



**PetroChina**

**“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК**

**БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭТ ТОСОН-УУЛ ХИХ ТАЛБАЙН  
ГАЗРЫН ТОС ОЛБОРЛОЛТЫН ТӨСӨЛ**

**ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ТОСОН-  
УУЛ ХИХ ТАЛБАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**Тосон-Уул**

**2023 он**

**ДОРНОД АЙМГИЙН МАТАД СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ ТОСОН-УУЛ ХИХ  
ТАЛБАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



/АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: 234

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:2075385/

**Хянасан:**

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч

/ /

**Биелэлтийг тайлагнасан:**

“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК-ИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БААЗЫН ДЭД ЗАХИРАЛ

СҮН ЯН ЖИ

“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК-ИЙН  
БХГ-Т ТОСОН-УУЛ ХИХ ТАЛБАЙН  
ЭМААБО-НЫ ХЭЛТСИЙН ДЭД МЕНЕЖЕР

Н.БАНЗРАГЧ

2023 он

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

**“ПЕТРОЧАЙНА ДАЧИН ТАМСАГ” ХХК-ИЙН БХГ-Т ХИХ ТАЛБАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

1.	ОЛБОРЛОЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
1.1.	Төслийн товч танилцуулга	8
1.2.	Орд ашиглалт, техник технологи	12
1.3.	Орд ашиглалтын олборлолт, бүтээн байгуулалтын мэдээлэл	22
2.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
2.1	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн тодорхойлолт	23
3	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	36
3.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	41
3.2	Усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл	41
3.3	Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	43
3.4	Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	46
3.5	Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл	50
4.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	52
4.1	Техникийн нөхөн сэргээлт	52
4.2	Биологийн нөхөн сэргээлт	54
5.	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	56
6.	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	73
7.	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	73
8.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	74
8.1	Аюултай бодис асгарах	75
8.2	Тос асгарах	76
8.3	Гал түймэр	77
8.4	Хяналтаас гадуурх дэлбэрэлт	78
8.5	Хүний эрүүл мэнд муудах	78

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

8.6	Зам тээврийн осол аваар гарах	78
9	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	79
9.1	Ахуйн хатуу хог хаягдал	80
9.2	Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал	80
9.3	Ахуйн шингэн хаягдал	82
9.4	Тосоор бохирдсон хөрс	83
10	ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	84
10.1	Агаар орчны мониторинг	84
10.2	Усны мониторинг	90
10.3	Хөрсний мониторинг	95
10.4	Ургамлын мониторинг	100
11	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	108
11.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах үүднээс байгаль орчны ажилтны бүтэц орон тоог нэмэгдүүлэх.	110
11.2	Аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах.	110
11.3	Гэрээлэгч ангиудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ.	110
11.4	Замын менежментийг сайжруулах.	111
11.5	ЭМААБО-ны хэлтсийн ажилтнуудыг чадвахжуулах сургалтанд хамруулах.	111
11.6	Үндсэн болон гэрээлэгч ангиудад байгаль орчны сургалт зохион байгуулах.	110
11.7	Химийн бодисын зарцуулалтын тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх.	112
11.8	Дорнод аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах ерөнхий төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллах.	113
11.9	Шинээр хэрэгжих төслүүдэд БОНБНУ хийлгэх.	113
12	НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД БОМТ-НИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	113
12.1	Дэлхийн усны өдөрт зориулан Буйр нуур Мэнэнгийн талын сав газартай хамтарсан ажил зохион байгуулах.	114

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

---

12.2	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл болоод 2024 оны БОМТ-г орон нутгийн иргэдэд танилцуулах.	115
12.3	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний явцыг орон нутгийн иргэдэд газар дээр нь танилцуулах.	115
12.4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон комист танилцуулан хийгдсэн ажлуудыг хүлээлгэн өгөх.	116
13	2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	117
14	2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ХУРААНГУЙ	118

### **Зургийн жагсаалт**

- Зураг № 1. БХГэрээт талбайн байршил
- Зураг № 2. Төслийн талбайн сансрын зураг
- Зураг № 3. Геологийн баталгаат нөөц болон ашиглалтын талбай.
- Зураг № 4. Олборлолтын үйл ажиллагааны бүдүүвч зураг.
- Зураг № 5. Өрөмдлөг хийж буй өрмийн цамхаг
- Зураг № 6. Тэсэлгээ хийх
- Зураг № 7. Үйлчилгээ хийх
- Зураг № 8. Олборлолтын тоног төхөөрөмжийн бүтэц
- Зураг № 9. Тос хадгалах савны бүтэц
- Зураг № 10. ТА-1 Байгууламжийн тос хадгалах сав (7000) тн)
- Зураг № 11. Газрын тосны тос, ус, хий ялгах олборлолтын нэгдсэн ил байгууламж
- Зураг № 12. Зам арчлалт хийж буй байдал
- Зураг № 13. Шинжилгээний хариу
- Зураг № 14. Ус ашиглах гэрээ, дүгнэлт, зөвшөөрөл
- Зураг № 15. Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжаас дээж авч буй нь
- Зураг № 16. Өрмийн шаврын хаягдлын сан байгуулж буй байдал
- Зураг № 17. Сургалтанд сууж буй жолооч нар
- Зураг № 18. Шинжилгээний хариу болон хөрсний дээж авч буй байдал
- Зураг № 19. Ашиглагдахгүй болсон замыг хаглаж бутлаж сийрүүлсэн байдал
- Зураг № 20. Галын сургалт
- Зураг № 21. Матад суманд модны суулгац хүлээлгэж өгсөн байдал.
- Зураг № 22. Тэрбум мод төслийн хүрээнд мод тарьж буй нь
- Зураг № 23. Сургалтанд сууж буй жолооч нар
- Зураг № 24. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй нь
- Зураг № 25. Өрмийн шингэн хаягдлын санд техникийн нөхөн сэргээлт хийж буй нь
- Зураг № 26. ҮШХСангийн нөхөн сэргээлт
- Зураг № 27. Биологийн нөхөн сэргээлт хийхээс өмнө
- Зураг № 28. Биологийн нөхөн сэргээлт хийсны дараа
- Зураг № 29. Биологийн нөхөн сэргээлт хийсэн зам
- Зураг № 30. 1000 ширхэг улиас мод суулгаж буй байдал
- Зураг № 31. Дүйцүүлэн хамгаалхад тохиромжтой талбайн байршил
- Зураг № 32. Хэт авианы шувуу үргээгч
- Зураг № 33. Нутгийн иргэдэд танилцуулга хийж буй нь
- Зураг № 34. Самбар байршуулж буй нь
- Зураг № 35. Идэвхтэн байгаль хамгаалагчид мотоцикл, дуран, байршил тогтоогч гардуулж буй нь
- Зураг № 36. Матад сумын төлөөлөгч нар
- Зураг № 37. Зэрлэг амьтдад бэлдсэг өвс тэжээл.
- Зураг № 38. Матад сумын засаг даргад галын багаж хэрэгсэл гардуулж буй нь
- Зураг № 39. Автомат камерт өртсөн цагаан зээрийн сүрэг.
- Зураг № 40. Зэрлэг амьтан барихад ашигладаг тор
- Зураг № 41. Цагаан зээрэнд хүзүүвч зүүж буй нь
- Зураг № 42. Дүйцүүлэн хамгаалах талбай 1-д тэмдэглэгдсэн дагуур зурам. 2023.07.01
- Зураг № 43. Бүс нутгийн үндсэн туруутан цагаан зээр. 2023.07.01
- Зураг № 44. Дүйцүүлэн хамгаалах талбайд тохиолдсон өвөгт тогоруу.2023.06.30
- Зураг № 45. Монгол гүрвэл нь тус нутгийн түгээмэл мөлхөгч. 2023.07.01

## **БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

---

- Зураг № 46. Та1 байгууламжийн химийн бодисын агуулахад аваарын худаг хийсэн байдал
- Зураг № 47. Гамшигаас хамгаалах төлөвлөгөө, химийн бодисын ослын төлөвлөгөө
- Зураг № 48. “Эко Ургамал” ХХК-н цэвэршүүлсэн шороо
- Зураг № 49. Гал түймрийн аюулаас сэргийлэх сургалт
- Зураг № 50. Галын багаж хэрэгсэл хүлээж авч буй байдал
- Зураг № 51. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт
- Зураг № 52. Хатуу хог хаягдлыг шийдвэрлэж буй байдал
- Зураг № 53. Аюултай хог хаягдлыг устгаж буй байдал
- Зураг № 54. Аюултай хог хаягдал хүлээлгэж өгсөн акт
- Зураг № 55. Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж
- Зураг № 56. Шинжилгээний хариу
- Зураг № 57. Тосоор бохирдсон шороог угааж буй нь
- Зураг № 58. Агаар орчны шинжилгээ хийж буй нь
- Зураг № 59. Агаарын мониторингийн цэгийн байршил
- Зураг № 60. Усны дээж авч буй нь
- Зураг № 61. Усны мониторингийн цэгүүдийн байршил
- Зураг № 62. Хөрсний дээж авч буй нь
- Зураг № 63. Хөрсний мониторинг цэгүүдийн байршил
- Зураг № 64. Хаврын мониторинг судалгаа /2023.06.28 – 07.02/
- Зураг № 65. Зуны мониторинг судалгаа /2023.08.10 – 08.17/
- Зураг № 66. Намрын мониторинг судалгаа /2023.09.24– 10.01/
- Зураг № 67. Ургамлын дээж авсан цэгүүд.
- Зураг № 68. Ургамлын бүрхэц
- Зураг № 69. Гэрээлэгч ангиудын мод тарьсан байдал
- Зураг № 70. Сертификат
- Зураг № 71. Усны өдөрлөг
- Зураг № 72. Матад сумын иргэдэд БОМТ танилцуулж буй нь
- Зураг № 73. Матад сумын хүүхдүүд
- Зураг № 74. Матад сумын төлөөлөл мониторинг хийх ажилд хяналт тавьж буй нь

### **Хүснэгтийн жагсаалт**

- Хүснэгт 1. Компани талаарх мэдээлэл
- Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн жагсаалт
- Хүснэгт 3. 2023 онд орд ашиглалтын хүрээнд хийгдэх ажлууд
- Хүснэгт 4. Тосон-Уул ХИХ талбайгаас 2023 онд олборлох тосны хэмжээ (тн)
- Хүснэгт 5. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа
- Хүснэгт 6. Гол нөлөөллийн дүн шинжилгээ
- Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал
- Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
- Хүснэгт 9. Албан тоот
- Хүснэгт 10. Ахуйн бохир байгууламжинд буулгасан шингэний хэмжээ
- Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
- Хүснэгт 13 19-р талбай автомат камер байршуулсан цэгийн координат
- Хүснэгт 14. Осол, эрсдэлийн төлөвлөгөөний хураангуй
- Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хураангуй
- Хүснэгт 16. 2021-2023 оны нийт тоосонцорын агууламж
- Хүснэгт 17. 2023 оны усны ерөнхий хими-физикийн шинжилгээний үр дүн
- Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хураангуй
- Хүснэгт 19. Нөлөөллий бүсийн оршин суугчдад БОМТ танилцуулах төлөвлөгөөний хураангуй
- Хүснэгт 20. БОМТ Нэгдсэн төсөв
- Хүснэгт 21. БОМТ Хураангуй

### **Графикын жагсаалт**

- График 1. Дуу шуугианы хэмжилт
- График 2. Дуу шуугианы үзүүлэлт
- График 3. 2021-2023 оны дуу шуугианы хэмжилтийн дүн, дБа
- График 4. 2021-2023 оны нийт тоосонцорын агууламж
- График 5. Ургамлын бүрхцийг 3 улирлаар харьцуулсан дүн /2023 он/
- График 6. Сүүлийн 4 жилийн харьцуулалт
- График 7. Сүүлийн 4 жилийн бүрхцийг харьцуулсан үр дүн




# БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

## НЭГ. ОЛБОРЛОЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг захиргааны харъяалал  
Төслийн харъяалалын байршил: Петровичайна дачин тамсаг ХХК-ийн БХГэрээт Тосон-Уул ХИХ талбайн нь Дорнод аймгийн Матад сумын 4 болон 6-р багийн нутагт Чойбалсан хотоос 220 км, Матад сумаас 80 км зайд оршдог.



Зураг № 1. БХГэрээт талбайн байршил

2. Төсөл хэрэгжүүлэгчийн аж ахуйн нэгжийн мэдээлэл

Хүснэгт 1. Компанийн талаарх мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Компанийн хаяг, байршил
“Петровичайна дачин тамсаг” ХХК	9019006066	Газрын тосны хайгуул хийх, олборлох, боловсруулах,	Баянзүрх дүүрэг, Их тойруу Доржийн гудамж 14-р байр

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

		экспорт, импортын үйл ажиллагаа эрхлэх	
--	--	---	--

3. Төслийн үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрлийн жагсаалт

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн жагсаалт

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	234
2	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл	0001243
3	Дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	03/2019
4	Цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	04/2019


4. ТӨСЛИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

“Дачин Ойл Фийлд Лимитед” компани нь 2005 оны 8-р сард Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Тамсагийн сав газрын XIX, XXI, XXII гэрээт талбайд газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт болон экспортын үйл ажиллагаа явуулах БХГ-ний эрх үүргийг Их Британи улсын Лондон хотод төвтэй, Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “СОКО ИНТЕРНЕЙШНЛ ЛЛС”-ийн охин компани “СОКО тамсаг монгол”ХХК-ийн эзэмшил хувьцааг худалдан авч эрх үүргийг шилжүүлэх хүлээн авах тухай гурван талын гэрээнд “СОКО тамсаг монгол”ХХК-ийн охин компани “СОКО Тамсаг Монгол”ХХК-ийн эзэмшил хувьцааг худалдан авч, эрх үүргийг шилжүүлэх хүлээн авах тухай гурван талын гэрээнд “СОКО ИНТЕРНЕЙШНЛ ЛЛС”, “Дачин Ойл Фийлд Лимитед” компани, Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж АМГТГХЭГазар гарын үсэг зурснаар өөрийн салбар компани болох “Петрочайна Дачин Тамсаг”ХХК-ийг АНУ-ын Делавере болон Монгол Улсад бүртгүүлж байгуулсан. Монгол Улсын ЭБЭХЯ-ны 2009.06.05-ны өдрийн 56 тоот “Тусгай зөвшөөрөл”-өөр Дорнод аймгийн Матад сумын Тамсагийн сав газарт газрын тостой холбогдох үйл ажиллагааг явуулж байна. “Петрочайна Дачин Тамсаг”ХХК нь Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 1996 оны 8 тоот зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 1996.08.09-ний өдрийн 183 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 1996.08.09-ний өдрийн 144 тоот тогтоолоор тус тус батламжилсан БХГэрээний дагуу МУ-ын ЗГ-ын 2012.12.01-ны өдрийн хуралдаанаар батлагдсан №154 тоот БХГ-ХИХ, XXI талбайг “Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахад зориулан уурхайн эдэлбэрийн зөвшөөрөл олгох тухай” тогтоолуудыг үндэслэн Монгол Улсын Уул Уурхайн Сайдын 2016 оны 05-р сарын 31 ний өдрийн А/61 дугаар тушаалыг үндэслэн олгосон 2016 оны 6 сарын 10 ны өдрийн Аж ахуйн үйл ажиллагааны 234 тоот тусгай

## БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

зөвшөөрөлтэйгээр Дорнод аймгийн Матад, Халхгол сумын нутаг дэвсгэрт байршилтай БХГ-т XIX, XXI талбайд газрын тостой холбогдох үйл ажиллагаа явуулж байна.


### ОРД АШИГЛАЛТЫН ТАЛБАЙН САНСРЫН ЗУРАГЛАЛ



Зураг № 2. Төслийн талбайн сансрын зураг

Тус талбайд геологийн баталгаат нөөцийг 178.85 сая тонн, ашиглалтын баталгаат нөөцийг 20.12 сая тонноор тогтоож, үйлдвэрлэлийн олборлолтод шилжүүлээд байгаа бөгөөд нийт 670 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Тус талбайн геологийн баталгаат нөөц нь 179 сая тонн бөгөөд МУ-засгийн газраас баталсан ашиглалтын талбайн нийт хэмжээ 650 км болоод байна.

**Геологийн баталгаат нөөц болон ашиглалтын талбай**



Зураг № 3. Геологийн баталгаат нөөц болон ашиглалтын талбай.

Тосон-Уул XIX талбай нь олборлолтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахаас гадна олборлолтыг нэмэгдүүлэхээр өрөмдлөг, цементаци, каротаж, перфораци, шингэн хагалбар, цооног үйлчилгээний дараах хэмжээний ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.


**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ, ХАДГАЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЯВЦ			
1. ОЛБОРЛОЛТ	2. ХАДГАЛАЛТ	3. ТЭЭВЭРЛЭЛТ	4. БОРЛУУЛАЛТ
			
<p>Петро Чайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон-Уул XIX талбайд тос олборлолтын 480, ус шахалтын 211 цооног ажиллаж байна.</p>	<p>ТА-1 байгууламжинд 398 цооног холбогдсон 7000 тн-ийн 3 танканд тосоо хадгалдаг бол 82 цооног уламжлалт буюу тос хураагуур бүхий 50 тн-ий танктайгаар олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.</p>	<p>Нэгдсэн байгууламж нь олборлосон газрын тосыг ус, тос, хийгээр ялгадаг. Ялгасан түүхий тосыг зориулалтын тээврийн хэрэгсэлд ачин тээвэрлэлтийг хийдэг.</p>	<p>Тээвэрлэсэн түүхий газрын тосоо Эрээн хотын Аршаантын дамжуулах хоолой хүртэл тээвэрлэн борлуулдаг.</p>

## 1.2. ОРД АШИГЛАЛТ, ТЕХНИК ТЕХНОЛОГИ

### 1.2.1. Цооног өрөмдлөгө, каратаж, тест, цементацын ажлууд

Газрын тос болон байгалийн хий нь газрын давхрага доор хэдэн зуун метрээс хэдэн мянган метрийн гүнд нүх, хагарал болон хад чулууны завсараар оршиж байдгыг хүсүүс хайж олборлохдоо газрын давхаргаас тос хий, орших давхрага хүртэл суваг өрөмдөхийг газрын тос байгалийн хийн цооног өрөмдөх гэнэ. Цооног өрөмдөхийн өмнө эхлээд өрөмдөх цооногийн байршлаа тодорхойлох, өрмийн цамхаг болон өрмөө угсарч босгоно. Цооног өрөмдөх ажил нь цахилгаан өрөм түүний толгойн эргэлтээр газрын давхрага руу хэд хэдэн удаа өрөмдсөнөөр цооногийн нүд гарна. Өрөмдөх цооногийн том багын хэмжээ нь өрмийн хошууны том багаас хамаардаг. Өрмийн толгой нь чулуун давхаргыг өрөмдөх үед өрмийн эх биеийг дагуулан газрын гүнруу өрмийн шингэн (өрмийн шавар) шахна. Ингэснээр өрмийн толгой газрын давхаргыг өрөмдөх явцад бутарсан их хэмжээний шороог өрмийн шингэн эргэлтийн явц дунд газрын гадарга дээр гаргана. Улмаар газрын гадаргын шороо болон бусал геохимийн дүн шинжилгээ хийх ажлыг каратаж хийх гэнэ. Цооног өрөмдөөд тодорхой гүнд хүрсний дараа цооногийн нүхрүү тусгай багаж хийу цооногийн тестийн ажил хийнэ. Цооногийн тестийн зорилго нь цооногийн давхаргийн чулуулгийн шинж болон тос, хий, усны байршилыг тогтооход оршино. (цооногт тест хийх гэнэ.). Тест хийсний дараа өрөмдсөн цооногийн нүдний диаметрээс бага хэмжээтэй ямар ч залгаасгүй ган хоолой суулгана. (үүнийг давхар хоолой гэнэ.). Давхар хоолой болон цооногийн ханын завсраар цемент шахаж давхар хоолойг цооногийн ханатай бэхэлж өгнө. (давхар хоолойг



Зураг № 4. Олборлолтын үйл ажиллагааны бүдүүвч зураг.

бэхэлж өгөх энэ ажлыг цооногийн цементац гэнэ). Ерөнхийдөө газрын тос байгалийн хийн цооног өрөмдөх гол зорилго нь илрүүлсэн тос хийн давхаргыг хамгаалж чулуулгын дундуур гаргасан


хоолойгоор газрын тос болон байгалийн хийг газрын гадарга дээр чөлөөтэй гаргах явдал юм. Цооног өрөмдөх ажил газрын тосны салбар дундаа маш чухал ажлын дараалалд ордог бөгөөд газрын тос, байгалийн хийг хайж олборлоход зайлшгүй хийгдэх ажил бөгөөд нэг төрлийн зардал



Зураг 5. Өрөмдлөг хийж буй өрмийн цамхаг

маш өндөртэй, техник технологи нь нарийн төвөгтэй, эрсдэл ихтэй нэгэн цогц систем бүхий ажиллагаа юм.

#### 1.2.2. Тэсэлгээ хийх:



Зураг № 6. Тэсэлгээ хийх

Давхар хоолойг тэсэлж цооногийн өрөмдлөгийн ажлыг дуусгах нь одоогийн байдлаар гадаад дотоодын улс оронд хамгийн түгээмэл ашигладаг арга юм. Үндсэн зарчим нь нэг цооногийг өрөмдөж, цементлэж дууссаны дараа тэслэгч ашиглан тостой давхрагын хэсгийн давхар хоолой, цементэн яндан болон тосны давхрагыг тодорхой гүнд тэслэж цоолосноор цооногийн хана болон газрын давхрага хооронд тос хийн урсах зам болж өгөх юм. Тэсэлгээ хийх нь ихэвчлэн цэвэр ус ашиглах бөгөөд ямар нэгэн нэмэлт бодис ашиглахгүй.

Байнга ашигладаг тэсэлгээний техник технологи:

Нэгдүгээрт: Цахилгаан кабель утсаар тэсэлгээний багажийг давхар хоолой дотор хүргэж буюу зорилтод давхрагын байршилд хүргэснээр тэсэлгээ хийгдэнэ. Үүнд давхар хоолойнд хонгиотой болон хонгиогүй

тэсэлгээ хийнэ.


Хоёрдугаарт: Тосны хоолойд тэсэлгээний багаж хүргэийг ТСП гэж товчлох ба налуу, хэвтээ, өндөр температур өндөр даралт, элсээр хамгаалсан цооног болон бага нэвчилттэй газрын давхрагат тэсэлгээ хийхэд ашиглана.

### 1.2.3. Хагалгаа хийх.

Тосон давхрагад усаар хагалгаа хийх явц нь газрын гадарга дээрх өндөр даралт бүхий насос ашиглаж өндөр зуурамхай шингэн газрын шингээх чадвараас хэд дахин илүү урсацаар цооногт шахахад цооногийн доод хэсэг орчим өндөр даралт хуримтлагдана. Харин насосны даралт цооногийн хана, чулуулгийн таталцалын эсэргүүцлийг давах үед газрын давхрагад хагарал үүснэ. Үргэлжлүүлэн (кварц элс эсвэл керамикийн) нэмэгдэлтэй хагалгааны шингэнийг хагарал руу шахсанаар хагарал нь урагшаа сунаж хагаралын завсараар дүүрэн нэмэгдэл болно. Үүний дараа насосоо зогсооход газрын доод давхаргад хангалттай урт мөн тодорхой өргөн, өндөртэй элсээр дүүрсэн хагарал үүссэн байна. Энэ хагарал томорсноор тос хийн урсац, газрын доод давхаргын шингээлт нэмэгдэж олборлолт, шахалтыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлдэг байна. Хагалгааны шингэн нь ихэвчлэн cross-linking agent болон өтгөрүүлэгчээс бүрддэггүй бөгөөд чанараа хадгалж, үзүүлэлтээ өндөрсгөхийн тулд хагалгааны шингэн рүү өөр олон төрлийн нэмэгдэл нэмнэ. Ихэвчлэн ашигладаг нэмэгдэл нь буферлэлт, ариутгагч тогтворжуулагч нунтаглагч цэвэрлэгч шаварлаг тогтворжуулагч болон шүүлтүүр бөглөрхөөс хамгаалагч зэрэг бодис ашигладаг.

### 1.2.4. Үйлчилгээ хийх

Цооногт үйлчилгээ хийх гэдэг нь цооног болон давхаргад чиглэсэн үйлчилгээ юм. Энэ нь гадарга дээрх тоног төхөөрөмж болон техникээр дамжин багаж хэрэгсэл ашиглан тухайн давхрага, цооногийн бүтэц тест хийсэн материалд тулгуурлан олборлолтын явцад үүссэн давхрага болон цооногийн эвдрэл гэмтэлийг засаж сэлбэж сэргээх явдал юм.



Зураг № 7. Үйлчилгээ хийх


Тухайн давхрагад үүссэн ямар нэгэн эвдрэл гэмтэлийг засаж залруулна. Мөн үнэн бодит бүрэн бүтэн геологийн материал хийх, нээж олборлох арга тодорхойлох хувиараар олборлож хувиараар шахах төлөвлөгөөг хэрэгжүүлсэнээр үр дүнтэй байх талаар шалгах тос усны цооногийн ашиглалтыг нэмэгдүүлэх мөн тосны орд болон тос усны цооногийн хэвийн аюулгүй ажиллах байдлыг хамгаалах олборлолтын боломжийг гаргах зэргийг хэрэгжүүлэх явдал юм. Цооногт үйлчилгээ хийхэд цооногт тест (formation testing) болон цооног засах гэсэн хоёр том төрөл байдаг.

1. Цооногт тест хийх: тест хийхдээ цооног угаах, даралтын тест хийх тэсэлгээ тос хий урсацыг нэмэгдүүлэх өдөөлт хийх зэрэг нэг цогц технологи ажиллагаа хийж үр дүнд хүрэх бөгөөд зорилга нь : 1) шинэ байршил тогтоох шинэ бүтэц нь технологийн холбогдолтой тосны урсац эсэхийг шалгах: 2) давхаргын тос хийн байдал болон тест хийсэн үр дүн хэр үнэн бодитой эсэхийг шалгах: 3) тос хийн давхраг болон тос хийн нөөцөнд үнэлгээ хийх.




2. Цооног засах: Энэ ажил нь ихэвчлэн тос хий усны цооног ашиглалтанд орсны дараа хийгддэг. Уг ажлын зорилго нь цооног болон давхаргад оршиж буй олборлолтонд нөлөөлөх гэмтлийг засах юм. Тэр дундаа давхаргын өөрчлөлт давхрага хоорондын холбоог зохицуулах багтана. Цооног засах ажил маш олог төрөл байдаг. Үүн дотор насос шалгах болон ус солих: жижиг завсрын үйлчилгээ жишээ нь хөнгөн задгай олборлох нүх бөглөх давхрага тавих зэрэг аргалах төдий үйлчилгээ хийх бага хэмжээний арга хэмжээ авах жишээ нь цахилгаанаар эргэлдүүлж олборлох насос дээш татах нийлүүлж эсвэл салгаж ус шахалтыг харилцан сольбох зэрэг том хэмжээний арга хэмжээ авах жишээ нь шингэн хагалгаа хийх хүчиллүүлэх элснээс хамгаалах хагалгааг тохируулах. Цооногт үйлчилгээ хийх явцад шингэн хагалгаа хийх хүчилжүүлэх болон бөглөө гаргах үйлчилгээнээс бусад үйлчилгээнд нэмэгдэл бодис ашиглахгүй.

### ОЛБОРЛОЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ



Зураг 8. Олборлолтын тоног төхөөрөмжийн бүтэц



Зураг 9. Тос хадгалах савны бүтэц

Тосон-Уул XIX талбайд одоогийн байдлаар ТА-1 нэгдсэн байгууламжинд холбогдсон 405, холбогдоогүй уламжлалт буюу танктай 85 тосны цооног ажиллаж байна. Эдгээр цооногууд нь бүгд жигд ажилладаггүй бөгөөд эвдрэл гэмтэл, хуваарийн дагуу зогссон гэх мэтээр харилцан адилгүй ажилладаг. ТА-1 нэгдсэн байгууламжинд холбогдсон цооногууд нь тухайн бүлэг ордын хэмжээнд хувиарлах буюу дахин дамжуулах байгууламжинд холбогддог бөгөөд хувиарлахууд нь цагирагуудаас тогтооно. Жишээ нь цөөн тооны 3-10 орчих цооногууд холбогдон 1 цагираг үүсгэнэ. Нэг хувиарлахад дунджаар 3-6 цагирагтай байдаг. Хувиарлах дэд станц нь цагирагууд руу 60-700С-ийн температуртай халуун холих усыг цагираг руу шахаж улмаар цооногуудаас олборлож буй тосыг тойроогоор цуглуулан буцаан тостой ус хувиарлах дээр ирж улмаар ТА-1 нэгдсэн байгууламжруу тостой усыг дамжуулна. Ус шахалтын хувиарлах дэд станцууд нь ТА-1 нэгдсэн байгууламжаас ирсэн технологийн шаардлага хангасан усыг шахалтын цооногууд руу (жишээ нь 4-5 тосны цооног дунд буюу ойролцоо байрлалтай байж улмаар эдгээр цооногийн даралтыг нэмэгдүүлэх зорилготой) шахдаг. Шахалтын цооногуудын гүний хэмжээ тосны цооногтой ойролцоо байдаг. Одоогийн байдлаар ус шахалтын 239 цооног байгаагаас өдөрт дунджаар 121 цооногт 6000м<sup>3</sup> усыг шахаж байна. Эдгээр шугам хоолойнууд нь (тос дамжуулах хоолой, холих усны хоолой, ус шахалтын шугам хоолой) 2 метр газрын гүнд зэрэгцээ 1 метрийн шуудуунд хийгдсэн болно. Ус шахалтанд ашиглаж буй усыг үйлдвэрлэл болон унд ахуйн зориулалтаар ашиглах 35 гүний худгаас олборлож байна. ТА-1 нэгдсэн байгууламж нь газрын тосонд агуулагдаж байсан хаягдал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглаж байгаа бөгөөд энэ нь ус шахалтанд хэрэглэж байгаа усны 30 гаруй хувийг эзлэж байна.

#### 1.2.5. 1-9 тос дамжуулах, ус шахах станцын танилцуулга

1-9 тос дамжуулж, ус шахах станц нь ТА-1 нэгдсэн байгууламжаас хойшоо 9.0 км-т, 19-19 цооногийн хэсгийн гол төвд оршдог 2012.08.13 ны өдөр барьж ашиглалтанд оруулсан. Төхөөрөмжийн дээд хязгээр нь 2500t/d шингэн цэвэршүүлэх чадалтай ба шингэн дамжуулах дээд хязгаар нь 39,1м<sup>3</sup>/цаг, хий ялгах хэмжээ нь 26021,2м<sup>2</sup>/өдөр. Тухайн станц нь 5 н хувиарлах байгууламж болон 9 цагирагтай 181 цооногийн түүхий тосны усыг ялгаж түүхий тос, байгалийн хийг дамжуулан ажилдаг. Одоогийн байдлаар цэвэршүүлж байгаа шингэн нь 3054 t/d , гадагш дамжуулж байгаа шингэн нь 41м<sup>3</sup>/d, ялгаж байгаа байгалийн хий нь 20693м<sup>3</sup>/d, гадагш дамжуулах насосны шугамын даралтын зөрүү нь 0.2Мра. Өдрийн гадагш дамжуулж байгаа түүхий тосны хэмжээ нь 980t/d, автомашинаар Та1-рүү зөөвөрлөж байгаа шингэний хэмжээ нь 300м<sup>3</sup>/d, гадагш дамжуулж байгаа байгалийн хий нь 12000м<sup>3</sup>/d.

Энэ станц нь тос дамжуулах, ус шахах гэсэн 2 том хэсгээс бүрдэнэ. Цахилгаан үүсгүүр нь хос цахилгаан үүсгүүр 10kv-ын шугамтай. Станц дотрох гол гол тоног төхөөрөмж нь ус тос ялгагч 2 ширхэг, ус холих зуух 3 ширхэг, дулааны зуух 2 ширхэг, байгалийн хийг тосноос ялгаж шатаах ком 1 ширхэг, гадагш тос дамжуулах насос 2 ширхэг, ус холих насос 3 ширхэг, дулааны ус

дамжуулах насос 3 ширхэг, 3 бүлүүрт насос 7 ширхэг. Одоогийн байдлаар хамгийн өндөр хүчин чадлаар ажиллах чадал нь 2500t/d шингэн, 20477м<sup>3</sup>/d байгалийн хий. Хамгийн их гадагш дамжуулах шингэний хэмжээ нь 1000t/d.

#### 1.2.6 Гүний ус цэвэршүүлж ус шахах байгууламж

Гүний ус цэвэршүүлж ус шахах байгууламж нь 2011 оны 10 сарын 29-нд туршилтаар ажиллуулж газрын гүний усыг цэвэршүүлэх хүчин чадал нь 4200м<sup>3</sup>/d. Анх баригдахдаа 2800м<sup>3</sup>/d хүчин чадалтайгаар байгуулагдсан. Усны чанар нь “8,3,2” стандарт, одоогийн байдлаар цэвэршүүлж байгаа ус нь 1754 м<sup>3</sup>/d, гадагш дамжуулж байгаа хэмжээ нь 1602 м<sup>3</sup>/d. Усны худгаас ирж байгаа усыг цэвэршүүлж хувиарлах руу дамжуулах үүрэгтэй. Нийтдээ 8 шүүлтүүр танктай, төрөл бүрийн насос 11 ширхэг, гал унтраагуур даралт нэмэж усаар хангах гэсэн тоног төхөөрөмжтэй. 1000м<sup>3</sup>-ын ус цэвэршүүлэх усны танк болон 200м<sup>3</sup>-ын ус буцаах танк тус бүр нэг нэг. Усны худгаас ирсэн ус нь эхлээд манганы элсэн шүүлтүүрээр дамжин нарийн шүүлтүүрт шүүгдэж стандартад нийцсэний дараа цэвэр усны танк руу орж ус шахалтын байгууламж болон станцын гаднах ус хуваарилах байгууламж руу дамжуулагдана. Ус шахалтын байгууламж нь 2011 оны 11 сарын 2 өдөр Та 1 ус шахах станц нэртэйгээр ашиглалтанд орсон. Зураг төслийн боловсруулсан хүчин чадал нь 1050м<sup>3</sup>/d, газрын гүн рүү шахах ус цэвэршүүлэх болон тостой ус цэвэршүүлэнэ. Насос ашиглахаас өмнө холих технологитой бөгөөд 3 бүлүүрт 8 насостой, одоогоор өдрийн цэвэр ус шахах нь 1220м<sup>3</sup>/d, бохир ус нь 500м<sup>3</sup>/d.

#### 1.2.7 Ачилт буулгалтын хэсэг

Ачилт буулгалтын хэсэг нь 2015 онд ашиглалтанд орсон. Зураг төслийн тохиргоогоор хамгийн дээд хүчин чадал нь 330t/d шингэн буулгах ба одоогийн байдлаар өдөрт 1300 м<sup>3</sup>/d шингэн буулгаж байна. 19-р талбайн танктай цооног, задгай олборлолт, бохир тос буцаан сорох, буулгах, хэмжих зэрэг ажлыг хариуцан ажиллаж байна. Энд ачилтын насос 3, буулгалтын насос 2, ачилтын цорго 10, 50 м<sup>3</sup> тос буулгах танк болон 100 м<sup>3</sup>-ын бохир тос буцаан хүлээн авах танк нэг нэг ширхэг, өдрийн ачих тосны дундаж хэмжээ нь 2300 t/d, өдрийн дундаж ачилтын машины тоо 80 автоцистерн. Буулгалтын нэг насосны урсгалтын хэмжээ нь 60м<sup>3</sup>/h танкнаар зөөж буулгаж байгаа шингэн (300 тн) мөн бохир тос, задгай олборлолт 120 тн), 1-9 дамжуулах станцаас ирж байгаа шингэн тос буулгах танк нь 19-р талбайн танктай цооногийн ирсэн тосыг хүлээн авч буулгах ба өдрийн дундаж буулгалтын машины тоо нь 50 гаруй байна.

#### 1.2.8 Та-1 олборлолтын нэгдсэн ил байгууламжийн шингэн цэвэршүүлэх хэсэг

Та-1 олборлолтын нэгдсэн ил байгууламжийн шингэн цэвэршүүлэх хамгийн өндөр хүчин чадал нь 4900t/d, тос цэвэршүүлэх нь 1820t/d, байгалийн хий  $3,9 \times 10^4$ м<sup>3</sup>/d, тостой ус 2400м<sup>3</sup>/d, цэвэр ус 4200м<sup>3</sup>/d. Энэ байгууламж нь түүхий тосноос усыг салгах, түүхий тосны дээж үзэх лаборатор, газрын гүний ус цэвэршүүлэх, тостой ус цэвэршүүлэх, ус шахах, ачилтын хэсэг, түүхий тос буцаан сорох, буулгалт, 110 киловаттын дэд станц, хийн генераторын хэсэг болон хагалгааны

шингэн цэвэршүүлэх гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Мөн 1200 kw дезиль хөдөлгүүрийн хэсэг, гал унтраах тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон.

#### 1.2.8.1 Тос дамжуулж ус ялгах хэсэг

Тос дамжуулж ус ялгах хэсэг нь 2011 оны 11 сард ашиглалтанд орсон. Ус ялгах хэсгийн бүрэн хүчин чадал нь 4900t/d: тос цэвэршүүлэх хамгийн өндөр хүчин чадал нь 1820t/d, хий цэвэршүүлэх хамгийн өндөр чадал нь  $3.9 \times 10^4(\text{sc})\text{m}^3/\text{d}$ . Бодит цэвэршүүлэх шингэний хэмжээ нь 4580м<sup>3</sup>/d, цэвэршүүлэх тос нь 2300t/d, байгалийн хий  $3,75 \times 10^4\text{m}^3/\text{d}$ . Тосноос усыг ялгасны дараах тосонд агуулагдах дундаж усны хэмжээ нь 0.15%, ачилтын тосонд агуулагдах усны хэмжээ 0.12%, дундаж ачилт нь 76/d. Станц дотор гурван фазын сеператор гурван ширхэг, халаагч зуух найм, 7000м<sup>3</sup> тос хадгалах сав гурав, 1000м<sup>3</sup> бохир ус тунгаах танк нэг ширхэг, 1000м<sup>3</sup> тос буулгах танк нэг ширхэг, төрөл бүрийн насос 28 ширхэг, химийн бодисоор ус ялгах технологи нь 19-р талбайн хувиарлахууд, тос дамжуулах станц, задгай олборлолт, танктай цооногоос ирсэн тос шингэнүүдийг тос, хий, ус гурван төлвөөр ялгаж тос нь 7000м<sup>3</sup> тос хадгалах сав руу орж тостой ус нь тунгаагуур савруу орж хоёрдохоо тунгаагдаж, тунгаасны дараа тос нь хоёр 7000м<sup>3</sup> тос хадгалах сав руу орж хадгалах савнаас машинд ачиж гадагш экспортлогдоно. Байгалийн хий нь тосноос ялгагдаж хатаагчаар дамжсаны дараа шууд станц дотрох халаагч зуух болон шатах хийн генераторт хэрэглэж байна. Ялгаж гарсан тостой усаа тостой усны танканд тунгаасны дараа нэг хэсгийг нь бохир ус цэвэрлэх хэсэгт цэвэрлэж нөгөө хэсгийг нь тосны цооногийн холих усанд ашиглана.

#### 1.2.8.2 Бохир ус цэвэрлэх хэсэг

2011 оны 11 сард ашиглалтанд орсон. Тостой бохир ус цэвэрлэх байгууламж нь 2400м<sup>3</sup>/d шингэн цэвэршүүлэх хүчин чадалтай бөгөөд одоогийн байдлаар өдрийн дундаж бохир ус цэвэршүүлэлтийн хэмжээ нь 760м<sup>3</sup>/d, бохир ус гадагш дамжуулалт нь 496м<sup>3</sup>/d, усаа 100% буцааж шахаж ашигладаг. Энэ байгууламж нь тос агуулсан усыг гүн гүнзгий цэвэршүүлж гадагш дамжуулах мөн станц доторх шахалтын хэсэг болон хувиарлах руу дахин шахдаг. Станц дотор тосны зөөлрүүлж тогтворжуулагч танк хоёр, SSF(хөвөгч бохир лаг цэвэрлэгч) төхөөрөмж хоёр, ус цэвэршүүлэгч танк болон лаг нягтруулах танк тус бүр нэг нэг, бодис нэмэх төхөөрөмж 8 ком, төрөл бүрийн насос 11 ширхэг бий. Бохир усруу бодис нэмсний дараа тос ялгах тунгааруур танк руу дамжуулж тосыг ялгасны дараа төхөөрөмж рүү орж хөвөгч эдийг ялгасны дараа ус цэвэрлэгч танк руу орж дахин гадагш дамжуулах насос руу дамжуулагдах болон хувиарлах байгууламж руу шахна. Гарч ирсэн түүхий тос болон ус нь ус цэвэршүүлэх хэсэг рүү цэвэршүүлэгдэж түүнээс гарсан лаг нь лаг нягтруулах хэсэг рүү явж лагийг нягтруулсныхаа дараа гадагш тээвэрлэгдэнэ.

#### 1.2.9. Хадгалалт

Тосон-Уул XIX талбайд олборлосон түүхий газрын тосыг олборлолтын ил байгууламж болох ТА-1 байгууламжинд 7000 тн-ий 3 танканд хадгалдаг бол нэгдсэн байгууламжинд холбогдоогүй цооногууд нь (Холбогдоогүй 85 цооногтой) хажуудаа 50 тн-ий тос хадгалах сав хураагууртайгаар хадгалалтын үйл ажиллагааг ханган ажилладаг.



Зураг 10. ТА-1 Байгууламжийн тос хадгалах сав (7000) тн)

Хадгалах савны 3 хэсэг :

- о 3ш-7000 м3
- о 3ш-1000 м3
- о 2ш-1500 м3
- о 1ш-500 м3 багтаамж бүхий хадгалах савнууд тус тус байна.

Зуухны хэсэг:

- о бш -Тос халаах зуух
- о бш -Халаах зуух
- о 3 ш тос, ус, хий ялгах төхөөрөмж байна.



Зураг 11. Газрын тосны тос, ус, хий ялгах олборлолтын нэгдсэн ил байгууламж

Энэхүү байгууламж нь гадаад талдаа нийт 5 тос цуглуулан дамжуулах дэд станц, 6 ш ус хувиарлах станц, 2 хувиарлан шахах байгууламжтай бөгөөд одоогийн байдлаар 405 ширхэг газрын тосны олборлолтын цооног, 196 ширхэг усны цооногуудтай холбогдсон. Тосны олборлолтын цооногуудаас тос цуглуулан дамжуулах нийт шугам хоолойн урт 113.68 км бөгөөд үүнээс тосны цооногоос тос цуглуулах цагираг шугам хоолойн урт 69.395 км, тос цуглуулах байгууламж хоорондын шугам хоолойн урт 19.33 км, ус холих станц байгууламж хоорондын шугам хоолойн урт 24.94 км тус тус байна. Ус шахалтын шугам хоолойн нийт урт 55.8 км бөгөөд үүнээс усны цооногийн шугам хоолой 31.895 км, байгууламж хоорондын шугам хоолойн урт 23.91 км тус тус байна. Тамсагийн олборлолтын нэгдсэн ил байгууламжинд ус ялгах станц, усны чанар сайжруулах станц, бохир ус цэвэршүүлэх станц, ус шахалтын станц, цахилгааны дэд станц, шатамхай хий ашиглан эрчим хүч түгээх станц, галын хамгааллын байгууламж, тос буулгах цэг, тос ачилтын талбай гэсэн хэсэгүүд багтдаг. Газрын тосны ус тос хийг ялгах хүчин чадлын дээд хэмжээ хязгаар нь 66.1Ч104 т/а.

Олборлолтын цооногуудаас тосыг дан болон давхар хоолойгоор халуун ус холих аргаар цуглуулна. Харин шинээр ашиглалтад орсон цооногуудын олборлолтын эхний үе шатанд түүнчлэн алсмагдмал зарим цооногуудаас олборлосон тосыг автомашинаар тээвэрлэн зөөж байна. Олборлолтын цооногуудыг холбосон шугам хоолойн сүлжээнд тос цуглуулах ба ус хуваарилах 9 дэд станц, ус шахалтын 1 станц ажиллаж байна. Олборлолтын цооногоор олборлосон шингэн ойролцоох тос цуглуулах дэд станцаар дамжин олборлолтын нэгдсэн байгууламж руу шахагдана. Олборлолтын нэгдсэн байгууламжаас шахагдсан ус нь хуваарилах дэд станцууд болон шахалтын станцаар дамжин шахалтын цооногоор газрын гүний давхарга уруу шахагдана. Тос цуглуулах ба ус хуваарилах дэд станцууд нь бүгд хоорондоо холбоотой байна. Олборлолтын цооног бүрийн технологийн үзүүлэлтүүдийг автоматаар хянах бололцоотой. Тос цуглуулах ба ус хуваарилах шугам сүлжээний зохион байгуулалт, дэд станцуудын байршлыг тогтоохдоо олборлолтын цооногуудын амсрын (толгойн) даралтыг бүрэн дүүрэн ашиглах, ингэснээрээ эрчим хүч хэмнэх нөхцөл хангагдана.

Ус холих шугам хоолойг тос цуглуулах ба ус шахах хоолойтой нэг сувагт байрлуулснаар газар шорооны ажлыг хамгийн бага хэмжээнд хийж, хөрсний температурыг хадгалах, шугам хоолойн дулааны алдагдлыг багасгах ач холбогдолтой. Мөн дэд станцуудын шугам хоолойг хооронд нь цуваа холбосноор дулааны нөхцөл сайжирч холих усны тоо хэмжээ багасах ба тос цуглуулах ерөнхий системийн радиус багасаж үйл ажиллагааны зардал буурна.

Газрын тосыг ус, хийнээс ялгах ерөнхий технологи:

Усгүйжүүлэх станцаар боловсруулах шингэний хамгийн дээд хэмжээ 4900 т/д байна. Цэвэр тосны гарцын дээд хэмжээ нь 5.28x10<sup>4</sup> (sc) м<sup>3</sup>/д байна.

Түүхий тосыг 2 үе шаттайгаар усгүйжүүлнэ. Үүнд:

1 - р шат: 3 фазын сеператор

2 - р шат: Саванд тунгаах

Энэ технологи нь үр дүн тогтвортой, эрчим хүч бага хэрэглэдэг, удирдлага хяналт сайтай, энгийн хялбар арга юм. Цооногийн шингэн нам температурын 3 фазын дегидраторт (усгүйжүүлэх төхөөрөмж) орж тос, ус, хий ялгагдана. Ялгасан тосоо 60 минут орчим тунгаагаад дараа нь халаах зууханд 600 С температур хүртэл халаана.

Халаасны дараа 2-4 өдөр босоо саванд тунгаагаад автомашинд ачихад бэлэн болно.

Сеператороос гарсан хийг хийн генераторын түлшинд хэрэглэдэг бөгөөд энэ нь байгаль орчны бохирдлоос сэргийлсэн арга хэмжээ юм.

Ус цэвэршүүлэх үйл ажиллагаа:

Ус цэвэршүүлэх процесс нь дараах зарчмаар явагдана. Үүнд:

Усны худаг → усыг хийжүүлэх → марганцтай элсэн шүүр → нарийн цэвэрлэгээний шүүр → цэвэр ус хураах сав → (исэлдэлт идэвхигүйжүүлэх хольц 30мг/л тунгаар тасралтгүй нэмнэ, бактери, ариутгагч хольц 100мг/л тунгаар 6- 8 цагаар 5 өдрийн давтамжтайгаар нэмнэ) → Ус хувиарлах дэд станц

Ус цэвэршүүлэх байгууламж нь 2 үе шаттайгаар баригдсан.

о 1 дүгээр үе шат 2800 м<sup>3</sup>/хоног

о 2 дугаар үе шат 4200 м<sup>3</sup>/хоног

Ус шахалтын үйл ажиллагаа:

Тост давхарга руу шахах технологийн хэрэглээний усыг дараах стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн байна. Олборлолтын нэгдсэн байгууламжийн шахуургын станцаас шахалтын станц болон ус хуваарилах дэд станцууд руу ус дамжуулах хоолой нь спирал гагнаастай, D 159 x 6 ган яндан байна. Хоолойн усны зарцуулга 31.67 м<sup>3</sup>/цаг ба тооцооны даралт 1.6 мПа. Шугам хоолойг газрын гүнд 3 метрт суулгасан. Шахалтын станц болон хуваарилах дэд станцуудаас шахалтын цооногууд руу өндөр даралттай ус шахагдана. Шахалтын станцын тооцооны даралт 14 мПа бөгөөд бүтээл нь 760 м<sup>3</sup>/хоног байна. Үүнээс гадна ус шахалтын үйл ажиллагааны усан хангамжинд 32 усны худаг ашиглагддаг. Ус шахалтын 1 цооногт амсрын даралт 14.1 мПа, бүтээл 24.7-33.6 м<sup>3</sup>/хоног байхаар тооцоолдог. Шахалтын цооногийн шугам хоолойн сүлжээнд тооцооны даралт 16 мПа байна.

1.2.10 Нэгдсэн байгууламжийн зам талбайн хийц:

Байгууламжийн зам талбай бүгд төмөр бетон, гол зам нь 6 метр өргөнтэй, туслах замууд 4 метрийн өргөн, нийт зорчих урт нь 2200 метр. Байгууламж нийт 5 хаалгатай, төв орох хаалга нь гол замтай холбоотой.

Барилгын хийц

- Олборлолтын нэгдсэн байгууламжийн үйлдвэрийн барилгууд бүгд тоосгон болон бетон хийцтэй.

- 7000 м<sup>3</sup>, 1000 м<sup>3</sup>-ийн ган савууд төмөр арматур бүхий бетон хийцтэй.

## **БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

- Галын хяналтын далан нь төмөр бетон хийцтэй.
  - Шингэн хаягдлын сан, ууршуулах далан бүгд ус үл нэвчүүлэх бетон хийцтэй.
- Сеператороос ялгарсан усыг ус халаах зууханд 70 С температур хүртэл халааж шахуургаар ус хуваарилах дэд станц руу шахна. Харин тос тунгаах саванд тунасан усыг шахуургаар ус тунгаах сав руу шахах ба энд 1-5 өдөр тунгаагдаад хаягдал ус нь ус боловсруулах хэсэг үрүү шахагдана.

### 1.2.11 Тээвэрлэлт

Тосон-Уул XIX талбайгаас олборлосон тосны экспортын тээвэрлэлтийг туслан гүйцэтгэгч 3 компани Тосон Уул – Бичигт чиглэлийн замаар хийж гүйцэтгэдэг. Өдөрт дунджаар 30 орчим тээврийн хэрэгсэлээр (20-25 тн-ий даацтай) 750 гаруй тн түүхий тос тээвэрлэж байна.

### 1.3. ОРД АШИГЛАЛТЫН ОЛБОРЛОЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 3. 2023 онд орд ашиглалтын хүрээнд хийгдэх ажлууд

№	АЖЛЫН ХӨТӨЛБӨР	ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ХЭМЖЭЭ	ТӨЛӨВЛӨГӨӨТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ
1.	Өрөмдлөг	2	2
2.	Цементаци	7	5
3.	Каротаж	7	5
4.	Перфораци	10	10
5.	Шингэн хагалбар	9	9
6.	Цооногийн үйлчилгээ	79	79
7.	Шинээр цооног ашиглалтанд оруулах	3	3

Хүснэгт 4. Тосон-Уул XIX талбайгаас 2023 онд олборлох тосны хэмжээ (баррель)

Цооногийн тоо	Ажиллах хоног	Эхлэх огноо	Нийт олборлох тос (тн)	Нийт олборлосон тос (тн) 2023.11.01-ны өдрийн байдлаар
488	0-365	2023.1.1- 2023.12.31	270,000	208,749.1

Тосон-Уул XIX талбайн 488 цооногт олборлолтын тоног төхөөрөмж суурилуулснаас хоногт дунджаар 457 цооногоор 337 тонн газрын тос олборлож түүхий тосыг Дорнод аймгийн Халхгол сумын Баянхошууны боомтоор БНХАУ-д экспортолж байна.



**ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

**1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Тосон-Уул XIX талбайн газрын тос олборлох төслийн БОНБНУ-ээр төслийн гол ба болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 5. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Сөрөг нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
Нэг. Олборлолтын үйл ажиллагааны явцад				
Өрөмдлөг	Геологийн тогтоц, газрын хөрс, ургамал, амьтан, ус, агаар	Олборлолтын талбай	Их	Төсөл хэрэгжих хугацаанд
Ус шахалт	Гүний ус	Олборлолтын талбай (нөөц хомсдох)	Их	Орд ашиглалтын хугацаанд
Олборлолт	Агаар, хөрс	Олборлолтын талбай	Дунд	Орд ашиглалтын хугацаанд
Тээвэрлэлт	Агаар, хөрс, хүн, амьтан, ургамал	Тээвэрлэлтийн зам түүний ойр орчим	Дунд	Орд ашиглалтын хугацаанд
Хоёр. Бүтээн байгуулалтын явцад				
Өндөр хүчдэлийн шугам байгуулах	Газрын хөрс, амьтан	Олборлолтын талбай	Дунд	Орд ашиглалтын хугацаанд
Далд шугам хоолой байгуулах	Геологийн тогтоц, газрын хөрс, ургамал, амьтан, агаар	Олборлолтын талбай	Их	Төсөл хэрэгжих хугацаанд

Хүснэгт 6. Гол нөлөөллийн дүн шинжилгээ

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

Нөлөөллийн ангилал	Гол нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн үргэлжлэх хугацаа
1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>Технологийн алдаа гарсан тохиодолд цооногийн толгойноос мөн тос дамжуулах шугам хоолой цоорсон тохиолдолд тос алдаж хөрсийг бохирддог.</li> </ul>	<p>1 цооног өрөмдөхөд 10м*20м*3м хэмжээтэй сан байгуулж 600 м3 өрмийн шлам үүсдэг ба 2023 онд 1 цооног өрөмдсөн.</p>	Хөрс бохирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Орд ашиглалтын хугацаанд
• Бохирдуулах		1 цооног өрөмдөхөд 0,02 га газар эвдэгддэг.	Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
• Эвдэх	<ul style="list-style-type: none"> <li>Газрын хэвлий эвдэх нөлөөлөлд цооног өрөмдөх, өрмийн шаврын сан байгуулах, өндөр хүчдэлийн шугам барих, далд шугам хоолой байгуулах ажлууд хамаарагдаж байна.</li> </ul>	1 цооног өрөмдөхөд өрмийн анги 0,6 га газарт түр байрлан хөрсийг богино хугацаанд доройтуулдаг.	Хөрс доройтуулах нөлөөллийн эрчим дунд зэрэг эрчимтэй байна.	Орд ашиглалтын хугацаанд
• Доройтуулах	<ul style="list-style-type: none"> <li>Доройтуулах нөлөөлөлд өрөмдлөг явуулах, газрын тосны олборлолт явуулах, тосны тээвэрлэлтийн ажлууд тус тус хамаарагдаж байна.</li> </ul>	Тосон Уул XIX талбайд 490 цооног хуваарийн дагуу ажиллаж байгаа бөгөөд 1 цооногын талбай 35м*35м буюу 0,122 га гэж үзвэл нийтдээ 60,02 га газар үйл ажиллагаанд өртөн доройтсон		

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

		байна. Тээвэрлэлтийг Тосон Уул – Бичигт чиглэлийн 140 км болон Тосон Уул- Баянхошуу чиглэлийн 210 км замаар хийж гүйцэтгэдэг.		
2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Нөөцийг бууруулах	БХГэрээт Тосон-Уул XIX талбайд гадаргын ус хомс болно. Олборлолтын үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл байхгүй. Харин олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор гүний ус болоод цэвэршүүлсэн усыг эргүүлэн газрын гүнд шахаж хэрэглэдэг.	2023.11.20-ны өдрийн байдлаар БХГэрээт Тосон-Уул XIX талбай нь 1.127.714 м3 усыг газрын гүнээс олборлон ашиглаж усны нөөцийг бууруулсан байна.	Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн эрчим их байна.	Орд ашиглалтын хугацаанд
3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл • Амьдрах орчинг хуваах	БХГэрээт талбайн амьтаны аймагт өрөмдлөг, олборлолт, тээвэрлэлт, өндөр хүчдэлийн шугам сүлжээ барих ашиглах, далд шугам хоолой байгуулах, зам барих ажлууд нь тэдгээрийн	БХГэрээт Тосон-Уул XIX талбайн зөвшөөрөгдсөн уурхайн эдэлбэр газрын хэмжээ (650 км <sup>2</sup> )	Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Орд ашиглалтын хугацаанд

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

<ul style="list-style-type: none"> <li>Амьдрах орчинг доройтуулах</li> <li>Амьдрах орчинг хомсдуулах</li> <li>Нөөцийг бууруулах</li> </ul>	<p>амьдрах орчныг хуваах, доройтуулах, хомсдуулах</p> <p>нөлөөллийг үзүүлж байна.</p> <p>Ургамлын аймагт өрөмдлөг, тээвэрлэлт, далд шугам байгуулах, зам барих ажлууд нь түүний амьдрах орчинг доройтуулах, хомсдуулах нөлөөллийг үзүүлж байна.</p>			
<p>4. Агаарт үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> <li>Бохирдуулах</li> <li>Тоос</li> </ul>	<p>Өрөмдлөгийн үеийн дуу чимээ, олборлолтын цооногийн илүүдэл хий болон ТА-1 байгууламжаас уурших хий, шатаасан хийн угаар нь агаарыг бохирдуулж түүний чанарыг доройтуулдаг. Тээвэрлэлт, өндөр хүчдэлийн шон босгох, далд шугам хоолой барих, замын барилгын ажил нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг.</p>	<p>БХГэрээт Тосон-Уул XIX талбайн зөвшөөрөгдсөн уурхайн эдэлбэр газрын хэмжээ (650 км<sup>2</sup>)</p>	<p>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй байна.</p>	<p>Орд ашиглалтын хугацаанд</p>
<p>5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс</p> <ul style="list-style-type: none"> <li>Хамгаалах</li> </ul>	<p>БХГэрээт Тосон-Уул XIX талбайд 2010, 2011 онд Шинжлэх ухааны академийн</p>	<p align="center">-</p>	<p align="center">-</p>	<p align="center">-</p>

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

• Нүүлгэн шилжүүлэх	Архелогийн хүрээлэнгээр 2 удаа архелогийн хайгуул судалгааны ажил хийлгэсэн бөгөөд уг судалгаагаар ашиглалтын талбайд архелогийн олдвор олноогүй болно.			
---------------------	---	--	--	--

Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг	Хүчтэй нөлөөлөх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
<b>1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт</b>											
1	Газрын доорхи урсацын өөрчлөлт										
2	Газрын доорхи усны чанарын өөрчлөлт		-			-		-		-	
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт										
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	-				-	-		-		
5	Геологийн тогтоцын өөрчлөлт										
6	Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт										
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
<b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>											
8	Газрын гадаргын нөөц баялаг	-									

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

9	Бэлчээр, тэжээлийн байдал	-									
10	Эрдэс түүхий эд, нөөц		-								
11	Эрчим хүчний нөөц		-								
<b>3. Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
12	Ундны усны чанар өөрчлөгдөх		-	-		-	-			-	
13	Ундны усны нөөц хомсдох		-		-			-		-	
14	Агаарын бохирдол	-		-	-		-		-		
15	Хөрсний бохирдол	-				-		-			-
16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		-			-	-				-
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	-		-	-		-		-		
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор</b>											
18	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх										
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		-								
20	Тусгай хамгаалалттай газар, нутагт нөлөөлөх										
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
22	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх		-								
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>											
23	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	
24	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх										

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

2 5	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	+				+		+		+	
2 6	Хүн амын тоо өөрчлөгдөх										
<b>6. Эдийн засаг, байгаль орчин</b>											
2 7	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+		+		+		+	
2 8	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+
2 9	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+		+	+		
3 0	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
3 1	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+		+		
3 2	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		-		-		-			-	
<b>7. Бусад нөлөөлөл</b>											
3 3	Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-	-			-	
3 4	Ахуйн бохир ус, нефьтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах.		-			-	-				-
3 5	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих		-		-		-		-		
3 6	Хүчтэй салхи, тоосжилт	-			-				-		
<b>Нөлөөллийн тоо ширхэг</b>		8	11	3	6	7	9	3	5	5	3
		6	1	1	1	6	2	5	2	4	1

--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Газрын тосны олборлолтын үйл ажиллагааны явцад агаар, хөрс, ургамал, амьтан, усны нөөц болоод чанарт голлон сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

## **2.1 Агаар орчинд нөлөөлөх нөлөөлөл**

### **2.1.1 Хорт хий**

Газрын тос олборлолтын байгальд үзүүлэх нөлөөлөл нь газрын тостой хамт олборлогдох нүүрсустөрөгчийн түүхий эдэд агуулагддаг хортой бодис бөгөөд хамгийн түрүүнд агаар орчныг бохирдуулах хорт хаягдлыг бий болгоно. Үүнд: нүүрсустөрөгч түүний уламжлалууд /CmHn/, хүхэрт устөрөгч H<sub>2</sub>S, нүүрсхүчлийн хий CO<sub>2</sub>, хүхэрт болон азотот нэгдлүүд /SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>/ голлон орно. Химийн урвалж бодисууд, тэсрэх болон цацраг идэвхит бодисын хадгалалт хамгаалалт, ашиглалт зөрчигдөж технологийн алдаа гаргах нь агаарт хортой нөлөөлөл үзүүлнэ.

### **2.1.2. Тоосжилт**

Тоос үүсгэгч эх үүсвэр нь 2 янз байна. Анхдагч үүсвэр нь өрөмдлөгийн үед ашиглах далан, нүх цооног болон далд шугам хоолойн ажил, хөрсний шороон овоолгууд, хайгуул-олборлолтын үеийн ажлын талбай, авто зогсоол, тээвэрлэлтийн гадаад дотоод замын сүлжээ, суурьшил хөдөлгөөн зэрэг газар ашиглалттай холбоотой бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл юм. Хоёрдогч эх үүсвэр нь тээврийн хэрэгслэл, машин механизмын хөдөлгөөн, хөрсөн дээр хийгдэх газар шорооны бүх ажлууд хамрагдаж байна.

### **2.1.3 Цацраг идэвхи**

Каротажийн судалгаанд ашиглах цацраг үүсгүүрийн ашиглалт, хадгалалт болоод агаар мандлын доод давхаргын цацраг идэвхийн гол үүсгүүр болох радон ба түүний задралын бүтээгдэхүүний агаар дахь хэмжээг судлах нь тухайн хот суурин газрын агаарын цацраг идэвхийг эрүүл ахуйн үүднээс үнлэх, мөн цацраг идэвхийн үүсэл гарлын асуудлыг тодруулахад чухал ач тустай.

## **3.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

### **2.2.1 Гадаргын ус**

Гадаргын усыг (тал хээрийн нутагт нуур тойром, гол горхи, сайр жалгаар урсах түр зуурын урсац, хотос хонхор газарт тогтсон түр зуурын ус г.м) бохирдуулагчийн тоонд газрын тос, түүний бүтээгдэхүүн, зэс, хар тугалганы нэгдэл ордог бол газрын доорхи усыг бохирдуулагчийн тоонд газрын тосны бүтээгдэхүүн, зэс, цайр, хар тугалга, мөнгөн ус, никель, кадми, мышьяк зэрэг хүнд металл, азот, сульфат, хлорын нэгдлүүд орно. Газрын тосны өрөмдлөг - хайгуул, олборлолт, анхан шатны боловсруулалт - хадгалалтын үед ашиглагдаад бохирдсон усыг цэвэрлэн эргүүлж ашиглах, түүгээр цэвэр усыг бохирдуулахгүй байх, усыг технологийн ба ахуйн хэрэгцээнд ариг гамтай тоолуураар тооцоотой ашиглах нь ус хамгаалах ач холбогдолтой юм. Компанийн зүгээс ТА-1 байгууламжаас гарсан хаягдал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашигладаг нь усанд хэмнэлттэй



ногоон шийдэл болсон технологи юм. 2023 онд газрын гүнээс олборлосон цэвэр усныхаа 30 гаруй хувьтай тэнцэхүйц хэмжээний бохир усыг цэвэршүүлэн эргүүлэн ашигласан байна. Газрын тос олборлолтын үед усны үндсэн хэрэглэгч нь ашиглалтын ба шахалтын цооногууд, угаалгын уусмал бэлтгэх зангилаа, шахуурганы станц, үйлдвэрлэлийн шугам хоолойнууд, бохир ус цэвэрлэх байгууламжууд болон эрчим хүчний тоног төхөөрөмжүүд байдаг.

#### 2.2.2. Газрын доорхи ус

Технологийн дараах процессууд нь гүний уст давхаргад сөрөг нөлөө үзүүлнэ. Үүнд:

- a) Уусмал ашиглан өрөмдлөг хийх;
- b) Химийн урвалжуудаас давхаргад нөлөөлөх, давхаргын хүрээнээс гадуур усжих;
- c) Ил задгай, хөрсний болон гүний ус нүүрсустөрөгчүүд болон химийн урвалжуудаар бохирдоно.
- d) Өрөмдлөгийн ажил нь хортой нөлөөллийнхөө хувьд янз бүрийн шинж чанартай химийн урвалжууд болон материалуудыг ашиглах, усыг янз бүрийн хэмжээгээр хэрэглэх, харилцан адилгүй хэмжээтэй технологийн хаягдал гаргахтай холбоотой байдаг. Төслийн хэрэгжилтийн үед хайгуул, олборлолтын цооног өрөмдөх, нефтийн уурын урсгалыг хөргөх, тоног төхөөрөмжийн хөдөлгөөнт хэсгийг хөргөх болон угаах, төрөл бүрийн химийн реагент уусмалыг бэлтгэхэд усыг хэрэглэнэ.
- e) Усан орчинд нөлөөлдөг эх үүсвэрүүдэд өрөмдлөгийн үед үүссэн бохир ус, ашиглагдсан угаалгын уусмал, өрөмдлөгийн шаарны шингэн хольц (Эдгээр хаягдлууд нь өөртөө органик болон органик бус бохирдуулагч бодисууд агуулж байдаг) зэрэг нь хамаарагддаг тул шингэн үл нэвчүүлэх геомембран хальсыг өрмийн шаврын хаягдлын санд дэвсэж ашигладаг болно.
- f) Өрөмдлөгийн ажлын технологийг барьж ажиллаагүй, өрмийн шугам хоолой цоорох, ханын бэхэлгээ, хамгаалалт муу хийгдэх зэргээс газрын доорхи ус бохирдох эрсдэлтэй байдаг. Иймд өрөмдлөгийн ажлын технологи үйл ажиллагааг чанд мөрдөн ажиллах шаардлагатай байдаг.
- g) Харин олборлолтын үед тостой хамт гарч байгаа бохир усны экологид нөлөөлөх нөлөөлөл нь давхаргын өгөлтийг сайжруулах зорилгоор ус хэрэглэсний улмаас түүнд агуулагдан гарч ирж байгаа нефтийн нүүрсустөрөгчүүд болон химийн урвалжуудын хэмжээнээс хамаардаг.
- h) Тосыг уснаас цэвэрлэх дамжлагын технологи ажиллагаа, гарч буй усны чанарт тавих мониторингийн хяналт байхгүй буюу муу ажилласанаас, усыг эргүүлэн бүрэн хэмжээгээр ашигладаггүй асгах зэргээс бохирдол бий болох эрсдэлтэй.

Мөн хөрсөн дээр асгарсан газрын тосны бохирдол аажимдаа урт удаан хугацааны явцад үер, бороо хурын усаар талбайн хэмжээнд нил угаагдал явах үед газрын гадаргад ил гарсан ус агуулагч чулуулгаар дамжин газар доорхи усыг бохирдуулах магадлалтай тул ил задгай асгарсан тосны бохирдолыг цэвэрлэн саармагжуулж байх шаардлагатай байдаг.

### **2.3 Хөрсөн бүрхэвч, ургамалын нөмрөгийн нөлөөлөл**

#### 2.3.1 Хөрсөн бүрхэвчийн нөлөөлөл:

Газрын тосны олборлолтын үед хөрсний элэгдэл эвдрэл үүсгэх гол хүчин зүйл нь өрөмдлөг, олборлолтын технологи, үйл ажиллагаа болоод тээвэрлэлт бол бусад хүчин зүйлд олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх түүний хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн дэд бүтцийн төслүүд нь (Өндөр хүчдэлийн шугам татах, далд шугам хоолойгоор цооногуудыг холбох, тээвэрлэлтийн дотоод болоод гадаад замын ажил) бүтээн байгуулалтын ажлын явцдаа хөрсний элэгдэл, эвдрэл үүсгэдэг болно. Харин хөрсийг бохирдуулагч гол эх үүсвэр нь өрөмдлөгийн үед ашиглагдах химийн реагентүүд тэдгээрийн ашиглалт, олборлолт- хадгалалт - ачилт, эргэлтийн ус, даланд хуримтлагдах технологийн шингэн хаягдал, газрын тосны хайгуул олборлолтын техник тоног төхөөрөмжүүдийн хөдөлгүүрүүдийг түлшээр цэнэглэх, химийн бодис материал ба түлшний хадгалалт, төслийн үйл ажиллагааны технологийн журам заавар зөрчигдөх тэдгээртэй холбогдсон технологи ажиллагааны доголдол, болзошгүй осол аваар зэрэг болно.

Ургамлын бүрхэвчийн нөлөөлөл:

Ургамлан бүрхэвч нь тэжээвэр ба зэрлэг амьтны тэжээл төдийгүй хөрсний дээд давхаргын дулаан ба чийгийг зохицуулагч, хөрс бэхжүүлэгч байгалийн үнэлж баршгүй бүтээгдэхүүн юм. Газрын тосны бохирдол нь хөрсний биологийн үржил шим, ургамлын газрын доорхи (ургамлын үндэс цөөрч үгүй болох хүртэл давхаргын зузаан хамрагдана) фитомассыг багасгах хортой нөлөөлөлтэй. Газрын тосны хор хөнөөл удаан хугацаанд илэрдэг. Газрын тосоор бохирдсон хөрсөнд исэлдэн ангижрах ферментийн үйлчлэлээр явагдах урвалын хурд огцом удааширч, хөрсний хүчилтөрөгчийн горим өөрчлөгддөг. Эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд газрын тосны хортой үйлчлэл нь илүү хүнд үр дагавартай байдаг. БХГэрээт Тосон-Уул XIX талбайд хийгдэх өрөмдлөг, олборлолтын үеийн ажлын талбайн ашиглалт, далд шугам хоолойн угсралт, экспортын зам болоод олборлолтын талбайн дотоод замын сүлжээний шигүүрэл зэрэг олон сөрөг нөлөөллүүдээс шалтгаалж ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц өөрчлөгдөн, халцгай талбайн хэмжээ ихсэх нь хөрс суларч элсжих, хотос хонхоруудад хуримтлагдах зэргээр цөлжих процессыг нэмэгдүүлнэ.

#### **2.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

XIX талбайн зүүн өмнө хэсэг буюу суурингийн өрөмдлөгөийн орчимд дуу чимээ, суурьшил хөдөлгөөн, шөнөөр асах гэрэл гэгээ зэрэг төслийн үйл ажиллагаа, суурингийн ахуйн хэрэгцээтэй холбогдож томоохон хөхтөн амьтад дайждаг. Тамсагийн газрын тосны хайгуул олборлолтын технологи үйл ажиллагаа болоод дэд бүтэцтэй уялдаж төслийн хэрэгжилтийн хугацаанд амьтны аймаг ялангуяа хөхтөн амьтад (цагаан зээр г.м), шувуудын байршил, тархац, тоо толгойд шууд болон шууд бус хэлбэрээр сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

##### **2.4.1 Шууд нөлөө:**

Үржил шимт хөрсөн дээр шинээр чулуу шороон үе бий болох үед тэнд байгаа дарагдсан амьтад (шавьж г.м) орчноо бүрдүүлж амжилгүй устаж үгүй болж төрөл зүйлийн тоо буурч өөрчлөлт орно. Өрөмдлөг, олборлолтын үеийн газрын тосны үнэр, түр суурьшил, хөл хөдөлгөөн,

дуу чимээнээс хөдөлгөөн хурдан амьтад (том хөхтөн, шувууд) дайжиж зайлж амьдрах орчиноо сэлгэхэд нөлөөлөн сөрөг нөлөө үзүүлдэг. Ялангуяа хэвлээр явагч амьтан ба хөрсний амьтдад илүү их нөлөөлөлтэй. Хүн, машин техникийн хөл хөдөлгөөн, дуу чимээ, гэрэл зэрэг нь орчин тойрны 2-3 км хүртэлхи зайд байгаа зарим том хөхтөн (цагаан зээр, үнэг, хярс, саарал чоно, бор гөрөөс) амьтадын гол байршил нутаг, нүүдэллэх замыг алдагдуулж, улмаар тоо толгойг бууруулахад хүргэж болох магадлалтай.


#### 2.4.2 Дам нөлөө:

Амьтан устгах дайжих, орчин тохигүйтэх зэрэг сөрөг өөрчлөлт нөлөөллөөс үүдэн амьтны аймагт дам нөлөө ямар нэг хэмжээгээр зайлшгүй гардаг. Жижиг мэрэгчдээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж үйл ажиллагаа явуулж буй нутгаас холдох, том туруутан амьтад дайжин холдсоныг дагаж саарал чоно байршлаа өөрчлөх гэх мэт сөрөг нөлөөтэй. Дээрх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулахын тулд төслийн хэрэгжилтийн үеийн технологи мөрдөлт, тэнд ажиллаж байгаа хувь хүний хариуцлагын асуудлыг хамгийн өндөрт түвшинд тавих шаардлагатай бөгөөд бага гэхгүй технологи алдаа нь байгаль орчин, хүний эрүүл мэнд хийгээд нийгэмд ихээхэн хэмжээтэй хохирлыг бий болгох магадлалтай тул заавар, зааварчилгаа, дүрэм, журмуудыг тодорхой болгон ажиллах шаардлагатай болдог. Мөн жил бүрийн байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд болоод түүнд шаардагдах зардлыг нарийн тодорхой тусгасан хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баримталж ажиллах нь чухал юм.

#### 2.5 Дуу чимээнээс үзүүлэх сөрөг нөлөөлөл

Дуу секундэд 16-20 мянган хэлбэлзэл хийдэг механик хэлбэлзэл бөгөөд хүний сонсголын системд ямар нэгэн муу нөлөөгүй. Харин шуугиан гэж өндөр давтамжтай ультра, инфра дууг хэлнэ. Энэ нь сонсголын системийг цочроож, мэдрэлийн системд таагүй нөлөө үзүүлдэг. Улмаар хүн нойргүйтэх, стрессэд орох, ямархан ядрах, хөдөлмөрийн бүтээмж алдах, аймхай болох зэрэг

График 1. Дуу шуугианы хэмжилт



сөрөг нөлөөнд автдаг. Шуугиан зөвхөн хүн төдийгүй бусад амьд организмд сөргөөр нөлөөлдөг. Шуугианыг ДБ (децибалл) гэсэн нэгжээр илэрхийлэх бөгөөд энэ нь логарифм хамаарлаар өсдөг.

Өөрөөр хэлбэл, шуугиан 0-10ДБ болж нэмэгдэхэд эрчим нь 10 дахин, 10-20ДБ болоход 100 дахин чанга болно гэсэн үг юм. Шуугианы хүнд нөлөөлөх хамгийн доод хэмжээ 120ДБ байдаг, шуугианы хэмжээ эх үүсвэр болон зайнаас хамаарна. Тухайлбал, энгийн замын хөдөлгөөнийн шуугиан 40-50ДБ, харин замын хажууд зогсож буй хүний хувьд 40-45ДБ байдаг бол зам дээр машины хөдөлгөөнд оролцож буй хүний хувьд ойролцоогоор 70ДБ байдаг. Энэ хэмжээний шуугианд хүн унтаж, тайван байж чаддаггүйг эрдэмтэд баталсан байна. Эх үүсвэрийн зайнаас гадна агаарын урсгал хөдөлгөөн нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, хөдөлгөөн ихтэй бол шуугиан амархан сарнидаг. Дуу шуугианы түвшин 90ДБ хүрсэн байранд 8 цагаас илүү хугацаагаар байхад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх ба 120ДБ хүрсэн дуу чимээ 0.6 минутаас илүү үргэлжлэхэд тэнд байгаа хүний сонсголын эрхтэн нь гэмтэх аюул учирна. Гадаадын зарим оронд дуу чимээний зөвшөөрөгдөх дээд хэмжээг мэдрэмтгий бүс (сургууль, цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн г.м)-д 45дБА, суурин газарт 50дБА, холимог бүсэд 60дБА, үйлчилгээний бүсэд 70дБА, үйлдвэрийн бүсэд 75 дБА байхаар тогтоожээ. Дээрх зургаас харахад 47 дБа-с 54 дБа –ын хооронд хэлбэлзэж байгаа нь стандартаас доогуур үзүүлэлт бөгөөд тухайн орчны дуу шуугианы богино хугацааны суурь утгыг илэрхийлж байгаа юм. Төслийн талбайн шуугианы эх үүсвэр нь ерөнхийдөө техникийн дуу чимээ, авто машины дуу чимээ болон төслийн үндсэн үйл ажиллагаа зэрэг байна.

## **2.6 Түүх соёлын биетэд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

“Петрочайна Дачин Тамсаг (Монгол)” ХХК нь 2010-2011 онуудад Шинжлэх ухааны академи, Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээт XIX, XXI талбайд хайгуул судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн байна. Тухайн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд: ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн захирлын Соёлын өвийн асуудал хариуцсан зөвлөх, доктор профессор Б.Гүнчинсүрэн, Археологийн авран хамгаалах судалгааны секторын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, доктор Ч.Ерөөлт-Эрдэнэ, доктор Г.Рэгзэн нараар удирдуулсан 2 ажлын хэсэг 2 удаа ажиллажээ. Матад, Халхгол сумдын нутаг, БХГ талбайд явуулсан хайгуул судалгааны ажлын үр дүнд нийт 160 гаруй дурсгал илрүүлж холбогдох баримтжуулалтыг хийж байршлыг тогтоосон байна. Үүнд: Чулуун зэвсгийн үеийн түүхэнд холбогдох уу суурин, түүвэр олдвор, хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үе, Хүннү, Түрэгийн үеийн булш оршуулгын байгууламж, дундад зууны үеийн түүхэнд холбогдох хүн чулуу хөшөө, XVIII-XIX зууны үеийн түүхэнд холбогдох бурхны шашны холбогдолтой сүм хийдийн туурь, бурхны хөрөг зэрэг Монголын түүхийн олон үеийн дурсгал багтана. Эдгээрээс Монголын чулуун зэвсгийн үеийн нэгэн гол төлөөлөл болох Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн бууц, суурин, Матад сумын нутагт орших хүрэл ба төмөр зэвсгийн үеийн түүхэнд холбогдох 158 булш бүхий Бүрдийн оршуулгын дурсгалт газар, Шонх тавантолгойд байх XIII зууны Монгол язгууртны чулуун хөрөг зэрэг чухал дурсгалуудыг онцлон тэмдэглэсэн байдаг. Тухайн нутаг дэвсгэр нь манай орны хамгийн намдор газар бөгөөд далайн түвшнээс 650м-т оршдог бөгөөд хөрсөн бүрхэвчийн хувьд дунд палеозой, юра, цэрдийн галавын чулуулаг болон дөрөвдөгч неогены хурдас ихээр тархсан байдаг.

Халхгол сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд Халхын То вангийн хошуундаа барьж байгуулсан уран барилгын дурсгалууд дотроос хамгийн гайхамшигтай нь Халхголын үзэсгэлэнт дэнжийг дэрлүүлэн байгалийн чулуугаар товойлгон 2 га илүү талбай эзлүүлэн урласан Найман аюулаас аврагч, өрөвч, нигүүлсэнгүй Жигважиджав Жанрайсиг бурхан юм. Мөн энэ нутагт 1939 онд Халх голын дайн болсон түүхэн дурсгалт газар юм. Үүнтэй холбоотой олон арван дурсгалт газрууд, Халхголын ялалтын 90 м зэс хөшөө, Ялалтын музей, Жуковын командын байр, Монгол дайчдын хөшөө, 90 баатрын хөшөө зэргүүд бий.

**ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Манай компани дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг өндөр хувиар бууруулах зорилт тавин ажилласан ба 2023 онд байгаль орчныг хамгаалах ажлуудын тендерийг нээлттэй зарлаж Монгол улсын бүртгэлтэй аж ахуй нэгжүүдийг сонгон ажилласан. Тосон-Уул XIX талбайн удирдлагын зүгээс аливаа барилгын ажил, цооног үйлчилгээний ажил эхлэх үед туслан гүйцэтгэгч, гэрээт компаниуд, тэдгээрийн анги нэгжүүдэд байгаль орчин, аюулгүй ажиллагааны шаардлага зөвлөмжүүдийг өгч, үйл ажиллагааны явц, ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажилласан. Эдгээр ажилд АМГТГ-ын холбогдох мэргэжилтнүүд болоод орон нутгийн засаг захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран аюулгүй тогтвортой олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.

Үйл ажиллагааны явцад хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нөхөн сэргээлт хийсэн өрмийн шаврын хаягдлын сангаас дээж авах, үйлдвэрлэлийн баазын объектуудад ариутгал, халдваргүйтгэл хийх, шинээр өрөмдөх цооногийн өрмийн шаврын хаягдлын санг шаардлагын дагуу байгуулах, автозамын менежментийг сайжруулах, хааж тэмдэгжүүлэх, технологийн шаардлагагүй болсон замуудыг хагалж сийрүүлэх ажлыг тусгасан бөгөөд дээрхи ажлуудын гүйцэтгэлийг тус тус үзүүлэв.

**Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөгч	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	Зарим хуваарилах чиглэлд явсан шороон зам	Үйлдвэрлэлийн баазын дотоод нөөц бололцоог дайчлан эвдэрсэн 5 км замыг грейдэрээр хусаж тэгшлэн индүүдэж арчилгаа хийсэн.

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

2		Үйлдвэрлэлийн баазын үйл ажиллагаатай холбоотой усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Ус ашиглалтанд баталгаажуулсан тоолуур ашиглаж төлбөрийг хийж улмаар улирал тутамд усны дээж авч шинжлүүлсэн.
3	Усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжид бохир ус зөвшөөрөлгүй буулгахаас урьдчилан сэргийлж байнгын бүртгэл хөтлөн ажиллах.	Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламжинд бохир буулгах тухай бүрт зөвшөөрлийн хуудсыг бөглүүлэн бүртгэл хөтлөн ажилласан.
4		Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн орж гарч байгаа усанд стандартын дагуу шинжилгээ хийлгэх.	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн орж гарч байгаа усанд стандартын дагуу улирал тутамд дээж авч Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжлүүлсэн.
5		Өрмийн сан байгуулахад шимт хөрсийг тусгайлан овоолж пайзжуулах	2023 онд 2 цооног өрөмдөж өрмийн шаврын хаягдлын сан байгуулан үржил шимт хөрсийг тусад нь овоолон пайз тавьж ажилласан.
6		Олборлолтын операторууд болон тээврийн хэлтсийн жолооч нар, гэрээлэгч ангийн нийт жолооч нарт маршрутын бус замаар зорчихгүй байх, түүний ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах	БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудын жолооч нарт аюулгүй ажиллагаа болоод байгаль орчны сургалтыг хийж ажилласан.
		Нөхөн сэргээлт хийсэн өрмийн шаврын хаягдлын	2023 оны БОМТ-нд тусгагдсаны дагуу 30 нөхөн саргээлт хийсэн цооногын

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

7	Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	сангаас хөрсний дээж авч шинжилгээнд өгөх	талбайгаас хөрсний дээж авч БОТЛ болоод Геологийн төв лабораторид шинжлүүлэх ажлыг “Байгаль тандалт” ХХК-тай гэрээ байгуулж хийж гүйцэтгүүлж ажилласан.
8	сөрөг нөлөөлөл	Ашиглахгүй болсон технологийн замын хөрсийг хаглаж сийрүүлэх	2023 оны БОМТ-нд 50 га газрыг хаглаж сийрүүлэхээр тусгагдсаны дагуу 50 га талбайд “Дорнод теленет сүлжээ” ХХК-тай гэрээ байгуулан хаглаж сийрүүлэх ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
9	Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршигийн талаар сургалт зохион байгуулах	Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхээр бэлэн байдлыг ханган гал түймэр унтраах тоноглолыг захиалан авч бэлэн байдлыг хангаж ажилласан. 2023 онд БХГ-т талбай болоод түүний орчны бүсэд гарсан 7 тал хээрийн түймрийг үйлдвэрлэлийн баазын зүгээс унтраан амьтан ургамлыг хамгаалан ажилласан байна. БХГ-т талбайд ажиллаж буй нийт ажилчдад хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж ажилласан.

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

10		Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлыг төлөвлөн зохион байгуулах.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэрээт талбайн түр суурингуудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн моджуулах ажлын хүрээнд “Байгалиа дээдлэе” ХХК-тай гэрээ байгуулан Дорнод аймгийн Матад суманд Жигдны суулгац 5000ш, Гүйлс модны суулгац 3000 ширхэгийг тус тус хүлээлгэн өгсөн байна. Мөн XIX талбайн хээрийн түр сууринд 18568ш мод тариад байна.
11		Хууль бусаар ан агнах, ургамал түүх тэдгээрийг тээвэрлэх ашиглахыг хооиглох тухай Монгол улсын холбогдох хууль дүрмийн талаар сургалт зохион байгуулах	Тосон-Уул XIX талбайн нийт ажилчдад Хууль бусаар ан агнах, ургамал түүх тэдгээрийг тээвэрлэх ашиглахыг хориглох тухай сургалт зохион байгуулсан.
12	Амьтны аймагт учруулах нөлөөлөл сөрөг	БХГ-т талбайн хээрийн түр суурин болоод ахуйн бохирын цэг, хатуу хог хаягдлын цэгт хортон шавьж мэрэгч амьтан үржих, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс шавжгүйтгэлийг хийх	БХГ-т талбайн хээрийн түр суурин болоод ахуйн бохирын цэг, хатуу хог хаягдлын цэгт хортон шавьж мэрэгч амьтан үржих, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс шавжгүйтгэлийг мэргэжлийн эрх бүхий “Эгэл альфа” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд уг ажлыг үйлдвэрлэлийн баазад 2023 оны 06-р сарын 26–29 өдрүүдэд, 2023 оны 09-р сарын 22-24-ны өдрүүдэд 2 удаагийн давтамжтай хийж гүйцэтгэсэн.



3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

3.1.1 Зам арчилгаа

2023 оны БОМТ-нд агаарын чанар болоод хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд БХГ-т талбайн технологийн шороон замын эвдрэл ихтэй хэсгүүдэд зам арчлалт хийгдэхээр тусгагдсаны дагуу үйлдвэрлэлийн баазын зүгээс дотоод нөөц бололцоог ашиглан эвдрэл ихтэй 5 км замыг автогрейдерээр хусаж тэгшилж янзалсан.



Зураг № 12. Зам арчлалт хийж буй байдал

3.2 Усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

3.2.1 Үйлдвэрлэлийн баазын үйл ажиллагаатай холбоотой усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах

Ус ашиглалтанд баталгаажуулсан тоолуур ашиглаж төлбөрийг хийж улмаар улирал тутамд усны дээж авч Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжлүүлсэн.



Амжилттай	Эмчилсэн	Хүлээгдэж байгаа	Хүлээгдэж байгаа	Хүлээгдэж байгаа	Хүлээгдэж байгаа
PH	7.2	6.5-8.5	7.0-8.5	7.0-8.5	7.0-8.5
Ca	120	0-1000	0-1000	0-1000	0-1000
Mg	40	0-1000	0-1000	0-1000	0-1000
Fe	0.1	0-10	0-10	0-10	0-10
NO3	10	0-100	0-100	0-100	0-100
NO2	0.1	0-10	0-10	0-10	0-10
Cl	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
SO4	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br+I	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br+I+B	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br+I+B+V	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br+I+B+V+Mo	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br+I+B+V+Mo+W	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br+I+B+V+Mo+W+Bi	100	0-1000	0-1000	0-1000	0-1000
CO3+HCO3+Cl+SO4+NO3+NO2+NH4+Mn+Cu+Zn+Pb+Ni+Cr+As+Hg+Cd+Se+Br+I+B+V+Mo+W+Bi+Po	100	0-1000	0-1000	0-1000	0-1000

Зураг № 13. Шинжилгээний хариу

# БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023



Зураг № 14. Ус ашиглах гэрээ, дүгнэлт, зөвшөөрөл

## Хүснэгт 9. Албан тоот

Байгууллага		Огноо	Албан тоотын дугаар
“Усны газар”	Ус ашиглах дүгнэлт	2022.03.03	05/245
“Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа	Ус ашиглах зөвшөөрөл, гэрээ	2023.03.10	A/03
“Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлт”	Шинжилгээний дүн	2022.09.04	23-387

### 3.2.2 Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжид бохир ус зөвшөөрөлгүй буулгахаас урьдчилан сэргийлж байнгын бүртгэл хөтлөн ажиллах.

Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламж нь 2010 онд ашиглалтанд орж улмаар 2019 онд Престиж инженеринг ХХК өргөтгөл хийж 175м<sup>3</sup>/х болгон хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжийг байнгын манаачтай байлгаж улмаар уг байгууламжинд буулгаж буй хаягдлыг бүртгэн ажиллаж байна. 2023 оны 11 сарын байдлаар уг байгууламжинд 11476 м.куб ахуйн бохирыг буулгаж цэвэршүүлсэн байна.

### Хүснэгт 9. Ахуйн бохир байгууламжинд буулгасан шингэний хэмжээ

№	Харъяалал	Буулгасан шингэний хэмжээ
1	Датамо ХХК	11476 м.куб

**3.2.2 Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн орж гарч байгаа усанд стандартын дагуу шинжилгээ хийлгэх.**

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн орж гарч байгаа усанд стандартын дагуу улирал тутамд дээж авч Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжлүүлсэн.




Зураг № 15. Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжаас дээж авч буй нь

**3.3 Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл**

**3.3.1 Өрмийн сан байгуулахад шимт хөрсийг тусгайлан овоолж пайзжуулах**

2023 онд 2 цооног өрөмдсөн бөгөөд дээрх 2 ширхэг өрмийн шаврын хаягдлын санг байгуулахдаа геомембранаар санг доторлон улмаар сангаас гарсан үржил шимт хүрэн хөрсийг тусад нь овоолго үүсгэн пайз тавьж тэмдэгжүүлэн ажилласан.



Зураг № 16. Өрмийн шаврын хаягдлын сан байгуулж буй байдал

# БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

3.3.2 Олборлолтын операторууд болон тээврийн хэлтсийн жолооч нар, гэрээлэгч ангийн нийт жолооч нарт маршрутын бус замаар зорчихгүй байх, түүний ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах.

БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудын жолооч нарт аюулгүй ажиллагаа болоод байгаль орчны сургалтыг хийж ажилласан.



Халтиргаа гулгаа болон шайхилгааны аюулгүй байдалын сургалтын бүртгэл

№	Огноо, нэр	Нис, суви	Хэлтэс, анги	Албан тушаал	Утасны дугаар	Гэрэлтүүлэг
1	Т.Доржиев	27	Сурталч	Сурталч	80081100	Т.Доржиев
2	С.Доржиев	28	Сурталч	Сурталч	80081100	С.Доржиев
3	У.Сүхбат	32	Сурталч	Сурталч	80081100	У.Сүхбат
4	А.Сүхбат	33	Сурталч	Сурталч	80081100	А.Сүхбат
5	С.Сүхбат	34	Сурталч	Сурталч	80081100	С.Сүхбат
6	Т.Сүхбат	35	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
7	Т.Сүхбат	36	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
8	Т.Сүхбат	37	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
9	Т.Сүхбат	38	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
10	Т.Сүхбат	39	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
11	Т.Сүхбат	40	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
12	Т.Сүхбат	41	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
13	Т.Сүхбат	42	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
14	Т.Сүхбат	43	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
15	Т.Сүхбат	44	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
16	Т.Сүхбат	45	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
17	Т.Сүхбат	46	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
18	Т.Сүхбат	47	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
19	Т.Сүхбат	48	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
20	Т.Сүхбат	49	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
21	Т.Сүхбат	50	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
22	Т.Сүхбат	51	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
23	Т.Сүхбат	52	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
24	Т.Сүхбат	53	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
25	Т.Сүхбат	54	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
26	Т.Сүхбат	55	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
27	Т.Сүхбат	56	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
28	Т.Сүхбат	57	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
29	Т.Сүхбат	58	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
30	Т.Сүхбат	59	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
31	Т.Сүхбат	60	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
32	Т.Сүхбат	61	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
33	Т.Сүхбат	62	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
34	Т.Сүхбат	63	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
35	Т.Сүхбат	64	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
36	Т.Сүхбат	65	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
37	Т.Сүхбат	66	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
38	Т.Сүхбат	67	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
39	Т.Сүхбат	68	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
40	Т.Сүхбат	69	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
41	Т.Сүхбат	70	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
42	Т.Сүхбат	71	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
43	Т.Сүхбат	72	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
44	Т.Сүхбат	73	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
45	Т.Сүхбат	74	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат
46	Т.Сүхбат	75	Сурталч	Сурталч	80081100	Т.Сүхбат

Зураг № 17 Сургалтанд сууж буй жолооч нар

# БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

3.3.3 Нөхөн сэргээлт хийсэн өрмийн шаврын хаягдлын сангаас хөрсний дээж авч шинжилгээнд өгөх.

Уг ажлыг мэргэжлийн эрх бүхий “Байгаль Тандал” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн бөгөөд уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэхдээ MNS 3298-90 “Байгаль хамгаалал. Хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд” стандартын дагуу хөрсний дээж авч дээж авсан тухай акт үйлдсэн. Хөрсний дээжийг MNS 3298-90 стандартын дагуу техникийн нөхөн сэргээлт хийсэн өрмийн шингэн хаягдалын сангийн дөрвөн өнцөг болон төв цэгээс 50-60 см гүнээс авч сайтар хольж 1 кг багтаамжтай зориулалтын саванд савлан сан тус бүрээс 4 ширхэг хөрсний дээж авсан. Нийт авсан дээжний 1 хувийг ”Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн ЭМААБО-ны хэлтэст нөөц дээжний зориулалтаар хүлээж авав.



**ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨҮГ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

Хөф: 2023/1321  
Байгаль Тандалт ХХК  
Дорнод аймаг, Матад сум /Тосон-Уул, 19-р талбай/  
УБ, Хан-Уул дүүрэг, 24-р хороо,  
Богдони-1201, 76 тоот  
99123126  
baygaltandal@yahoo.com

Хяналтын шинжилгээний лаборатори  
Хиймэл  
10  
20, хөрс  
21.902-21721  
2023.09.19  
2023.09.26  
2023.10.02  
2

Тайлбар: (1) АСЗ-Атестирчигдсан стандарт загвар

Экспертын шинжилгээний лабораторийн эрхлэгч: *С.Ундраа*  
Хяналтын инженер: *Э.Наранчимэг*

*Манай байгуулалтар үйлчилгээнд байрлалаа.*

ГЭШТ нь МНС БОИЭС 17002, 360 17004, БОИЭС 17001 шаардлагын шаардлага хангана. Манай үйлдэл, шалгалтын бичиг Шинжилгээний дүн нь зөвхөн өгөгдөл бүрэн гүйцэтгэгдсэн үед л зөвхөн үүрэгтэй, тогтолцоо дараа нь хэрэглэгдэх болно. Энэ үйлдэл бичгийг хуурамч үйлдэл хуульчид харуулахыг хориглоно.

1800 001-077, Улаанбаатар хот, 6702  
Улаанбаатар хотын захиргаа, 13200-аас байр  
Утас: 991-2018 294, 76101001 Факс: 991-2018 4212  
Бичиг хаяг: Байгаль орчны менежментийн төв төүг

Хяналтын дүн: 2023.10.02  
Хуудас: 2/11

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн цөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот  
Утас: 11-341818 И-мэйл: [bohzi@gmail.com](mailto:bohzi@gmail.com)

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2023/ 502-504  
Сорьц ирүүлсэн газрын нэр, хааг утас : "Байгаль тандалт" ХХК  
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : н.Даланжаргал 99125126  
Сорьцны тоо, төрөл : 3, хөрсний сорьц  
Сорьц авсан огноо : 2023.09.19  
Сорьцны тодорхойлолт : Дорнод аймаг Матад сум 19-р талбай  
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01-2022  
Шинжилсэн огноо : 2023.09.25  
Хуудасны тоо : 1/1

Үр дүн

№	Сорьц авсан цэгийн нэр	Кальций (Сd)	Хар гуулал (Рb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронций (Sr)
1	T19-350-220 47°3'16.43" 116°19'49.2"	<0.05	12	<0.05	<0.5	<0.05	29	302
2	T19-268-169 46°56'58.7" 116°12'28.11"	0.8	9	<0.05	<0.5	<0.05	30	223
3	T19-223-1238 46°54'1.2" 116°16'22.12"	1.0	13	<0.05	<0.5	<0.05	29	248
<b>MNS 5850:2019/ЗДХ/</b>		<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>800</b>

Шинжилгээ гүйцэтгэсэн: *И.Оюунсүрэн* Инженер Б.Даваасүрэн  
Хянаж баталгаажуулсан: *Э.Наранчимэг* БОШ-ний хэлтсийн дарга Б.Бархсарчгаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



Зураг № 18. Шинжилгээний хариу болон хөрсний дээж авч буй байдал

3.3.4 Ашиглахгүй болсон технологийн замын хөрсийг хаглаж сийрүүлэх.

Тосон-Уул XIX талбайн хуучин зам, эвдэрсэн, ашиглагдахгүй болсон 50 га талбайг хагалж сийрүүлэхээр “Дорнод теленет сүлжээ” ХХК-тай гэрээ байгуулан уг ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Уг ажлын хүрээнд Тосон Уул XIX - Баянхошууны боомт чиглэлийн засмал замаас 21-р талбай руу салж явдаг хуучин шороон замыг хагалаж сийрүүлсэн.



Зураг № 19 Ашиглагдахгүй болсон замыг хаглаж бутлаж сийрүүлсэн байдал

3.4 Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

3.4.1 Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршигийн талаар сургалт зохион байгуулах.

Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхээр бэлэн байдлыг ханган гал түймэр унтраах тоноглолыг захиалан авч бэлэн байдлыг хангаж ажилласан. 2023 онд БХГ-т талбай болоод түүний орчны бүсэд гарсан 7 тал хээрийн түймрийг үйлдвэрлэлийн баазын зүгээс унтраан амьтан ургамлыг хамгаалан ажилласан байна. БХГ-т талбайд ажиллаж буй нийт ажилчдад хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж ажилласан.



Зураг № 20. Галын сургалт

3.4.2 Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлыг төлөвлөн зохион байгуулах.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэрээт талбайн түр суурингуудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн моджуулах ажлын хүрээнд “Байгалиа дээдлэе” ХХК-тай гэрээ байгуулан Дорнод аймгийн Матад суманд Жигдны суулгац 5000ш, Гүйлс модны суулгац 3000 ширхэгийг тус тус хүлээлгэн өгсөн бол БХГ-т Тосон Уул XIX талбайн хээрийн түр сууринд 18568ш мод тариад байна.

# БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

## МОДНЫ СУУЛГАЦ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АКТ

Дорнод аймаг Матад сум

2023 оны 05-р сарын 13

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хотолборийн хүрээнд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн зүгээс Жигд болон Гүйлс модны 8000 суулгацгийгнийгний харуцлагын болон орон нутгийн хамтын ажиллагааны ажлын хүрээнд Дорнод аймгийн Матад суманд хүлээлгэж өгч байна.

№	Суулгацны нэр төрөл	Тоо хэмжээ	Суулгацны нас	Суулгацны өндөр
1	Жигд	5 000	2 нас	60-70 см
2	Гүйлс	3 000	2 нас	70-80 см

**Хүлээлгэн өгсөн:**

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийг төлөөлж:

Дэл ерөнхийлөгч:  /Han Zhichang/

БХГ-т Тосон Уул XIX талбайн дэд дарга:

 /Zhao Liang/

Байгаль орчны асуудал харуцсан ажилтан:

 /Naqin/

**Хүлээн авсан:**


Дорнод аймгийн Матад сумыг зохиож:

Засаг дарга:  /J. Enkhbold/

Засаг даргын орлогч:

 /B. Arinjav/

ЗДТГ-ын дарга:

 /M. Serenjav/

Санхүү албаны дарга:

 /U. Jambajmaa/

Түмэнхаан багийн Засаг дарга:

 /N. Enkhmaa/

№	Суулгацны нэр төрөл	Суулгацны өндөр	Суулгацны нас	Тоо ХЭМЖЭЭ
1	Нарс	2-2.5m	8--10	50ш
2	Мөнгөлөг улиас	1.5-2m	3	300ш
3	Хайлаас	1.5m	4	12000ш
4	Буйлс	1.5m	4	280ш
5	Голт бор	1m	4	145ш
6	Өрөл	2m	7	16ш
7	Монос	1.5m	4	195ш
8	Гүйлс	1.2m	3	32ш
9	Улаан агч	0.7m	2	20ш
10	Шар хуайс	1.5m	5	2530ш
	<b>Нийт</b>			<b>18568ш</b>



Зураг № 21. Матад суманд модны суулгац хүлээлгэж өгсөн байдал.





Зураг № 22. Тэрбум мод төслийн хүрээнд мод тарьж буй нь

3.5 Амьтны аймагт учруулах сэрэг нөлөөлөл

3.5.1 Хууль бусаар ан агнах, ургамал түүх тэдгээрийг тээвэрлэх ашиглахыг хориглох тухай Монгол улсын холбогдох хууль дүрмийн талаар сургалт зохион байгуулах.

Тосон-Уул XIX талбайн нийт ажилчдад хууль бусаар ан агнах, ургамал түүх тэдгээрийг тээвэрлэх ашиглахыг хориглох тухай сургалт зохион байгуулсан.



Зураг № 23. Сургалтанд сууж буй ажилчид

3.5.2 Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

Ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэлийг мэргэжлийн эрх бүхий “Эгэл альфа” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд уг ажлыг үйлдвэрлэлийн баазад 2023 оны 06-р сарын 26–29 өдрүүдэд, 2022 оны 09-р сарын 22-24-ны өдрүүдэд 2 удаагийн давтамжтай хийж гүйцэтгэсэн.



Зураг № 24. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй нь

Тус ажлын хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Хүнс хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрлэлийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн

А/25, А/46, А/76 тоот хамтарсан тушаалын 4-р хавсралтаар батлагдсан чанарын шаардлага хангасан бодисуудыг ашиглана. Нийт 62 сууц, 34 албан өрөө, үйлдвэрлэлийн баазын эмнэлгийн өрөө, Монгол хятад гал тогоо, тоног төхөөрөмж, хүнс, материалуудын агуулахууд, кемп доторх 18 бохирын худаг, 2 цооног, кемпийн гаднах хог хаягдал ангилан ялгах цэг, хурлын танхим, 2-р кемп, Та-1 нэгдсэн байгууламж, хатуу хог хаягдал ангилан ялгах цэг, ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжуудад ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн бөгөөд халдваргүйтгэлийн ажлыг хийхэд ОХУ-д үйлдвэрлэсэн “РУ-4” маркийн 20 л багтаамжтай цахилгаан автомакс, мананцар үүсгэгч “Atomizer DS350”8 гар автомакс, мотофом, хүйтэн мананцар үүсгэгч “УF-500”, халуун мананцар үүсгэгч буу, цахилгаан жин, хэмжээт шилэн сав /хуванцар/, ХАБЭА-н хамгаалалтын хувцас, нэг удаагийн хувцас, хошуувч, N95 маск, нэг удаагийн малгай, резинэн бээлий, зөөврийн эмийн сан зэргийг ашигласан. Хлорын шохой, НИСОР 1:1200 тунгаар гадна халдваргүйтгэлд тус тус найруулж уусмал бэлтгэн автомаксаар болон мотофомоор шүршиж мөн хлорын шохойг хэрэглээ. Шавжгүйтгэлд Карате/ лямбпацигалотрин 0,2-0,3 л/га 20-30 мл тунгаар бодисыг гадна орчинд шавж авгалдай устгалд, жилию, дихлофос гель, ФАС зэргийг дотор орчинд тус тус шавжгүйтгэлд хэрэглэсэн. Мэрэгчгүйтгэлд: өгөөш /бромадиолон 0,5%-аар 30 кг / Открыс, ЭФА наалдуулагчийг хавсран хэрэглэсэн. Уг ажлыг гүйцэтгэхдээ явах замын дагуу болон тавиурын доогуур болон нүх сүвэнд онгоцонд хийж 1 метрийн зайтай тавьсан.

**ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжилт
1	Техникийн нөхөн сэргээлт	Өрмийн шаврын санд техникийн нөхөн сэргээлт хийх	Ширхэг	7	2023 оны БОМТ-нд тусгагдсан 7 өрмийн зүмп, 4 үйлдвэрлэлийн шингэн хаягдалын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн эрх бүхий “Баянтал Энержи” ХХК-аар гүйцэтгэв.
		Үйлдвэрлэлийн шингэн хаягдлын санд техникийн нөхөн сэргээлт хийх	Ширхэг	4	
2	Биологийн нөхөн сэргээлт	Эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийх	га	5	2023 оны БОМТ-нд тусгагдсан 5 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 1000 ш улиас мод суулгахаар ажлыг мэргэжлийн эрх бүхий “Эко эрдэнэс бюлдинг” ХХК хийж гүйцэтгэсэн.
		“Тэрбум мод” төслийн хүрээнд мод суулгах	Ширхэг	1000	

4.1 Техникийн нөхөн сэргээлт:

БХГ-т Тосон Уул XIX талбайн 2023 оны БОМТ-нд 7 өрмийн шингэн хаягдалын сан, 4 үйлдвэрлэлийн шингэн хаягдалын санд техникийн нөхөн сэргээлт хийхээр тусгагдсаны дагуу “Баянтал Энержи” ХХК-тай гэрээ байгуулан техникийн нөхөн сэргээлийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5914:2008, “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” MNS 5915:2008, “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5916:2008, “ Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5917:2008, “Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт техникийн шаардлага” MNS 6200:2010 стандартуудын дагуу мөн БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ыг удирдлага болгон ажилласан.



Зураг № 25. Өрмийн шингэн хаягдлын санд техникийн нөхөн сэргээлт хийж буй нь



Зураг № 26. ҮШХСангийн нөхөн сэргээлт

Нөхөн сэргээлт хийсэн аргачлал:

Өрөмдлөгийн шаврын уусмал, цооногийн угаалгын шингэн болон цооног өрөмдлөгийн үйл ажиллагааны үед үүссэн бусад холимог хаягдлыг цуглуулж хадгалах зориулалтын нүхийг өрмийн шингэн хаягдалын сан гэнэ. Өрмийн хаягдалын санд техникийн нөхөн сэргээлтийг өрөмдлөгийн үйл ажиллагаа дууссанаас 12 сарын дараа хийж гүйцэтгэнэ. Эхний ээлжинд хаягдлын сангийн хамгаалалтын тор болон шонг хурааж саармагжуулалт хийх ажиллагаанд бэлдэнэ. Саармагжуулалтанд магнийн хлорид болон хөнгөн цагааны сульфатыг ашиглана. Дээрх зориулалтын саармагжуулах бодисуудыг сайтар хольж хутган ууршуулалтын байдалд оруулах бөгөөд ухсан шороогоор өтгөрүүлэлтийг хийнэ. Ингэж өтгөрсөн хаягдын санг 1-2 хоногийн турш байгалийн нар салхиар хатааж бүрэн тогтвортой төлөвт шилжсэний дараагаар үргэлжлүүлэн булж улмаар хэлбэржүүлэлтийг хийж дууссаны дараагаар MNS 5916:2008 стандартын дагуу бэлтгэсэн шимт хөрсний овоолгоор 0.1 метрээс багагүй зузаантай хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлэн болгон тухайн цооногийн дугаар бүхий тэмдэг тэмдэглэгээг суурилуулсанаар техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээлгэн өгөхөд бэлэн болно.

#### 4.2 Биологийн нөхөн сэргээлт:

БХГ-т Тосон Уул XIX талбайн 2023 оны БОМТ-нд 5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж 1000 Улиас мод суулгахаар төлөвлөсний дагуу мэргэжлийн эрх бүхий “Эко эрдэнэс бюлдинг” ХХК-тай гэрээ байгуулан техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 4 өрмийн шингэн хаягдалын сан, 3 шингэн хаягдлын далан, ашиглагдахгүй болсон 4 км зам дээр биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэн 1000 ш улиас модыг 2023 оны 10дугаар сард шилжүүлэн суулгуулсан. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2008, “Улиасны суулгац. Ерөнхий шаардлага” MNS 6257:2011, “ Суулгацны нүх бэлтгэх, суулгах. Ерөнхий шаардлага” MNS6258-1:2011, “Мод, сөөгний суулгац арчлах” MNS 6258-2:2011 стандартуудыг удирдлага болгон ажилласан байна.



Зураг № 27. Биологийн нөхөн сэргээлт хийхээс өмнө



Зураг № 28. Биологийн нөхөн сэргээлт хийсний дараа



Зураг № 29. Биологийн нөхөн сэргээлт хийсэн зам



Зураг № 30. 1000 ширхэг улиас мод суулгаж буй байдал

**ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Манай компанийн Тосон Уул XIX талбайн байгаль орчны дүйцүүлэн хамгааллын 2017-2021 оны төлөвлөгөөний хугацаа тул 2023-2027 онд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, суурь судалгааны ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллага болох “ЕАСС” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж ажилласан. Уг судалгаагаар БХГэрээт Тосон Уул XIX талбайн орчим тэмдэглэгдсэн ургамал, амьтны зүйлээс экосистемийн хамгийн гол тулгуур зүйл болох боломжтой зүйлүүдийг аргачлал, шалгуурын дагуу сонгоход дараах 4 зүйл амьтан 4 зүйл ургамал сонгогдсон.

**Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ, байршил сонголт:**


Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоосны дараагаар төслийн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооно. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооход дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Үүнд: 1) Экосистемийн ховор байдал 2) Амьдрах орчны төрөл 3) Экологийн эрүүл байдал 4) Ландшафтын байршил 5) Нөлөөллийн хугацаа

Дорнод аймгийн Халхгол, Матад сумдын нутаг дэвсгэрт “Петро чайна” ХХК-ний хэрэгжүүлж буй газрын тос олборлох бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон – Уул XIX талбайн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах боломжит газрыг (талбайг) сонгохдоо монгол орны хэмжээнд тооцсон “тунадас, температурын потенциал утга (Q)”-ын шугаман бус загварчлалыг суурь болгож ашигласан. Тунадас, температурын потенциал утга (Q) нь тухайн газрын байгалийн бүс бүслүүрийн төлөв байдал, шилжилт хөдөлгөөнийг илэрхийлэх суурь нөхцөлийг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл тухайн газарт ургамал ургахад зайлшгүй шаардлагатай боломжит тунадас, ургамал ургах үеийн дундаж температурын харилцан хамаарлыг илэрхийлсэн тоон утга юм. Энэхүү тоон утгын загварчлалыг монгол орны хэмжээнд хийхдээ дэлхийн болон монгол улсын цаг уурын байгууллагаас эмхэтгэн гаргадаг олон жилийн цаг уур, уур амьсгалын болон хиймэл дагуулын анхдагч мэдээ мэдээллийг тоон статистикийн ба орон зайн өгөгдлийн шинжилгээний өндөр төвшинд боловсруулан хийж гүйцэтгэсэн байна. Ингээд дээр дурдсан үндсэн болон нэмэлт шалгууруудыг хэрхэн зурагласныг доор дэлгэрэнгүй орууллаа.

Үндсэн зургуудаас давхцуулж гаргасан дүйцүүлэн хамгаалахад тохиромжтой байдлын зургаас хамгийн тохиромжтой талбайг оновчтой сонгох нэмэлт шалгуур тогтоохын тулд төслийн талбай, дэд бүтэц, хөл хөдөлгөөн ихтэй орон нутгийн болон ачаа тээврийн төв замууд, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах үндсэн шугамууд, малчин айл өрхийн тогтмол ашигладаг худаг уст цэгүүд, томоохон тариалангийн талбай, сум суурин газрууд зэргээс алслалтын хязгаар бүхий зураглалыг хийж ашигласан. Ингээд эцэст нь дүйцүүлэн хамгаалахад тохиромжтой газар нь



“Тосон – Уул XIX талбайн” хувьд төслийн талбайгаас зүүн урагшаа 25-50 км орчимд байрлах Их эрээний тал орчмын жижиг толгод бүхий тэгш талархаг газар бөгөөд энэхүү талбай нь “Дорнод монгол” дархан цаазат газрын орчны бүсэд хамаарч байна. Бидний сонгосон талбай нь экосистемийн хувьд төслийн талбайтай ижил төстэй, тухайн орчинд амьдарч байгаа зэрлэг ан амьтанд хамгийн таатай буюу хүний үйл ажиллагааны янз бүрийн сөрөг нөлөөллөөс тохиромжтой зайд байрласан, хамгийн боломжит хур тунадас болон ургамал ургах үеийн орчны температуртай учраас ургамал бүрхэвч сайтай буюу идэш тэжээлийн олдоц, хүртээмж сайн байх боломжтой гэж үзсэн.



Зураг № 31. Дүйцүүлэн хамгаалхад тохиромжтой талбайн байршил

**Төлөөлөл болгон сонгосон биологийн олон янз байдал:**

Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон хоёр газар (Мэнэнгийн цагаан хоолой, Эрээний тал) нь газарзүйн мужлалаар дорнод монголын хээрийн тойрогт хамаардаг. Биологийн олон янз байдал нь нарийн зохион байгуулалттай тул тухайн газар нутгийн бүх биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах боломжгүй. Харин тухайн экосистем, амьдрах орчныг төлөөлөн илтгэж чадах эсвэл нэн ховор, ховор, түлхүүр, шүхэр амьтан ургамлын зүйл, бүлгэмдлийг сонгон тэдгээрт чиглэсэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Амьтан ургамлын хэдэн зүйлийг анхааран хамгаалах талаар тодорхой тоо тогтоох боломжгүй ч байгаль хамгааллын практикт тухайн газар нутгийн экосистемийн төлөөлөл болох 8 хүртэлх тооны биологийн олон янз байдлыг

сонгох нь зохимжтой байдаг. “Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн газрын тос олборлох Тосон уул XIX талбай орчим, дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэхээр сонгосон талбайд 2022 оны долоодугаар сард хийсэн биологийн олон янз байдлын суурь судалгаанд үндэслэн хамгаалах биологийн олон янз байдлыг төлөөлөл болгон сонгосон. Экосистемийн төлөөлөл болгон биологийн олон янз байдлыг сонгохдоо экологийн чухал хүчин зүйлийн шалгуур үзүүлэлтийг баримталсан. Үүнд

1. Хэмжээ: Экосистемд эзлэх хувь, зүйлийн тоо толгой, Популяцийн сүргийн бүтэц
2. Нөхцөл: Шүхэр ба Түлхүүр зүйл, харилцан үйлчлэлд ордог зүйлүүд, бүлгэмдлийн бүтэц, махчлал ба шимэгчлэл
3. Ландшафт-ын хүчин зүйл: Бүлгэмдлүүд болон экосистемүүд хоорондоо холбогдох байдал

**Цагаан зээр:** Цагаан зээр тухайн экосистемийн идэш тэжээлийн гинжин хэлхээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зээр нь өргөн уудам орон зайг хамран тархдаг учир хээрийн экосистемийн шүхэр зүйл юм. Зээрийн сэг зэм, хоргол нь газарт шингэж задран байгалийн бордоо болж өвс ургамал ургахад таатай нөлөө үзүүлдэг. Цагаан зээрийн хурц туруу нь хөрсөн дээрх өнгөрсөн жилийн хагд өвсийг бутлан шим тэжээлийн эргэлтэд оруулж, нялх ургамлын нарны хангамжийг нэмэгдүүлдэг

**Дагуур огдой:** Хээрийн экосистемд огдойн нөлөө асар их ялангуяа өвлийн улиралд идэж тэжээлийн хэлхээнд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Дагуур огдой орчны өөрчлөлтөд мэдрэмтгий тул биологийн олон янз байдлын өөрчлөлтийг түүний тархац ,элбэгшлээр хянаж болно. Дагуур огдой хээрийн экосистем хэвийн тогтвортой байгаа үед өсөж үрждэг.

**Дорнодын мэлхий:** Дорнодын мэлхий нь хур тунадас элбэг жил хялганат хээрт байршин амьдардаг онцлогтой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан тоо толгой ховордож байгаа. Монгол улсын улаан ном (2013)-нд орсон. Дэлхийн тархцын захын цэг тул онцгой анхаарах шаардлагатай.

**Шилийн сар:** Шилийн сар гүеэгээ өдөрт нэг удаа дүүргэдэг. Нэг удаа 5-9 цайвар үлийч барьдаг бөгөөд 4 ангаахайтай нэг шилийн сар өдөрт 20-30 цайвар үлийчийг устгадгийг судлан тогтоосон байдаг. Шилийн сарыг хамгаалснаар үлийн цагаан оготны тархалтыг хязгаарлах үндэс бүрдэнэ.

**Хялганат хээр:** Хялгана буюу хялганат хээр нь дэлхийн хэмжээнд нэн чухал экосистемд тооцогддог бөгөөд дэлхийн хэмжээнд маш бага хамгаалагдсан хот суурин, үйлдвэр, тарайлангийн

## БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

Хүснэгт 11 Аюул заналыг эрэмбэлсэн байдал

ДХ зүйлүүд	Аюул занал/шалтгаан	Ноцтой байдал	Хамрах хүрээ	Нөхөн сэргээгдэхгүй байдал	Нийлбэр үнэлгээ
Цагаан зээр	Хээрийн түймэр	Маш их	Их	дунд	Их
	Тоо толгойн хомсдол /Хууль бус агнуур/	Маш их	Их	Их	Их
	Амьдрах орчны доройтол	Маш их	Их	Дунд	Их
	Нүүдэл шилжилт хөдөлгөөний хязгаарлалт	Их	Их	Их	Их
Хялгана	Хээрийн түймэр	Маш их	Их	Бага	Их
	Ургах орчны доройтол/Малын тоо өсөх/	Их	Дунд	Бага	Дунд
Дагуур огдой	Хээрийн түймэр	Маш их	Их	Дунд	Их
	Амьдрах орчны доройтол	Маш их	Их	Их	Их
Дэрэвгэр жэрэвгэрүү, Урал чихэр, Дэрст хотгор	Хээрийн түймэр	Маш их	Их	Их	Их
	Ургах орчны доройтол	Их	Бага	дунд	Дунд
	Нөөцийн хомсдол/	Их	бага	дунд	Дунд
Шилийн сар	-	-	-	-	-
<b>Тулгамдаж буй асуудлын өнөөгийн үнэлгээ</b>					<b>Их</b>

зориулалтаар хамгийн их ашиглагдсан хэдий ч биологийн олон янз байдал, экосистемд үзүүлэх нөлөөллөө одоо болтол хадгалсаар ирсэн маш нарийн цогц тогтолцооны нэг хэсэг юм. Мөн хялганат хээр нь дорнод монголын тал хээрийн бүсийн хөхтөн амьтны гол төлөөлөгч болох Цагаан зээрийн үржиж төллөдөг тархац нутгийн нэг хэсэн хувьд цагаан зээрийн амьдрах орчныг хамгаалах, өнөөгийн нөхцөл байдлыг нь хадгалах, байгалийн дахин давтагдаагүй байдлыг алдагдуулахгүйн тулд тус амьдрах

орчныг сонгосон.

**Дэрст хотос хотгор:** Хээрт маш бага талбайд тохиолдох хэдий ч хээрийн экосистем үзүүлэх нөлөө нь асар их юм. Тэр дундаа биологийн олон янз байдлын амьдрах орчны хувьд маш чухал орчныг бүрдүүлдэг учир жижиг мэрэгч болох туулай, огдой гэх мэт жижиг махчид хярс, үнэг зэрэг амьтадын хувьд гол амьдрах орчин болохоос гадна олон ховор, нэн ховор ургамлын ургах орчин болдгоороо маш чухал юм. Иймээс хээрийн жижиг амьтадын амьдрах орчныг хамгаалах, өнөөгийн нөхцөл байдлыг нь хадгалах, хамгаалах үүднээс Дэрст хотгорыг сонгон авсан.

**Дэрэвгэр Жиргэрүү:** Эмийн гоц ашигт ургамал бөгөөд сүүлийн жилүүдэд үйлдвэр болон ахуй зориулалтаар маш их хэмжээгээр түүж ашигласнаас болж нөөц, тархац нь маш ихээр багассан Байгалийн ургамлын тухай хууль (1995), Монголын улсын Улаан ном (2013) –д ховор статусаар бүртгэгдсэн. Уг ургамлын төрөл зүйлийг хамгаалснаар ургах орчин болсон хээрийн экосистем хамгаалагдах учир *Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischk.- дэрэвгэр Жиргэрүүг сонгон авсан.

**Урал Чихэр өвс:** Эмийн чухал ашигт ургамал бөгөөд ахуй зориулалтаар маш их хэмжээгээр түүж ашигласнаас болж нөөц, тархац нь маш ихээр хомсодсон учир Байгалийн ургамлын тухай хууль (1995), ховор статусаар бүртгэсэн. Уг ургамлын төрөл зүйлийг хамгаалснаар ургах орчин болсон хээрийн экосистем хамгаалагдах учир *Glycyrrhiza uralensis* Fisch. - Урал Чихэр өвсийг сонгон авсан.

# БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

Хүснэгт 19. Аюул заналын үнэлгээ

Хамгаалах үнэт зүйлс	Дагуур огдой	Шилийн сар	Дорнын мэлхий	Цагаанзэр	Хялгана	Ураалчихэр өвс	Дэрэвгэр жирэруу	Дэрст хотос	Аюул заналын үнэлгээний дүгнэлт
<b>Аюул занал</b>									
Нүүдэл шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах	Дунд	бага	бага	Маш их					Дунд
Тоо толгойн хомсдох	Дунд	Их	Бага	бага					ИХ
Амьдрах орчныдоройтол	Маш их	Дунд	Маш их	Маш их					Маш их
Идэш тэжээлийн хомсдол	Дунд	Дунд	дунд	Маш их					Дунд
Ургах орчны доройтол	Маш их	Бага	Дунд	Маш их	Дунд	Дунд	Дунд	Дунд	Их
Нөөцийн хомсдол					Дунд	Бага	Дунд	Бага	Их
<b>Зүйлийн аюул заналын үнэлгээ</b>	Их	Дунд	Дунд	Маш их	Дунд	Дундаас бага	Дунд	Дундаас бага	Их

Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сонгосон талбайд хээрийг төлөөлж чадах биологийн олон янз байдал тус бүр тулгарч буй аюул заналыг үнэлэхэд нийлбэр үнэлгээ “ИХ” гэсэн үзүүлэлттэй гарсан. Шилийн сард үзүүлэх аюул занал нийлбэр үнэлгээгээр бага гэж үнэлэгдсэн байна. Шилийн сарын хувьд үнэлгээнд хамруулсан аюул заналуудад бага өртдөг. Дорнод монголын хээрийн биологийн олон янз байдалд хамгийн их аюул занал учруулж байдаг эрсдэл хээрийн түймэр, ган зуд, ургах орчны доройтол байна. Эрээний тал, Мэнэнгийн цагаан хоолой орчим хээрийн түймэр биологийн олон янз байдалд хамгийн их дарамт үзүүлдэг. Цаашид хээрийн түймрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатайТөлөөлөл болгон сонгосон зүйлүүдэд дарамт учруулж буй аюул заналыг эрэмбэлэн авч үзвэл Цагаан зэр, Хялгана, Дагуур огдой гэсэн гурван зүйлүүдэд амьдрах орчны доройтол, хээрийн түймэр, хууль бус агнуураас шалтгаалсан ноцтой байдал үүсгэж буйг харуулж байна. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг дээрх зүйлүүд рүү илүү чиглүүлэх шаардлагатай.

### Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө:

“Петрочайна Дачин тамсаг” ХХК-ний бүтээгдэхүүн хуваах гэрээт газрын тосны ашиглалтын XIX болон XXI талбайд БОЯБ амьдрах орчин, экосистемийг алдагдалгүй, тогтвортой хадгалах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад гол зорилго оршино. Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах долоон арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

ДХ арга хэмжээ 1:Төслөөс байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах.

ДХ арга хэмжээ 2:Хяналт шалгалтын сүлжээ байгуулах, орон нутгийн удирдах байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч хоорондын харилцаа холбоог сайжруулах

ДХ арга хэмжээ 3:Бэлчээрийн менежментийг сайжруулах арга хэмжээ

ДХ арга хэмжээ 4:Био техникийн арга хэмжээ хэрэгжүүлэх

ДХ арга хэмжээ 5:Сургалт сурталчилгааны явуулах замаар иргэдийн экологийн боловсролын түвшинг дээшлүүлэх

ДХ арга хэмжээ 6:Судалгааны ажил эрчимжүүлэх, мониторингийн арга хэмжээ хэрэгжүүлэх

ДХ арга хэмжээ 7:Сум орон нутгийн мал эмнэлгийн чадавхыг сайжруулах дэмжлэг үзүүлэх “Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн 2023 - 2027 онд хэрэгжүүлэх “Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө”-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.4.6 болон 9.6 дугаар заалтууд, Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам болон БОНХ-ийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу боловсруулав. БОАЖЯ, НҮБХХ-ийн “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төсөл болон Дэ Нэйче Консерванси хамтран гаргасан дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлагад 9 зарчим тусгасан байдгаас дорнод монголын хуурай хээрийн экосистемийн өвөрмөц байдал, Газрын тос боловсруулах төслийн онцлог гэх мэт шалтгаанаар дараах 6 зарчмыг баримталсан. Үүнд:

1. Нөлөөллийг бууруулах шатлалыг ашиглах: “Петрочайна Дачин тамсаг” ХХК газрын тос олборлох төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан ажилладаг. Тус байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайланд төслөөс байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөөг хэрэгжүүлэн ажилладаг.

2. Экологийн бүс нутгийн байгаль хамгаалах зорилтыг авч үзэх: Тиймээс дүйцүүлэн хамгаалах газар нутгийг сонгохдоо Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар, тэдгээрийн орчны бүсийг хамруулсан.

3. Бүх биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах боломжгүй: Дүйцүүлэн хамгаалахаар сонгосон талбай Дорнод монголын хээрийн тойрогт хамаарах хэдий ч тэгш тал, дэрс улалж бүхий хөндийн цайдам тойром бүхий говь гэх мэт экосистемийн олон янз байдлыг агуулж байдаг. Тус экосистем нь зүйлийн олон янз байдлаар(амьтан ургамлын зүйл) арвин. Энд хөхтөн амьтдын 31 зүйл, хоёр нутагтан мөлхөгчдийн 5 зүйл, Шувуудын 76 зүйл, шавжийн 1317 зүйл ургамлын хувьд тойргийн хэмжээнд 900 гаруй судалгааны талбайн хувьд 300 гаруй зүйл тархсан байна. Эдгээр амьтан ургамлын зүйл нэг бүрд чиглэсэн хамгааллын төлөвлөгөө боловсруулах боломжгүй. Тиймээс биологийн олон янз байдлын төлөөлөл сонгох зарчмыг баримтлан 8 зүйлийг төлөөлөл болгон сонгосон.

4. Талуудын оролцоог хангах: Талуудын оролцоог хангах үүднээс орон нутгийн байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны байгууллагууд болох Дорнод аймгийн ЗДТГ, Дорнод аймгийн БОГ, Дорнод хамгаалалтын захиргаа, Халхгол сумын ЗДТГ, Матад Сумын ЗДТГ, Буйр мэнэнгийн сав газрын захиргаа, Нөмрөгийн ДЦГ хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагуудад албан тоот хүргүүлж шинээр боловсруулах дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд тусгах ажилд санал авсан. Дээрх байгууллагуудаас Дорнод хамгаалалтын захиргаа, Нөмрөг ДЦГ-ын хамгаалалтын захиргаа, Буйр мэнэнгийн сав газрын захиргаа гэсэн байгууллагууд бичгээр санал ирүүлснийг тайланд хавсаргасан. Ирүүлсэн саналуудаас хэрэгжих боломжтой, үр дүнг хэмжиж болохуйц, биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэхүйц арга хэмжээг дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөнд тусгасан .

5. Экологийн хувьд “ижил” буюу “дүйцэхүйц” байх: Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газрыг олборлолт явуулж байгаа талбайд ойр байрлалтай, экологийн хувьд ижил төстэй, талбайн хэмжээг нөлөөлөлд өртсөн талбайтай дүйцэхүйц байхаар тооцон Тосон уул XIX талбайн хувьд Их эрээний тал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

6. Дүйцүүлэн хамгаалал нь нөлөөлөлд өртсөн бүс нутагт хэрэгжих: Газрын тос олборлох Тосон уул XIX талбай нь Дорнод аймгийн Матад сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг иймээс дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газрыг Матад сумын нутагт сонгохыг эрмэлзсэн. Тосон – Уул XIX талбайн хувьд Матад сумын нутагт төслийн талбайгаас зүүн урд зүгт 25-50 км орчим зайд байрлах Дорнод Монголын ДЦГ –ын орчны бүсэд хамаарах Их эрээний тал орчмын 49646.7 га талбайд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө хэрэгжүүлэхээр болсон. Уг 7 чиглэл бүхий арга хэмжээг дотор нь 25 үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэхэд 1 жилийн хугацаанд 70686.8 \$ буюу өнөөгийн ханшаар 240,335,120 төгрөг, 5 жилд 353,434 \$ буюу өнөөгийн ханшаар 1,201,675.600 төгрөг зарцуулагдахаар байна.

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Д/д	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэгч	Биелэлт
1.	Газрын тос олборлох төслийг цахилгаанаар хангадаг түгээх шугамын хүчдэл хуваарилах зангилаанд хэт авианы шувуу үргээгч байршуулах.	2023 он	Төсөл хэрэгжүүлэгч	БОМТ хүрээнд хийгдсэн
2.	Төслийн талбайн ашиглалтгүй болсон авто зам болон тээврийн зам дагуу үүссэн олон салаа замыг хааж жил бүр тодорхой хэмжээнд хагалж сийрэгжүүлэх.	2023 он	Төсөл хэрэгжүүлэгч	БОМТ хүрээнд хийгдсэн
3.	Нутгийн иргэдэд дүйцүүлэн хамгааллын зорилго, хилийн шугамыг тодорхой танилцуулах,	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
4.	Дүйцүүлэн хамгаалах талбайн эргэлтийн цэгүүдийг тэмдэгжүүлэх. Самбар байршуулах	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
5.	Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах	2023 он	Төсөл хэрэгжүүлэгч	-
6.	Идэвхтэн байгаль хамгаалагчийг шаардлагатай багаж хэрэгслээр хангах (мотоцикл-1, дуран-1, байршил тогтоогч-1)	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
7.	Идэвхтэн байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
8.	ДХ талбайд орон нутгийн болон отрын мал нутаглуулахгүй байхаас гадна хадлангийн газар олгохгүй байх талаар сум орон нутагтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах.	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
9.	Цаг хүндэрсэн байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед зэрлэг амьтдад өвс тэжээл бэлтгэх.	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
10.	Нутгийн иргэдэд хог хаягдал, үнс нурам, тээврийн хэрэгслээс үүдэлтэй хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах сургалт зохион байгуулах, Сургалтын үеэр дүйцүүлэн хамгаалах талбай орчмын айл өрх, малчид болон хилийн заставууд, хамгаалалтын захиргаа, СЗДТГ гэх мэт байгууллагуудад түймэр унтраах, багаж хэрэгслээр хангах. Уг багаж хэрэгслийг ашиглах заавар зөвлөмжийг сургалтаар өгөх.	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

	<ul style="list-style-type: none"> <li>• Үлээгч төхөөрөмж-40ш</li> <li>• Цохилуур-40</li> </ul>			
11.	Тосон Уул XIX талбайд 2017-2022 оны дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөгөөр хэрэгжүүлсэн ажлуудыг сайжруулах, хөв цөөрмүүдэд хөдөлгөөн мэдрэгч бүхий автомат камер суурилуулж мониторингийг байнга хийх, үр дүнг БОМТ –ын биелэлтийн тайланд жил бүр тусгаж байх.	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
12.	Цагаан зээрт сансрын дохиолол бүхий хүзүүвч зүүн мэдээлэл цуглуулан шилжилт хөдөлгөөнийг нарийн тодорхойлох.	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
13.	Дүйцүүлэн хамгаалах талбайн махчин шувууд, жижиг хөхтөн, хоёр нутагтан амьтдын тархац байршил, зүйлийн бүрдэлийн судалгаа хийх	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+
14.	Дүйцүүлэн хамгаалах талбайд ургамлын мониторинг судалгаа хэрэгжүүлэх (Ховор ургамлын тархалт, тохиолдоц, зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийн өөрчлөлт)	2023 он	Менежмет хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллага	+

5.1 Газрын тос олборлох төслийг цахилгаанаар хангадаг түгээх шугамын хүчдэл хуваарилах зангилаанд хэт авианы шувуу үргээгч байршуулах.

2023 онд БХГ XIX талбайн цахилгаан дамжуулах шугамын хүчдэл хуваарилах зангилаанд хэт авианы шувуу үргээгч 876 ш байршуулсан. Энэ онд шувууны хорогдол гараагүй байна.



Зураг № 32. Хэт авианы шувуу үргээгч



5.2 Төслийн талбайн ашиглалтгүй болсон авто зам болон тээврийн зам дагуу үүссэн олон салаа замыг хааж жил бүр тодорхой хэмжээнд хагалж сийрэгжүүлэх.

Тосон-Уул XIX талбайн хуучин зам, эвдэрсэн, ашиглагдахгүй болсон 50 га талбайг хагалж сийрүүлэхээр “Дорнод теленет сүлжээ” ХХК-тай гэрээ байгуулан уг ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Баянхошууны боомд явдаг засмал замаас 21-р талбай руу салсан хуучин шороон замыг хагалаж сийрүүлсэн.

5.3 Нутгийн иргэдэд дүйцүүлэн хамгааллын зорилго, хилийн шугамыг тодорхой танилцуулах,


Нутгийн иргэдийн төлөөлөл, Матад сумын Засаг Даргатай уулзах уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Петрочайна Дачин тамсаг” ХХК-н “Тосон Уул” XIX талбай хурлын зааланд зохион байгууллаа. Ингэснээр орон нутгийн иргэд, малчид, төсөл хэрэгжүүлэгч хооронд дүйцүүлэн хамгаалалын зорилго, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрхэн хэрэгжүүлэх, хамтран ажиллах талаар нэгдсэн ойлголтонд хүрсэн чухал арга хэмжээ болсон. Энэ уулзалтаар нутгийн иргэдэд дүйцүүлэн хамгааллын зорилго, хилийн шугамыг тодорхой танилцуулсан болно.



Зураг № 33. Нутгийн иргэдэд танилцуулга хийж буй нь

### 5.3 Дүйцүүлэн хамгаалах талбайн эргэлтийн цэгүүдийг тэмдэгжүүлэн самбар байршуулах

Талбайн эргэлтийн цэгүүдийг тэмдэгжүүлэхдээ хайгуулын болон ашиглалтын талбайд эргэлтийн цэгийн шав тэмдэг тавьдаг шаардлагыг баримталсан. Ингэж тэмдэг байршуулснаар дүйцүүлэн хамгаалах талбайг отор нүүдлийн малын талхигдал, хадлан авах зэрэг өөр төрлийн нөлөөлөлөөс ангид байгалын унаган төрхөөрөө нь авч үлдэх боломж бүрдэнэ. Сонгосон талбайд 15 эргэлтийн цэг тэмдэгжүүлэв. Эргэлтийн цэгийн координатыг доор хүснэгтээр үзүүлэв. Мөн цаашид биологийн олон янз байдлыг хамгаалах, биотехникийн болоод байгаль хамгааллын ямар ажил явуулахад талбайн хил хязгаар тодорхой ойлгомжтой байна.



Зураг № 34. Самбар байршуулж буй нь

### 5.4 Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах

Дүйцүүлэн хамгаалах талбайг хариуцсан ажиллах идэвхтэн байгаль хамгаалагчийг уулзалтанд оролцсон нутгийн иргэдийн саналаар Матад сумын Эрдэнэбадрах баг Лагийн нуур орчмоор нутагладаг малчин С.Энхмөнхийг сонгож нэг жилийн хугацаатай туслах ажилтны гэрээ байгуулсан.

### 5.5 Идэвхтэн байгаль хамгаалагчийг шаардлагатай багаж хэрэгслээр хангах (мотоцикл-1, дуран-1, байршил тогтоогч-1)

ДХ талбайг хариуцан ажиллахаар сонгогдсон Т.Энхмөнх болон уулзалтанд оролцсон хүмүүст биологийн олон янз байдал, Байгаль хамгаалагчийн гүйцэтгэх үүргийн талаар анхан шатны мэдлэг олгох, Төслөөс олгосон тоног төхөөрөмжийг (мотоцикл-1, дуран-1, байршил тогтоогч-1) ашиглах зааварчилгаа өгөх гэсэн агууллагын хүрээнд танхимийн болон практик сургалт явуулсан.



Зураг № 35. Идэвхтэн байгаль хамгаалагчид мотоцикл-1, дуран-1, байршил тогтоогч-1 гардуулж буй нь

#### 5.6 Идэвхтэн байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах

Байгаль хамгаалах ажилд судалгаа их чухал байдаг. Учир нь, тухайн газар нутгийн байгалийн онцлог, амьтны тоо, биологийн зүйлүүдийн уялдаа холбоог мэдэж авснаар хамгааллын оновчтой аргыг сонгох боломж бүрддэг юм. Энэ ажилд байгаль хамгаалагчдын үүрэг их байдаг бөгөөд мониторинг судалгааны арга зүйд суралцсан байх нь давуу тал болдог. Сургалтыг “ЕАСС” ХХК-ийн амьтан судлаач зохион байгуулав.

#### 5.7 ДХ талбайд орон нутгийн болон отрын мал нутаглуулахгүй байхаас гадна хадлангийн газар олгохгүй байх талаар сум орон нутагтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах.

Уулзалтын үеэр Менежмент хэрэгжүүлэгч мэрэгжлийн байгууллага болон багын засаг зарга хороонд дүйцүүлэн хамгаалах талбайн эргэлтийн цэгүүдийг зөвшилцөх, цаашид ДХ талбайд хадлангийн талбай олгохгүй байх, отор нүүдийн мал бүхий иргэдийг оруулахгүй байх талаар ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. Уг уулзалтанд Матад сумын Засагд дарга Д.Баттулга Эрдэнэбадрах багын дарга Б.Амгалан нарын бүрэлдэхүүнтэй 9 хүн оролцсон.



Зураг № 36. Матад сумын төлөөлөгч нар

5.8 Цаг хүндэрсэн байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед зэрлэг амьтдад өвс тэжээл бэлтгэх.

Дорнод монголын хээрт өвс тэжээлийн хүрэлцээ хангалтай, өвсөн тэжээлтэн мэргчид болон туруутан амьтад өлдөх, хорогдох тохиолдол маш бага байдаг хэдийч болзошгүй эрсдэл болох их хэмжээ цас унаж нарийн өвс хунгарт дарагдах, хавар эрт их хэмжээний талбайг хамарсан хээрийн түймэр дэгдэж бэлчээр нутаг шатдаг энэ үед цагаан зээр болон өвсөн тэжээлтэн амьтдад өвс тавиж өгөх зорилгоор 300 бодол өвс бэлтгэн хүлээлгэн өгөв.



Зураг № 37. Зэрлэг амьтдад бэлдсэн өвс тэжээл.

5.9 Нутгийн иргэдэд хог хаягдал, үнс нурам, тээврийн хэрэгслээс үүдэлтэй хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах сургалт зохион байгуулах, Сургалтын үеэр дүйцүүлэн хамгаалах талбай орчмын айл өрх, малчид болон хилийн заставууд, хамгаалалтын захиргаа, СЗДТГ гэх мэт байгууллагуудад түймэр унтраах, багаж хэрэгслээр хангах. Уг багаж хэрэгслийг ашиглах заавар зөвлөмжийг сургалтаар өгөх.

Петрочайна Дачин тамсаг ХХК-н газрын тос олборлох бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон Уул XIX талбайн Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах явцад биологийн олон янз байдалд байдалд, тус экосистемийн шүхэр зүйл болох Хялган хээр, Цагаан зээрэнд хүчтэй нөлөө үзүүлэх аюул заналыг Миради программ хангамжийн тусламжтайгаар тооцооход ой хээрийн түймэр хамгийн өндөр хувьтай гарсан тиймээс Дүйцүүлэн хамгаалах талбайд гал түймэр гаргахгүй байх, ойр орчим гал түймэр гарсан тохиолдолд гал түймрийг цаг алдалгүй унтраах нь хамгаас чухал тиймээс дүйцүүлэн хамгаалах талбайд хамгийн ойр байрлах Матад сум ЗДТГ болон Эрдэнэбадрах багын малчин иргэдэд гал түймэр унтраах багаж хэрэгсэл гардуулан өгч тоног төхөөрөмж хүлээлцэх актанд талууд гарын үсэг зурав.

- |                          |                         |
|--------------------------|-------------------------|
| Үүнд :                   | Мэнэнгийн цэргийн анги: |
| 1. Үлээгч-30 шигхэг      | 1. Үлээгч-5 ширхэг      |
| 2. Цохиур- 30 ширхэг     | 2. Цохиур-5 ширхэг      |
| 3. Тросон шүүр-30 ширхэг | 3. Тросон шүүр-5 ширхэг |



Зураг № 38. Матад сумын засаг даргад галын багаж хэрэгсэл гардуулж буй нь

5.10 Тосон Уул XIX талбайд 2017-2022 оны дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөгөөр хэрэгжүүлсэн ажлуудыг сайжруулах, хөв цөөрмүүдэд хөдөлгөөн мэдрэгч бүхий автомат камер суурилуулж мониторингийг байнга хийх, үр дүнг БОМТ –ын биелэлтийн тайланд жил бүр тусгаж байх.

Автомат камерыг тодорхой цэгт тавихдаа тухайн зориулан тавьж буй амьтны өндрийн хэмжээ, мөн камерын гэрэл, дулаан мэдрэгчийн чиглэл, харц, түүний нарны гэрлийн шууд тусгалд өртөх байдал, салхины чиглэл, тухайн орчны ургамалжилтын байдал, ялангуяа өндөр ургасан өвс ургамал салхинд хөдөлснөөр автомат камерт дан ургамлын зураг бичигдэж, камерын SD картыг дор нь дүүргэх магадлал өндөр байдаг зэрэг олон талын эрсдэлийг бодолцон үзэж байршуулах шаардлагатай. Бид хээрийн бүсэд автомат камер байршуулах тул өвсний хөдөлгөөнийг мэдрэхээргүй тулгуур бүхий хайрцаг урьдчилан бэлтгэсэн.

Хүснэгт. 13 19-р талбай автомат камер байршуулсан цэгийн координат

1	Дүйцүүлэн хамгаалах талбайд	116.324	46.95239
2	Хөв цөөрөм байгуулсан цэгт	116.6412	46.67123



Зураг № 39. Автомат камерт өртсөн цагаан зээрийн сүрэг

Төхөөрөмж тус бүрийн сүүлийн 3 байршлын цэг [Google Map] [Энгийн цэг нэмэх]



5.11 Цагаан зээрт сансрын дохиолол бүхий хүзүүвч зүүн мэдээлэл цуглуулан шилжилт хөдөлгөөнийг нарийн тодорхойлох.

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн газрын тос олборлох үйл ажиллагаа явуулж буй дорнод монголын хээрийн шүхэр зүйл нь цагаан зээр байдаг. Umbrela species буюу шүхэр зүйл гэдэг нь тухайн экосистемдээ чухал байр суурь эзэлдэг, өргөн уурам орон зайд тархсан зүйлийг хэлдэг. Иймээс дорнод монголын хээрт байгаль хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлэхдээ цагаан зээрийг голлон анхаарах шаардлагатай. Тосон уул XIX талбайн 2023 онд хэрэгжүүлэх дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд цагаан зээрийн нас хүйсийн ялгаатай 10 бодьгалд сансарын бүхий дохиолол бүхий дамжуулагчтай хүзүүвч зүүн тус бүс нутгийн зээрийн шилжилт хөдөлгөөн, тархац нутгийн хэмжээ төслийн үйл ажиллагаатай давхацдаг эсэх, цаашид дүйцүүлэн хамгааллын хүрээнд хийгдэх ажлуудыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой ажил болсон. Цагаан зээр хүзүүвчлэх ажлыг “ЕАСС” ХХК-ийн судлаачид болон “Их нартын байгалын нөөц газрын хамгаалалтын захиргааны хамт олонтой хамтран хэрэгжүүлэлээ. Олсоор хийгдсэн нэг бүр нь 1.5 метрийн өндөртэй, 300 м урттай 30 ширхэг торыг холбон тухайн үед бидэнд харагдах зээрийн сүргээс тор харагдахгүй хэмжээний зайд байршуулсан. Энэхүү тор нь олсоор хийгдсэн учир амьтны биед механик гэмтэл учруулахгүй. Торыг татахдаа амьтан ирээд мөргөх үед тор амархан унах нөхцөлийг тооцоолон шонгуудыг газарт гүехэн суулгаж, торыг сул татсан.



Зураг № 40. Зэрлэг амьтан барихад



Зураг № 41. Цагаан зээрэнд хүзүүвч зүүж буй нь

5.12 Дүйцүүлэн хамгаалах талбайн махчин шувууд, жижиг хөхтөн, хоёр нутагтан амьтдын тархац байршил, зүйлийн бүрдэлийн судалгаа хийх.

2023 оны 6, 7 дугаар сард махчин шувууд, жижиг хөхтөн, хоёр нутагтан амьтдын тархац байршил, зүйлийн бүрдэлийн судалгааг хийж гүйцэтгэсэн. (Хавсралт 10)



Зураг № 42. Дүйцүүлэн хамгаалах талбай 1-д тэмдэглэгдсэн дагуур зурам. 2023.07.01



Зураг № 43. Бүс нутгийн үндсэн туруутан цагаан зээр. 2023.07.01



Зураг № 44. Дүйцүүлэн хамгаалах талбайд тохиолдсон өвөгт тогоруу. 2023.06.30



Зураг № 45. Монгол гүрвэл нь тус нутгийн түгээмэл мөлхөгч. 2023.07.01

5.13 Дүйцүүлэн хамгаалах талбайд ургамлын мониторинг судалгаа хэрэгжүүлэх (Ховор ургамлын тархалт, тохиолдоц, зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийн өөрчлөлт)

2023 оны 6, 7 дугаар сард ургамлын мониторинг судалгааг (Ховор ургамлын тархалт, тохиолдоц, зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийн өөрчлөлт) хийж гүйцэтгэсэн. (Хавсралт 10)

### **ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уг төсөл нь үндсэндээ 1998 оноос хойш хэрэгжиж байгаа төсөл бөгөөд хэрэгжиж буй газар нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарагддаг тул газар олголт шинээр хийгдэх тохиолдолд Матад сумын газрын даамал БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын захиргаанаас тухайн хүсэж буй газар газрын тосны хайгуул, олборлолт, технологи үйл ажиллагаатай давхцаж буй эсэх талаар лавлан газар олголт хийгддэг тул нүүлгэн шилжүүлэлт хийгдэх ажил гардаггүй болно. Зайлашгүй шаардлагаар нүүлгэн шилжүүлэлт хийгдэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд цаг алдалгүй нүүлгэн шилжүүлэлт хийгдэх ажлыг компани өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх төлөвлөгөөтэй ажилладаг ба 2023 онд нүүлгэн шилжүүлэлт хийгдэх шаардлага гараагүй болно.

### **ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Манай компани нь 2010-2011 онуудад Шинжлэх ухааны академи, Архелогийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээт XIX, XXI талбайд хайгуул судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн. Матад, Халхгол сумдын нутаг ДАТАМО ХХК-ний гэрээт талбайд явуулсан хайгуул судалгааны ажлын үр дүнд нийт 160 гаруй дурсгал илрүүлж холбогдох баримтжуулалтыг хийж байршлыг тогтоосон байна. Компаний зүгээс газрын тосны хайгуул, өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн түүх соёлын дурсгал илэрсэн тохиолдолд тухайн талбайд газар шорооны болон газрын тосны өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагааг зогсоож Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу ГТГ, ШУА-ийн Археологийн хүрээлэнд мэдэгдэж, мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах, малтлага судалгааны ажлыг хийлгэж, холбогдох байгууллагаас зохих зөвшөөрөл авсаны үндсэн дээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллах төлөвлөгөөтэй байдаг бөгөөд 2023 онд хайгуул, өрөмдлөгө, бүтээн байгуулалтын ажлын явцад ямар нэгэн түүх, соёлын өв олдоогүй болно.



**НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хүснэгт 14. Осол, эрсдэлийн төлөвлөгөөний хураангуй

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжилт
1	Аюултай бодис асгарах	Химийн бодисыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах	TA1 байгууламжийн, Өрмийн 3 ангийн, Цагаан хэрмийн ангийн, Дачингийн шингэн хагалгааны ангиудын химийн бодисын агуулахуудад	БХГ-т Тосон Уул XIX талбайд ашиглагддаг химийн бодис 3 төвлөрсөн агуулахад хадгалдаг бөгөөд ашиглалт, хадгалалтын явцад өдөр тутам хяналт тавьж улмаар Дорнод аймгийн Онцгой байдлын газраар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ашиглах төлөвлөгөөг” батлуулан ажилласан.
2	Тос асгарах	Тосны асгаралт гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч асгаралтыг зогсоон асгарсан тосыг шуурхай цэвэрлэх	TA1 байгууламж, хувиарлах, тос усны цооног, далд шугам хоолойноос тос асгарах үед	БХГ-т талбайн олборлолтын технологи үйл ажиллагааны явцад тос асгарсан тохиолдол гараагүй бөгөөд харин олборлолтын үйл ажиллагааны явцад асгарсан тосыг тухай бүрт нь цэвэрлэж тостой шороо угаах үйл ажиллагаа явуулдаг “Эко Ургамал” ХХК-д хүлээлгэн өгч ажилласан болно.
3	Гал түймэр	Төслийн талбайд гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах	БХГэрээт талбайн олборлотын бүх барилга байгууламжууд цооногуудад	Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхээр бэлэн байдлыг ханган гал түймэр унтраах тоноглолыг захиалан авч бэлэн байдлыг хангаж ажилласан. 2023 онд БХГ-т талбай болоод түүний орчны бүсэд гарсан 7 тал хээрийн түймрийг үйлдвэрлэлийн баазын зүгээс унтрааж ажилласан.
4	Хяналтаас гадуурх дэлбэрэлт	Төслийн талбайн аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон тэсрэх бодистой холбоотой журмыг дагаж мөрдөнө.	Тэсрэх бодисын агуулах, цооног, ажилчдын байр сууц, тээврийн хэрэгсэл	БХГ-т талбайн олборлолтын цооногын үйл ажиллагаанд хэрэглэгддэг тэсрэх бодисыг Бласт Сэлэнгэ ХХК нийлүүлэн уг бодисын өдөр тутмын ашиглалт, хадгалалтанд хяналт тавьж ажилладаг ажилладаг.
5	Хүний эрүүл мэнд муудах	БХГэрээт талбайд хүний эрүүл мэнд муудахад үйлдвэрлэлийн баазын эмч тохирох арга хэмжээг авч шаардлагатай тохиолдолд дараагийн	Үйлдвэрлэлийн баазын талбай	БХГ талбайд өдөр тутамд хүний эрүүл мэндийн үзлэгийг үйлдвэрлэлийн баазын эмч үзлэг хийж тохирох эмчилгээг хийдэг бөгөөд гэнэтийн аваар ослын үед хүний эрүүл мэнд муудах яаралтай анхны тусламж үзүүлэн дараагийн шатны эмнэлэгт шилжүүлж ажилладаг.

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**


		шатлалын эмнэлэгт шилжүүлнэ.		
6	Автомашинны осол гарах	Замын хөдөлгөөний дүрэм, тээврийн хэрэгсэл жолоодох шаардлагуудыг биелүүлэх	Үйлдвэрлэлийн баазын талбай	БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудын жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдох дүрэм, журмыг танилцуулан сургалт хийж тогтмол хугацаанд тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтуудыг хийж ажилласан.

8.1 Аюултай бодис асгарах

БХГ-т Тосон Уул XIX талбайд ашиглагддаг химийн бодисыг 3 төвлөрсөн агуулахад (Олборлолтын ТА1 байгууламжийн химийн бодисын агуулах, Өрмийн 3-р ангийн химийн бодисын агуулах, Цагаан хэрмийн химийн бодисын агуулах) хадгалдаг бөгөөд ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн явцын өдөр тутмын үйл ажиллагаанд химийн бодис нийлүүлдэг аж ахуй нэгжүүд болоод тэдгээрийн химийн бодис хариуцсан ажилтан хяналт тавьж ажилладаг. 2023 онд БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын зүгээс Дорнод аймгийн Онцгой байдлын газраар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ашиглах төлөвлөгөөг” батлуулан мөрдлөг болгон ажилласан. ТА1 байгууламжийн химийн бодисын агуулахад химийн бодисын асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлэн шингэн химийн бодис хадгалдаг хэсэгт асгаралт үүссэн тохиолдолд асгаралтын худаг шинээр барьж байгуулсан.



Зураг № 46. Та1 байгууламжийн химийн бодисын агуулахад аваарын худаг хийсэн байдал



Зураг № 47. Гамшигаас хамгаалах төлөвлөгөө, химийн бодисын ослын төлөвлөгөө

## 8.2. Тос асгарах

БХГ-т талбайн олборлолтын технологи үйл ажиллагааны явцад тос асгарсан тохиолдол гараагүй бөгөөд харин олборлолтын үйл ажиллагааны явцад асгарсан тосыг тухай бүрт нь цэвэрлэж тостой шороо хүлээн авах, цэвэршүүлэх үйл ажиллагаа явуулдаг “Эко Ургамал” ХХК-д хүлээлгэн өгч ажилласан болно.



Зураг № 48. “Эко Ургамал” ХХК-н цэвэршүүлсэн шороо

### 8.3 Гал түймэр

Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үүднээс нийт ажилчдад объектын болон хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлын тухай танхимын болон практик сургалтыг зохион байгуулсан бол гал түймрийн бэлэн байдлыг хангах үүднээс гал түймэр унтраах тоноглолыг захиалан авч бэлэн байдлыг хангаж ажилласан. 2023 онд БХГ-т Тосон Уул ХИХ талбайн үйлдвэрлэлийн баазын зүгээс Дорнод аймгийн Онцгой байдлын газраар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ашиглах төлөвлөгөөг” батлуулан мөрдлөг болгон ажилласан. 2023 онд БХГ-т талбай болоод түүний орчны бүсэд гарсан 7 тал хээрийн түймрийг үйлдвэрлэлийн баазын зүгээс унтрааж ажилласан.



Зураг № 49. Гал түймрийн аюулаас сэргийлэх сургалт



Зураг № 50. Галын багаж хэрэгсэл хүлээж авч буй байдал

**8.4 Хяналтаас гадуурх дэлбэрэлт**

БХГ-т талбайн олборлолтын технологи үйл ажиллагааны явцад өдөр тутамдаа ажлын байранд хэлтэс нэгжүүдийн менежерүүд хяналт тавьж ажилладаг бол үйлдвэрлэлийн баазын зүгээс талбайн ЭМААБО-ны хэлтэс давхар хяналт тавьж ажилладаг. БХГ-т талбайд олборлолтын цооног үйлчилгээний хэрэглэгддэг тэсрэх бодисыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн эрх бүхий байгууллага болох “Бласт Сэлэнгэ” ХХК нийлүүлдэг ба уг бодисын өдөр тутмын ашиглалт, хадгалалтанд хяналт тавьж ажилладаг ажилладаг. 2023 оны тайлант жилийн хугацаанд дээрх аюул осол гараагүй болно.

**8.5 Хүний эрүүл мэнд муудах**

БХГ талбайд үйлдвэрлэлийн баазын ажилчид болоод гэрээлэгч ангиуд, айд өрхүүдийн хүн амын эрүүл мэндийн үзлэгийг үйлдвэрлэлийн баазын эмч үзлэг хийж тусламж үйлчилгээг өдөр тутамдаа үзүүлж ажилладаг бол гэнэтийн аваар осол гарч хүний эрүүл мэнд муудсан тохиолдолд яаралтай анхны тусламж үзүүлэн дараагийн шатны эмнэлэгт шилжүүлж ажилладаг. 2023 оны тайлант жилийн хугацаанд гэнэтийн аваар осол гарсан тохиолдол бүртгэгдээгүй болно.

**8.6 Зам тээврийн осол аваар гарах**

Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын захиргааны зүгээс БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудын жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдох дүрэм, журмыг мөн Авто тээврийн үндэсний төвтэй хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдал болоод хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх сургалтуудыг авч яриа таниулгыг хийж ЭМААБО-ны хэлтсийн зүгээс тогтмол хугацаанд тээврийн хэрэгсэлд аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтуудыг хийж ажилласан.



Зураг № 51. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт

**ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хураангуй

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжилт
1	Ахуйн хатуу хог хаягдал	Үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	БХГ-т талбай нь хог хаягдалыг ангилан ялгах, давир бүтээгдэхүүнийг нийлүүлэх, булшлах зэрэг үйл ажиллагааг “Матад БЭШН”ХХК-тай гэрээ байгуулан ажиллалаа
2	Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал	Дээж авч шинжилгээнд өгч байгууламжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.	Улирал тутамд дээж авч Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн сорилтын лабораторид шижлүүлсэн.
3	Ахуйн шингэн хаягдал	Тосоор бохирдсон хөрсийг цэвэршүүлэх	2023 Мэргэжлийн эрх бүхий “Эко Ургамал” ХХК-тай гэрээ байгуулж тосоор бохирдсон хөрсийг цэвэршүүлэн ажиллаж байна.
4	Тосоор бохирдсон хөрс		


Манай компаний хог хаягдлын менежментийн зорилго нь газрын тос олборлох төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн хог хаягдлыг дахин ашиглах улмаар эх үүсвэр дээр нь ангилж хадгалан боловсруулах цэгт хүргэх, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэх, бүх шатанд хог хаягдал хамгийн бага гарах бололцоог хангах, түүнийг бууруулах, хог хаягдлыг байгаль орчинд тархахаас сэргийлэх, хоргүй, аюулгүй хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа юм.

БХГ-т талбайн хог хаягдлыг ангилан ялгах, дахивар бүтээгдэхүүнүүдийг нийлүүлэх, булшлах зэрэг үйл ажиллагааг “Матад БЭШН”ХХК - тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн.

Талбай дээр үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудын хогийн цэгийн тохижилт, хадгалалт, тээвэрлэлтийг Үйлдвэрлэлийн баазын дэд захиралын 2018.08.21-ны өдрийн 18/01 журам 3 дугаар хавсралтын дагуу зохицуулан хийж гүйцэтгэдэг болно.

### 9.1 Ахуйн хатуу хог хаягдал

2022 оны 7 дугаар сард ахуйн хог хаягдлын ландфиллийн нүхийг шинээр бэлтгэж хашаажуулан ашиглалтанд оруулсан. Ахуйн хогийг ангилан 240 м.куб кардон хайрцаг ялгаж шатаах зуухаар шатаасан. 80 м.куб хуванцар сав, 15 м.куб шил зэргийг ялган авч, гар аргаар нягтруулан савлаж, овор хэмжээг нь багасган, дахин ашиглалтанд бэлтгэж, хог хаягдлын талбайгаас Чойбалсан, Улаанбаатар хот руу тээвэрлэв. Ахуйн 896 м.куб хогийн дарж булшилсан.



Зураг № 52. Хатуу хог хаягдлыг шийдвэрлэж буй байдал

### 9.2 Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал


“Петрочайна дачин тамсаг” ХХК-ний БХГ-т Тосон-Уул XIX талбай нь газрын тосны хайгуул, өрөмдлөг, олборлолтын үйл ажиллагаанд хэрэглэгдсэн химийн бодисын сав баглаа боодол, даралт нь унасан галын хор зэргийг химийн бодисын сав баглаа боодол устгадаг мэргэжлийн эрх бүхий “Түмэн Эгшиг” ХХК-тай гэрээ байгуулан хүлээлгэн өгч устгуулахаар ачуулж ажилласан. 2023 оны 5-р сарын 9-с 5 р сарын 15-ний өдөр хүртэл хугацаанд нийт 4

## БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

удаагийн шланз автотээврийн хэрэгслээр Дорнод аймгийн Матад сумын 19-р талбайгаас Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багт байрлах Түмэн-Эгшиг ХХК-н “Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол дахин боловсруулах Эко үйлдвэр”-н аюултай хог хаягдлыг түр хадгалах талбайд батлагдсан маршрутын дагуу тээвэрлэн зөөж буулгасан болно. 2023 оны 5 дүгээр сарын 9-с 5-р сарын 24 хүртэл хугацаанд устгалын ажлыг зохион байгуулан ХАБЭА-болон стандарт дүрэм журмын дагуу Аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд байгаль орчинд халгүй арга технологиор саармагжуулж, хоргүйжүүлэн пиролизийн тусгай зууханд задалж, шатааж, дахин боловсруулж устгасан болно.



Зураг № 53. Аюултай хог хаягдлыг устгаж буй байдал



**“Петрочайна дачин тамсаг” ХХК-н XIX талбайн устгах шаардлагатай хог хаягдал хүлээлгэж өгсөн хуудас**

Тосон-Уул XIX талбай		2023.05.09			
№	Хог хаягдлын төрөл	Хэмжих нэгж	Ачигдсан хэмжээ	Тайлбар	Тээвэрлэсэн машины улсын дугаар
1	Арчих материал	тн	43,550	Хогийн төвлөрсөн цэг	30-97 УНИ
2	Арчих материал	тн	37,200	Хогийн төвлөрсөн цэг	19-37 УЕЕ
3	Арчих материал	тн	42,300	Хогийн төвлөрсөн цэг	09-21 УАР
4	Арчих материал	тн	42,900	Хогийн төвлөрсөн цэг	26-51 УБН
5	<b>НИЙТ ДҮН</b>	тн	<b>165,950</b>		

Хүлээлгэж өгсөн ЭМААБО-н ажилтан

Г.Нямсүрэн

Хүлээж авсан “Түмэн-Эгшиг ХХК-ны захирал

Г.Чинзориг

Хүлээж авсан “Түмэн-Эгшиг ХХК-ны менежер

Б.Одбаяр



Зураг № 54. Аюултай хог хаягдал хүлээлгэж өгсөн акт



**9.3. Ахуйн шингэн хаягдал**

Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламж нь 2010 онд ашиглалтанд орсон 125м3/хон хүчин чадалтай байсаныг 2019 онд Престиж инженеринг ХХК-тай гэрээ байгуулан өргөтгөл засвар, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн 175м3/х болгон хүчин чадлыг нэмэгдүүлсэн ба байгууламж нь газар дор байрлуулсан тус бүр нь 3 тасалгаатай шүүх систем бүхий 40 тн-ийн 5 танк, шингэн ууршуулах 2 далан (ээлжээр хэрэглэдэг), лаг хаях нэг жижиг далангаас бүрдэнэ. Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжийг байнгын манаачтай байлгаж уг байгууламжинд буулгаж буй шингэн хаягдлыг бүртгэн уг байгууламжийн өдөр тутмын арчлалт, засвар үйлчилгээг хийн ажиллаж байна. 2023 онд нийт 11476 тн бохирыг буулгаж цэвэршүүлсэн байна. Улирал тутамд дээж авч Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн сорилтын лабораторид шижлүүлсэн.



**Зураг № 55. Ахуйн бохир ус цэвэрлэх**

**4502.4.16/М**

**САНХААГИЙН СТАНДАРТ ХӨМЖИЛ ЗҮЙН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ**

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**  
CERTIFICATE OF ANALYSIS

**Бүртгэлийн дугаар** 22-74  
**Шалгахтай холбоотой хураат гаргасан өдөр** / **Петро Чайна Дачин Тамсаг** ХХК / 19-р хороо

**Байдалгачийн нэр** Д.Д. Лабораторийн нэр  
**Дал** / **Хийгч** / **Хэрэглэгч** / **Төрөл** / **Төрөл** / **Төрөл**

Дал	Далын нэр	Хийгчийн нэр	Хэрэглэгчийн нэр	Хэрэглэгчийн үйлдвэр	Хэрэглэгчийн үйлдвэр	Хэрэглэгчийн үйлдвэр
248	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч
249	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч
250	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч

**Санаат тэйлбар:**

**БАТАРСАН ЛАБОРАТОРИЙН** ЭРХЭЦЭГ

**4502.4.16/М**

**САНХААГИЙН СТАНДАРТ ХӨМЖИЛ ЗҮЙН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ**

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**  
CERTIFICATE OF ANALYSIS

**Бүртгэлийн дугаар** 22-74  
**Шалгахтай холбоотой хураат гаргасан өдөр** / **Петро Чайна Дачин Тамсаг** ХХК / 19-р хороо

**Байдалгачийн нэр** Д.Д. Лабораторийн нэр  
**Дал** / **Хийгч** / **Хэрэглэгч** / **Төрөл** / **Төрөл** / **Төрөл**

Дал	Далын нэр	Хийгчийн нэр	Хэрэглэгчийн нэр	Хэрэглэгчийн үйлдвэр	Хэрэглэгчийн үйлдвэр	Хэрэглэгчийн үйлдвэр
248	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч
249	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч
250	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч	Хийгч

**Санаат тэйлбар:**

**БАТАРСАН ЛАБОРАТОРИЙН** ЭРХЭЦЭГ

**Зураг № 56. Шинжилгээний хариу**

#### 9.4. Тосоор бохирдсон хөрс

Газрын тос олборлох үйл ажиллагааны үед технологийн доголдол болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр газрын тос хөрсөнд хаягдан бохирдол үүсгэдэг. Ингэж үүсгэсэн бохирдолыг хусч цэвэрлэн тостой шороо хүлээн авах цэгт буулгадаг. Тосоор бохирдсон шороог хүлээн авах, цэвэршүүлэх ажлыг 2023 онд “Эко Ургамал” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлж байна. 2023 онд 3223 м.куб бохирдсон шороог тус компани цэвэршүүлээд байна. Мөн тус компанийн цэвэршүүлсэн шорооноос дээж авч Байгаль орчны төв лабораторид шинжлүүлсэн.



Зураг № 57. Тосоор бохирдсон шороог угааж буй нь



Зураг № 58. “Эко Ургамал” ХХК-н цэвэршүүлсэн шороо

## **АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

Газрын тос олборлох үйл ажиллагааны явцад агаар, хөрсөн бүрхэвч, усан орчин, ургамлан нөмрөгт үзүүлж буй сөрөг нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтүүдийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээг төлөвлөх зорилгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Петровичайна дачин тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын зүгээс уг ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн эрх бүхий байгууллага болох “Цавчирын Хөндий” ХХК-тай гэрээ байгуулан хээрийн судалгааг 2023 оны 6, 8, 9 дүгээр саруудад хийж гүйцэтгүүлсэн.


### **1. АГААРЫН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

“Петровичайна Дачин Тамсаг” ХХК-ний Дорнод аймгийн Матад сумын нутагт байрлах Тосон-Уул XIX талбайд 2023 оны агаарын чанарын орчны хяналт шинжилгээний хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. 6 болон 9-р сарын агаарын шинжилгээг Сүхбаатар ус уаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лаборатори, 8-р сарын агаарын шинжилгээг Цаг уур орчны шинжилгээний газар байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторит сорилтын дүнг боловсруулсан. Хэмжилт, дээжлэлтийг төсөл хэрэгжүүлэгчээс өгсөн 15 цэгт хийж гүйцэтгэсэн. Мөн нарийн ширхэглэгт тоосонцор /PM2.5/, том ширхэглэгт тоосонцор /PM10/ үзүүлэлтийг MNS 4585:2016 стандартын дагуу 24 цагийн хэмжилт хийх шаардлагатай байдаг тул 19-3 олон замын уулзвар, Бичигтийн боомт явах зам дагуу 5 км, Баянхошуу чиглэлийн автозам 20 км-т гэсэн 3 цэгт 6-р сар болон 8-р саруудад хэмжсэн. 6-р сарын орчны хяналт шинжилгээний агаарын хэмжилтийн үед орчны байдал 5-10м/сек, үүлэрхэг, газрын гадарга 6-р сарын 29-ны өдөр чийгтэй, 6-р сарын 30-нд хуурай, температур 17-26 градус, төслийн үйл ажиллагаа явагдаж байсан бөгөөд шинжилгээ авах үед хөдөлгөөнтэй байсан. Хувиарлах байгууламж, шингэн хаягдал, ахуйн бохир, цооног орчимд үл мэдрэгдэх болон мэдрэгдэхүйц үнэртэй байсан бол 9-р сарын орчны хяналт шинжилгээний үед орчны байдал тогтуун салхигүй тогтуун, газрын гадарга чийгтэй, өдөртөө 16-20 градусын дулаан, үйл ажиллагаа хэвийн явагдаж байсан.



Зураг № 58. Агаар орчны шинжилгээ хийж буй нь

# БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023



Зураг № 59. Агаарын мониторингийн цэгийн байршил




График2. Дуу шуугианы үзүүлэлт




График 3. 2021-2023 оны дуу шуугианы хэмжилтийн дүн, дБа

2021-2023 оны дуу шуугианы хэмжилтээр 27-64.3 дБа байна. 2021 оны хэмжилтээр 19M-A-4 (Бичигтийн боомт явах зам дагуу 5 км) цэгт 64.3 дБа, 19M-A-9(1-9 дэд станц) цэгт 61.2 дБа, 19M-A-11 (Баянхошуу чиглэлийн автозам 20 км) цэгт 64.4 дБа утгатай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2016 стандарт өдрийн цаг(07-22 цаг)-ын 60 дБа-ын утгыг давсан байна. Бусад мониторингийн цэгийн хэмжилтээр агаарын чанарын стандарт давсан утга байхгүй.

## БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023

Хүснэгт 16. 2021-2023 оны нийт тоосонцорын агууламж

Нийт тоосонцор								
№	МЦ	2021 он	2022 он		2023 он			MNS4585:2016
			зун	намар	6-р сар	8-р сар	9-р сар	
1	19M-A-1	0.001	0.009	0.022	0.013	0.088	0.002	0.5
2	19M-A-2	0.003	0.018	0.034	0.049	0.064	0.004	0.5
3	19M-A-3	0.003	0.021	0.108	0.067	0.072	0.033	0.5
4	19M-A-4	0.002	0.038	0.042	0.086	0.070	0.012	0.5
5	19M-A-5	0.003	0.009	0.048	0.022	0.090	0.004	0.5
6	19M-A-6	0.001	0.011	0.03	0.022	0.072	0.005	0.5
7	19M-A-7	0.002	0.013	0.029	0.059	0.090	0.002	0.5
8	19M-A-8	1.280	0.008	0.03	0.030	0.119	0.003	0.5
9	19M-A-9	0.001	0.027	0.048	0.012	0.098	0.003	0.5
10	19M-A-10	0.001	0.023	0.033	0.042	0.068	0.004	0.5
11	19M-A-11	0.002	0.034	0.051	0.047	0.107	0.004	0.5
12	19M-A-12	0.139	0.01	0.043	0.026	0.070	0.006	0.5
13	19M-A-13	0.001	0.013	0.035	0.027	0.110	0.007	0.5
14	19M-A-14	0.002	0.034	0.05	0.014	0.240	0.005	0.5
15	19M-A-15	0.002	0.28	0.028	0.029	0.060	0.006	0.5
16	Сод монгол ШТС	0.002						0.5
17	1-16 явах зам	0.005						0.5
18	Шинэ кемп	0.029						0.5
19	Нэгдсэн байгууламжийн зүүн тал	0.029						0.5
20	Чойбалсан явах зам	0.028						0.5

Орчны хяналт шинжилгээний 2019-2023 оны тайлангийн агаарын шинжилгээний хариуг харьцуулж үзэхэд 2019 оны шинжилгээнд нийт тоосонцор хэмжигдээгүй, 2021 онд 19M-A-8 /Зүүн талын айлууд/ мониторингийн цэг дээр Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартын агаар дах нийт тоосонцорын 0.5 мг/м<sup>3</sup> агууламжийн утгаас 2.56 дахин их, харин бусад мониторингийн цэгт Агаарын чанарын стандарт утгаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.




График 4. 2021-2023 оны нийт тоосонцорын агууламж

2023 оны орчны дуу шуугианы хэмжилтийг мониторингийн цэгт 20 минутын хугацаатай хийсэн бөгөөд хэмжилтийн үеийн утга 27-55 дБа байна. Энэ нь Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартад заасан өдрийн цагаар (07-22 цаг) зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 60 дБа-аас хэтрээгүй байна. 2019 онд дуу шуугианы хэмжилт хийгдээгүй, 2021-2023 оны дуу шуугианы хэмжилтээр 27-64.3 дБа байна. 2021 оны хэмжилтээр 19М-А-4 (Бичигтийн боомт явах зам дагуу 5 км) цэгт 64.3 дБа, 19М-А-9(1-9 дэд станц) цэгт 61.2 дБа, 19М-А-11 (Баянхошуу чиглэлийн автозам 20 км) цэгт 64.4 дБа утгатай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2016 стандарт өдрийн цаг(07-22 цаг)-ын 60 дБа-ын утгыг давсан байна. Бусад мониторингийн цэгийн хэмжилтээр агаарын чанарын стандарт давсан утга байхгүй. 2023 оны төслийн талбайд хэмжсэн агаар дахь тоосны хэмжилтийн үр дүнгээс харахад нийт тоосны хэмжээ 6-р сард 0.012-0.86 мг/м<sup>3</sup>, 8-р сард 0.060-0.24 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.002-0.033 мг/м<sup>3</sup> хооронд буюу “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 стандартаас бага байна. 6-р сар, 8-р сар, 9-р сарын хэмжилтийн үр дүнг харьцуулахад нийт тоос 9-р сарын утга хамгийн бага 8-р сарын агаарын хэмжилтийн утга 6 болон 9 дүгээр сартай харьцуулахад их байгаа боловч Агаарын чанарын стандарт 0.5 мг/м<sup>3</sup> утгаас давсан үзүүлэлт байхгүй байна. Харин 19-3 олон замын уулзвар орчимд Рm10 6-р сард 0.026 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.009 мг/м<sup>3</sup>, Рm2.5 6-р сард 0.019 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.008 мг/м<sup>3</sup>, Бичигтийн боомт явах зам дагуу 5 км-т Рm10 6-р сард 0.024 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.006 мг/м<sup>3</sup>, Рm2.5 6-р сард 0.018 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.004 мг/м<sup>3</sup>, Баянхошуу чиглэлийн автозам 20 км орчимд Рm10 6-р сард 0.018 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.003 мг/м<sup>3</sup>, Рm2.5 6-р сард 0.013 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.002 мг/м<sup>3</sup> буюу MNS4585:2016 стандартаас бага байна. Орчны хяналт шинжилгээний 2019-2023 оны тайлангийн агаарын шинжилгээний хариуг харьцуулж үзэхэд 2019 оны шинжилгээнд нийт тоосонцор хэмжигдээгүй, 2021 онд 19М-А-8 /Зүүн талын айлууд/ мониторингийн цэг дээр Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартын агаар дах нийт тоосонцрын 0.5 мг/м<sup>3</sup> агууламжийн утгаас 2.56 дахин их, харин бусад мониторингийн цэгт Агаарын чанарын стандарт утгаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. Орчны хяналт шинжилгээний нарийн ширхэгт тоосонцор 2019-2023 оны хэмжилтийн дүн тухайн жилийн хээрийн хэмжилтээс шалтгаалан мониторингийн зарим цэгүүд дээр нарийн ширхэгт тоосонцор хэмжигдээгүй байна. 2019 оны агаарын хэмжилтийн дүнгээр 19М-А-6(Дорнын их гэгээ), 19М-А-7(Нэгдсэн байгууламжийн ачилтын хэсэг) РМ10 тоосонцор, 2021 оны агаарын хэмжилтийн дүнгээр мониторингийн цэг 19М-А-10 (1-11 хувиарлахын буулгалт) РМ10 тоосонцор, 19М-А-8 (Зүүн талын айлууд) цэгт РМ10 болон РМ2.5 тоосонцрын хэмжээ Агаарын чанар.Ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартаас давсан үзүүлэлттэй байна. 2022 болон 2023 оны агаарын хэмжилтээр Агаарын чанарын стандарт давсан утга байхгүй. 2023 оны төслийн талбай дахь хүхэрлэг хий (SO<sub>2</sub>) хэмжилтийн үр дүнгээс харахад 6-р сард 0.004-0.022 мг/м<sup>3</sup>, 8-р сард 0.012-0.032 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.003-0.026 мг/м<sup>3</sup> хооронд буюу “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 стандартаас бага байна. Төслийн талбай дахь азотын давхар ислийн (NO<sub>2</sub>) хэмжилтийн үр дүнгээс харахад 6-р сард 0.021-0.055 мг/м<sup>3</sup>, 8-р сард 0.020-0.345 мг/м<sup>3</sup>, 9-р сард 0.026-0.065 мг/м<sup>3</sup> хооронд

буюу “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 стандартаас бага, зарим хэмжилтийн цэгүүд дээр стандарт утгаас давсан байна (График 2-8). 8-р сарын агаарын хэмжилтийн Петротранс, Зүүн талын айлууд Ахуйн бохир цэвэршүүлэх, 1-4 хувиарлахын ЦДАШ-ын цэгүүд дээр Агаарын чанарын азотын давхар ислийн стандарт утгаас давсан байна. Хүхэрлэг хий, Азотын давхар ислийн агууламж 2019 онд хийгдээгүй. 2021-2023 оны Агаарт агуулагдах хүхэрлэг хийн агууламж 0.002-0.228 мг/м<sup>3</sup> агууламжтай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2016 стандарт утга давсан үзүүлэлт байхгүй байна. Хэмжилтийн утга хамгийн өндөр гарсан нь 2021 оны агаарын хэмжилтээр 19М-А-8 ( Зүүн талын айлууд) цэгт 0.228 мг/м<sup>3</sup> илэрсэн боловч агаарт агуулагдах хүхэрлэг хийн агууламжийн стандартаас бага байна. 2021-2023 оны Агаарт агуулагдах азотын давхар ислийн агууламж 0.008-0.345 мг/м<sup>3</sup> агууламжтай байсан. 2023 оны 8-р сарын агаарын чанарын хэмжилтээр мониторингийн цэг 19М-А-5(Петротранс)-0.345 мг/м<sup>3</sup>, 19М-А-8(Зүүн талын айлууд)-0.21 мг/м<sup>3</sup>, 19М-А-13(Ахуйн бохир цэвэршүүлэх)-0.289 мг/м<sup>3</sup>-ын агууламжтай байсан нь Агаарын чанар. Ерөнхий шаардлага MNS4585:2016 стандарт утга давсан байна. Бусад мониторингийн цэгүүд дээр азотын давхар ислийн агууламж стандарт утга давсан үзүүлэлт байхгүй.




**2. УСАН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**

Газрын тос олборлох Тосон-Уул XIX талбайн 2023 оны усан орчны мониторингийн хээрийн судалгааны ажлыг 6-р сарын 29-31, 8-р сарын 09-10, 9-р сарын 28-29-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Хээрийн судалгааны үед усны дээж авах, тээвэрлэхдээ “Унд ахуйн хэрэгцээний, үйлдвэрийн ус хангамжийн зориулалттай ус. Химийн шинжилгээний дээж авах аргачлал” MNS 3934 : 1986, Усны чанар-Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж” MNS ISO 5667-11:2000 стандартын дагуу 1.5 л багтаамжтай цэвэр усны саванд авсан. Дээж авахдаа дээжийн савыг дээж авч буй эх үүсвэрийн усаар 2 удаа зайлж, савыг дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн явцад сэгсрэгдэх, хүчил төрөгчтэй тухайн дээж харилцан үйлчлэлд орохыг хязгаарлана. Дээжийг харанхуй, сэрүүн нөхцөлд хүйтэн баригч саванд хадгалж тээвэрлэсэн болно. Гүний усны ерөнхий химийн шинжилгээ (анион, катион, Ph, TDS, ES, физик үзүүлэлтүүд зэрэг)-ийг Газарзүй-Геозкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний магадлан итгэмжлэгдсэн лабораторид, хүнд элементийн шинжилгээг “Эс Жи Эс” ХХК-ийн олон улсын магадлан итгэмжлэгдсэн лабораторид 57 үзүүлэлтээр шинжилгээний холбогдох аргачлал, стандартын дагуу тус тус шинжлүүлсэн.



Зураг № 60. Усны дээж авч буй нь

# БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023



Зураг № 61. Усны мониторингийн цэгүүдийн байршил

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

Хүснэгт 17. 2023 оны усны ерөнхий хими-физикийн шинжилгээний үр

Үзүүлэлт	Нэгж	Стандарт	19W-W-1			19M-W-2			19M-W-3			19W-W-4			19W-W-12			19W-W-13		
			хавар	зун	намар	хавар	зун	намар	хавар	зун	намар	хавар	зун	намар	хава	зун	нама	хава	зун	нама
<b>Физик үзүүлэлтүүд</b>																				
Тунгалаг	см	-	-	30	0	30	30	30	30	20	28	30	30	30	27	15	26	29	25	29
Өнгө	-*-	20	-	Үгүй	Боршаргал	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Цайваршаргал	Сулшаргал	Үгүй	Үгүй	Үгүй	Цайваршаргал	Шар	Ногооншаргал	Цайваршаргал	Сулшаргал	Цайваршаргал
Тунадас	-	-	-	Үгүй	Улаан нунтаг шороон	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үл мэдэг	Элс шороо	Үгүй	Үгүй	Үгүй	Хөвсгөр шороон	Үл мэдэг	Хөвсгөр шороон	Үгүй	Үгүй	Үгүй
Булингаршил	NTU	5	-	0.53	295	0.02	2.76	0.12	0.6	8.89	16.8	0.12	2.76	0.18	5.75	12.36	8.75	3.31	4.53	4.35
Усны орчин, рН	-*-	6.5-8.5	-	7.53	7.59	6.85	6.69	6.7	7.39	7.99	8.13	6.9	6.9	6.76	7.54	8.01	8.12	7.42	7.45	7.84

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

ЕС	мСм/ см	1	-	56 52	6201	197 7	15 4	766	337 7	3230	3328	213	10 7	113	1006 0	168 0	1403	1715	9153	1150 8
<b>Химийн үзүүлэлт</b>																				
Cl <sup>-</sup>	мг/л	350	-	11 34	1093	389 .4	38 07	151. 9	596 .8	589.3	604.2	47. 9	24. 9	29.1	2609. 3	151 .9	99.4	158.7	1918	2662. 5
SO <sub>4</sub> <sup>-</sup>	мг/л	500	-	89 0	1250	335	2.6	135	580	480	580	25	2.8	18	1850	170	120	185	1420	1950
NO <sub>2</sub> <sup>-</sup>	мг/л	1	-	0	0.01	0	0	0.03	0	0	0.01	0	0	0	0.05	0.1	0.05	0.05	0.05	0.05
NO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	50	-	2	0	2	4	0	1	1.2	0	2	1	0	35	45	35	40	20	32
CO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	-	-	0	0	0	0	0	0	6	12	0	0	0	0	6	24	0	0	0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	-	-	37 8.2	396.5	128 .1	30. 5	54.9	347 .7	353.8	305	18. 3	24. 4	0.2	494.1	585 .6	536.8	549	469.7	494.1
Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	мг/л	-	-	11 21	1253. 9	380 .5	37. 5	163	732 .3	683.3	726.2	49. 3	25. 6	30.2	2221. 3	341 .6	272.9	321.7	1688	2314. 6
Ca <sup>++</sup>	мг/л	100	-	92. 6	90.4	39. 9	1.6	10.2	34. 5	37.3	35.1	1.2	1.2	1.6	100	28. 7	22	26.3	73.3	92.6
Mg <sup>++</sup>	мг/л	30	-	40. 7	50.2	18	0	4.7	11. 7	11.2	12.2	0	0	0	232.3	24. 7	29.9	32	176.8	230.6
NH <sub>4</sub> <sup>+</sup>	мг/л	1.5	-	0.1	2	1.2	0	0.1	1.6	0	1.5	0	0	0	0.7	0.7	0.7	0.8	0.5	0.5

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

<b>Fe<sup>++</sup></b>	мг/л	0.3	-	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
<b>Fe<sup>+++</sup></b>	мг/л	0.3	-	0	1.2	0	0	0	0	2.4	1.8	0	0	0	0	0	0	0	0.3	0
<b>TDS</b>	мг/л	-	-	33	3543	113	92	438	193	1938	1902	122	64	65	5748	100	802	980	5491	6576
<b>Ерөнхий хатуулаг</b>	мг-экв/л	7	-	7.9	8.64	3.4	0.0	0.9	2.6	2.78	2.75	0.0	0.0	0.08	24.09	3.4	3.56	3.94	18.2	23.58
				7		7	8		8			6	6			6				

### 3. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Газрын тос олборлох Тосон уул XIX талбайн 2023 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний мониторингийн хээрийн судалгаа буюу хөрсний дээж авалтыг 2023.06, 2023.08, 2023.9-р саруудад хийж гүйцэтгэсэн. Энэхүү XIX талбайд хөрсний мониторинг хийдэг нийт 33-н цэгээс өнгөн хөрсний буюу 0-10 см гүнээс дээжлэлт хийсэн. Хөрсний бохирдлын дээжийг холимог дээж байдлаар авсан. Дээжийг авахдаа “Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990” стандартыг баримталсан.

Лабораторийн задлан шинжилгээ:

Хөрсний дээжүүдэд агро-хими, физик шинж, органик нүүрстөрөгчийн агуулга, хүнд металл зэрэг 22 орчим үзүүлэлтүүдийг лабораторийн задлан шинжилгээний аргаар тодорхойлсон. Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрс Судлалын лабораторид тодорхойллоо. Үүнд:

- |                                  |                      |
|----------------------------------|----------------------|
| • Органик нүүрстөрөгчийн агуулга | - Шатаалтын алдагдал |
| • Ялзмаг                         | - Тюриний            |
| • Урвалын орчин (pH)             | - Потенциометрийн    |
| • CaCO <sub>3</sub> карбонат     | - Кальциметрийн      |
| • Механик бүрэлдэхүүн            | - Гидрометрийн       |
| • Давсжилт, ЕС                   | - Потенциометрийн    |
| • Фосфор                         | - Спектро фотометр   |
| • Кали                           | - Дөлт фотометр      |


Хөрсний дээжийг лабораторийн задлан шинжилгээнд бэлтгэж боловсруулахад “Физик химийн шинжилгээ хийх дээжийг урьдчилан боловсруулах. MNS ISO 11464:2002” стандарт, анализ хийхэд “Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга. MNS 3310 : 1991” стандартуудыг мөрдлөг болгосон.

Хүнд металл. Хүнцэл (As), Кадмий (Cd), Кобальт (Co), Хром (Cr), Зэс (Cu), Молебден (Mo), Никель (Ni), Хар тугалга (Pb), Стронций (Sr), Ванади (V), Цайр (Zn) зэрэг элементүүдийг магадлан итгэмжлэгдсэн SGS олон улсын лабораторид ICP40B аргазүйгээр Optical Spectrometer (OS)-ийн багажаар тодорхойлсон.



Зураг № 62. Хөрсний дээж авч буй нь

# БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023



Зураг № 63. Хөрсний мониторинг цэгүүдийн байршил

Мэргэжлийн эрх бүхий “Цавчирын хөндий” ХХК нь 2022 оны 6-р сар болон 9-р сард хоёр удаа нийт 33 цэг дээрээс хөрсний дээж авч органик нүүрстөрөгч (C), агро-хими ба ус физик шинж чанар, хүнд металл зэрэг 22 нэр төрлийн үзүүлэлтээр тодорхойлсон. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь газрын тос олборлох “Тосон уул XIX” талбайн хөрсний орчны хяналт шинжилгээг 2023 онд 3 удаагийн давталтаар (6,8,10 сард) нийт 33 цэгт хөрсний органик нүүрстөрөгч (C), агро-хими ба ус-физик шинж чанар, хүнд металл зэрэг 22-н үзүүлэлтээр тодорхойллоо. Ахуйн болон техникийн гаралтай хатуу хог хаягдал болон шатах тослох материалаар бохирдож болзошгүй цэгүүдийн хөрсний гадарга дээр мэдэгдэхүйц том хэмжээний бохирдол байхгүй, ганц нэг цэгт тослох материалын жижиг толботой байна. Тосны танк бүхий SMP-27 цэгт 6; 8-р сард бага зэрэг цэгэн бохирдолтой байсан боловч 10-р сард эрс багассан байна. Бусад цэгүүд нь эрүүл хөрстэй ойролцоо утгатай буюу хэвийн түвшинд байна. Мөн өмнөх жилийн судалгааны үр дүнгээс хол зөрүүтэй тохиолдол байхгүй байгаа нь төслийн талбайд өнөөгийн байдлаар онц ноцтой бохирдол үүсээгүй хэвийн байгааг илтгэж байна. Хөрсний урвалын орчин (pH)-ийн утгын хэлбэлзэл 6 болон 8-р сард дунд зэргээс хүчтэй шүлтлэг орчинтой байгаа нь тухайн үеийн хөрсний халалт хуурайшилтаас шалтгаалж хялбар уусах давс болон бусад хөдөлгөөнт элементүүд хөрсний гадарга хэсэг рүү шилжсэнтэй холбоотой байна. Харин 10-р сард хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс дунд зэрэг шүлтлэг болж нэлээд буурсан нь энэ бүс нутагт 8 сараас хойш ихээхэн бороо хур их орсонтой холбоотой байна. Мөн хөрсний урвалын орчин нь хөрсний чийгшил болон хуурайшилтаас шалтгаалж өөрчлөгдөж байдаг тогтмол биш үзүүлэлт учраас өмнөх жилүүдийн үр дүнтэй харьцуулах өрөөсгөл ойлголт болно. Карбонатын өндөр агууламжтай цэгүүд нь өмнөх жилтэй ойролцоо буюу өөрчлөлт багатай, харин зарим цэгүүдэд шинээр бага зэрэг карбонатжилттай болсон байгаа нь тухайн цэгүүдэд өнгөн хөрсний бага зэрэг талхигдал явагдсаныг илтгэж байна. Мөн бас нэг шалтгаан нь 8 болон 10-р саруудын хөрсний дээж авалтыг хөрсний гадарга илүү талхадсан гадаргаас сонгож авсантай холбоотой байна. Хөрсний ялзмагийн утгын хэлбэлзэл 8 болон 10-р саруудад бага зэрэг буурсан зүй тогтолтой байгаа нь шалтгаан нь эдгээр саруудын хөрсний дээж авалтыг хөрсний гадарга нь илүү талхадсан газрыг сонгож авсантай холбоотой байна. Хөрсний хялбар уусах давсжилтын (ЕС) утгын хэлбэлзэл нь зуны халалт хуурайшилт ихтэй 8-р сард зарим цэгүүдэд бага зэрэг өссөн, харин намар хур тунадас их орсноос шалтгаалж эргээд бага зэрэг буурсан байна. Мөн гаднын нөлөөгөөр хэт буурсан эсвэл өссөн тохиолдол байхгүй буюу хэвийн түвшинд буюу сулаас дунд зэрэг давсархаг байна. Нийт төслийн талбайд зонхилон тархсан хөрсөн бүрхэвч нь ихэвчлэн элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй учраас хөдөлгөөнт фосфор, калийн хангамж багатай буюу үржил муутай байна. Хөрсний хүнд металлуудын хувьд Cd, Mo, Sn маш бага буюу бараг илрээгүй, харин бусад металлууд тодорхой хэмжээгээр илэрсэн бөгөөд эдгээрийн агууламж стандартын хүлцэх агууламжаас хэтэрсэн тохиолдол байхгүй, өмнөх жилээс өөрчлөлт маш багатай буюу хэвийн түвшинд байна. Хэдийгээр хүнд металлууд хүлцэх агууламжаас хэтрээгүй боловч зарим металлууд нь нийт дунджаас арай өндөр агууламжтай байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд: Хүнцлийн хувьд гүвээрхэг өндөрлөг газруудаар байрлалтай цэгүүдэд харьцангуй бага агууламжтай, харин хотос хонхор болон



**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

хүчтэй талхадсан цэгүүдэд бага зэрэг өндөр агууламжтай байна. Мөн Cr, Co, Cu, Ni, V гэсэн металлууд хатуу хучилттай тээврийн зам дагууд болон төв кемпийн авто зогсоол, ачилтын талбай зэрэг машин техникийн тогтмол хөдөлгөөн ихтэй цэгүүдэд бусад цэгээс бага зэрэг өндөр агууламжтай байгаа нь тухайн цэгүүдэд дээрх металлууд авто машины утаанаас ялгарч бага зэрэг бохирдол үүсгэж байгааг нотолж байна.

Цэгийн дугаар	Ерөнхий байршил	Хөрсний гадаргын төлөв	Цэгийн солбицол	
			Y	X
SMP-1	ШТС орчмын талхлагдсан газар	Хүчтэй талхадсан	46.9435	116.248
SMP-2	Ууршуулах бетон далан	Дунд зэрэг талхадсан	46.9282	116.335
SMP-3	Ахуйн цэвэрлэх байгууламж	Дунд зэрэг талхадсан	46.9221	116.346
SMP-4	Хатуу хог хаягдлын талбай	Дунд зэрэг талхадсан	46.9224	116.337
SMP-5	Хатуу хог хаягдлын талбайгаас зүүн урагшаа	Нөлөөлөл байхгүй	46.9068	116.386
SMP-6	Нөхөн сэргээлт хийгдсэн шингэн хаягдлын сан	Нөхөн сэргэсэн	46.9276	116.342
SMP-7	1-4 хуваарилах ЦДАШ	Хүчтэй талхадсан	46.9131	116.249
SMP-8	Хөвөө нуураас 50м орчим зайд	Дунд зэрэг талхадсан	46.889	116.224
SMP-9	19-3 цооног орчим	Дунд зэрэг талхадсан	46.9364	116.224
SMP-10	19-3 олон замын уулзвар орчим	Дунд зэрэг талхадсан	46.9347	116.224
SMP-11	Бичигтийн зам дагууд 5 км орчимд	Бага зэрэг талхадсан	46.8938	116.198
SMP-12	Бичигтийн зам дагууд 30 км орчимд	Бага зэрэг талхадсан	46.6824	116.07
SMP-13	Бичигтийн зам дагууд 10 км орчимд	Бага зэрэг талхадсан	46.8523	116.173
SMP-14	Дорнын их гэгээ ХХК -ний гадна талбай	Дунд зэрэг талхадсан	46.9397	116.2
SMP-15	Дачингийн цооног үйлчилгээ гадна талбай	Дунд зэрэг талхадсан	46.9386	116.203
SMP-16	Химийн бодисын агуулах байсан газар	Дунд зэрэг талхадсан	46.94	116.198
SMP-17	Цацрагийн анги байсан газар	Бага зэрэг талхадсан	46.9397	116.199
SMP-18	Зүүн талын айлууд орчим	Хүчтэй талхадсан	46.9617	116.293
SMP-19	Баянхошуу чиглэлийн авто зам дагууд	Бага зэрэг талхадсан	46.9737	116.343
SMP-20	19-318-197 цооног орчим	Бага зэрэг талхадсан	47.2244	116.402

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

SMP-21	1-11 хуваарилах орчим	Хүчтэй талхадсан	47.0805	116.352
SMP-22	1-9 дэд станц орчим	Хүчтэй талхадсан	47.0259	116.317
SMP-23	Төв кемпийн гадна зогсоол	Хүчтэй талхадсан	46.9518	116.263
SMP-24	Нэгдсэн байгууламжийн ачилтын талбай	Бага зэрэг эвдэрсэн	46.9612	116.253
SMP-25	Түүврийн аргаар дээжлэлт хийсэн талбай	Дунд зэрэг талхадсан	46.9748	116.247
SMP-26	Матад хороолол орчим	Дунд зэрэг талхадсан	46.9429	116.204
SMP-27	1-16 явсан далд шугам хоолой дагууд	Дунд зэрэг талхадсан	46.8908	116.131
SMP-28	Петро транс хашааны гадна	Хүчтэй талхадсан	46.9431	116.249
SMP-29	Дорнод аймаг явах зам дагууд	Бага зэрэг талхадсан	46.9696	116.078
SMP-30	Шаравнямбуугийн өвөлжөө	Хүчтэй талхадсан	46.8643	116.195
SMP-31	Шинэ кемпийн гадна талбай	Бага зэрэг талхадсан	46.9537	116.272
SMP-32	Усны хуваарилах 1-23 урд	Хүчтэй талхадсан	46.9564	116.263
SMP-33	ТА-1 зүүн урд	Хүчтэй талхадсан	46.9627	116.258

#### 4. УРГАМЛЫН МОНИТОРИНГ

“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон – Уул ХИХ талбайн ургамлан нөмрөгийн хэв шинж, бүрхцийн үндсэн үзүүлэлт, биомасс, зүйлийн тохиолдоц болон зүйлийн бүрдэл, ангилал, нэн ховор болон ховор ургамлын төрөл, зүйлүүд түүний тархалт, хамгааллын статус, ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдал өөрчлөлт, доройтлыг илрүүлэх мониторинг судалгааг жил бүр хэрэгжүүлэн ирсэн. Тухайн төслийн талбайн ургамлын мониторинг судалгааг 2023 онд хавар, зун, намар гэсэн 3 удаагийн хээрийн хэмжилт судалгааг хийж гүйцэтгэсэн.



Зураг № 64. Хаврын мониторинг судалгаа /2023.06.28 – 07.02/



Зураг № 65. Зуны мониторинг судалгаа /2023.08.10 – 08.17/



Зураг № 66. Намрын мониторинг судалгаа /2023.09.24– 10.01/


Ургамлан нөмрөгийн судалгаа хийсэн арга зүй

Ургамалжилтын судалгааг хийхдээ ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, түүний өөрчлөлтийг Друдегийн аргаар, тусгаг бүрхэцийг Л.Г.Раменскийн аргаар тодорхойлсон. Геоботаникийн бичиглэл хийхдээ тухайн ургамлын мониторингийн цэгийг төлөөлүүлэн 1x1 м<sup>2</sup> болон 10 x10 м<sup>2</sup> талбайд раменскийн тор ашиглан тодорхойлсон бөгөөд санамсаргүй байрлуулан цэг тус бүрээр бичиглэл хийж, хээрийн судалгааны мэдээ материалуудад үндэслэн ургамлын тайланг боловсруулсан.



Зураг № 68. Ургамлын бүрхэц: Хавар 30 %, Зун 75 %, Намар 70 % -ийн бүрхэцтэй байна.

# БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023



Зураг № 67. Ургамлын дээж авсан цэгүүд.

Мониторинг судалгааны гол үр дүнгүүд

Тосон – Уул XIX талбайн ургамлын өнөөгийн төлөв байдал, нөлөөллийг хянах зорилготойгоор нөлөөллийн эх үүсвэр, төслийн үйл ажиллагаанаас хамааруулан нийт 30 цэгт мониторингийн цэг байгуулан жил бүр хяналт, шинжилгээ судалгааны ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тосон – Уул XIX талбайн 2023 оны ургамлын хяналт шинжилгээг хавар, зун, намар гэсэн 3 улирлын мониторинг судалгааг хэрэгжүүлэн бөгөөд судалгааны үр дүнг улирал бүрээр нэгтгэн боловсруулла.

Ургамлын мониторингийн 20 цэгийн 3 улирлын судалгааны ургамлын бүрхцийг харьцуулан үзвэл хавар ургамлын бүрхэц хамгийн багадаа 10-15 % ийн бүрхэцтэй байхад хамгийн ихдээ 55-60 %, дунджаар 32 %-ийн бүрхэцтэй байна. Харин зун хамгийн багадаа 45 %, хамгийн ихдээ 85-90 %, дунджаар 67 %-ийн бүрхэцтэй байна. Харин намар ургамлын бүрхэц хамгийн багадаа 5-30 % байхад хамгийн ихдээ 85-90 %, дунджаар 59-% -ийн бүрхэцтэй байна. Доорх зургаас харахад VP-3, VP-8, VP-18 цэгүүдэд ургамлын бүрхэц хамгийн муу байна. Харин VP-25, VP-30, VP-5 гэсэн цэгүүдэд ургамлын бүрхэц хамгийн сайн байна. Улирлын мониторинг судалгааны үр дүнгээс харахад хавар буюу 6-7 сарын дунд үе хүртэл ургамлын бүрхэц маш муу байхад зун буюу 7 сарын сүүлчээс 8 сарын сүүлч хүртэл эрс нэмэгдэж байгаа судалгааны судалгааны үр дүнгээс харагдаж байна. Харин намар ургамлын бүрхэц бага зэрэг буурсан байна. Энэ үр дүнгээс харахад тухайн төслийн талбайд ургамлын нөмрөгийн бүрхэц улирлаар эрс өөрчлөгддөг болох нь харагдаж байна. Иймээс ургамлын мониторингийн судалгааг зөв цаг үед төлөвлөн хийх нь мониторинг судалгааны үр дүнд ихээхэн чухал болох нь харагдаж байна. 2023 оны ургамлын мониторинг судалгаагаар 1 м<sup>2</sup> талбайд тохиолдох ургамлын зүйлийн тохиолдоц буюу зүйлийн баялгийг мөн 3 улирлаар бүртгэж гаргасан бөгөөд доор зургаас харахад хавар хамгийн багадаа 1 м<sup>2</sup> талбайд 2-3 зүйл ургамал тохиолдох бол хамгийн олондоо 7 зүйл, дунджаар 4-5 зүйл тохиолдож байна. Харин зуны судалгаагаар хамгийн багадаа 1 м<sup>2</sup> талбайд 5 зүйл, хамгийн олондоо 11 зүйл тохиолдох бол дунджаар 6-8 зүйл ургамал тохиолдож байна. Намрын мониторинг судалгаагаар 1м<sup>2</sup> талбайд хамгийн бага 1 зүйл, хамгийн олондоо 8 зүйл дунджаар 6-7 зүйл ургамал тохиолдож байна. Намар VP – 18 дугаартай цэгт талбайн ажил хийгдэж байсан учир тухайн орчмын ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөж талхлагдаж ургамлан нөрмөггүй болсон байв. Харин VP – 2 цэгт хавар огт ургамлан нөмрөг тохиолдоогүй бөгөөд тухай цэг орчмын ургамлан нөмрөг хавар түймэрт өртсөн байна. Түймэрт өртсөн цэг орчмын ургамлан нөмрөг зун маш сайн сэргэн ургасан нь зургаас харагдаж байна.

График 5. Ургамлын бүрхцийг 3 улирлаар харьцуулсан дүн /2023 он/




График 6. Сүүлийн 4 жилийн харьцуулалт





График 7. Сүүлийн 4 жилийн бүрхцийг харьцуулсан үр дүн



**Дүгнэлт**

Бидний судалгааны талбай болох газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон – Уул XIX талбай нь газрын гадаргын хувьд (д.т.д 660-762 м) өндөрт өргөгдсөн тэгш талархаг болон нам хотос бүхий 2 ялгаатай газрын гадаргыг дага болон төслийн нөлөөллөөс хамааран Үетэн – Том хялганат, Таан – Хялганат, үетэн – шарилжит буюу шарилж –үетэнт буюу шарилж – нэг наст үетэнт, дэрс – хиаг – бударганат гэсэн 4 жижиг ургамлан бүлгэмдэлд хуваан авч үзлээ.

Үүнд:

1. Үетэн – хялганат бүлгэмдлийн ургамлын тусгаг бүрхэц дунджаар 45-60%, ургамлын дундаж өндөр 30-40 см, хуурай ургац дунджаар 6 - 8 ц/га, 1м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 6-8 зүйл ургамал бүртгэгдэж байв.
2. Таан – Хялганат ургамлан бүлгэмдэл нь судалгааны талбайн баруун, баруун хойд талаар нөлөөлөлд бага өртсөн хэсгээр тархана энд ургамлын тусгаг бүрхэц дунджаар 50-80 %, ургамлын дундаж өндөр 25-30 см, ургац дунджаар 4-6 ц/га, 1м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 4-6 зүйл ургамал бүртгэгдэж байв.



3. Үетэн - шарилжит бүлгэмдэл судалгааны талбайн төв хэсгээр буюу нөлөөлөлд өртсөн хэсгээр түлхүү тархан ургана. Бүлгэмдлийн тусгаг бүрхэц 25-50 %, зарим газраар хиаг зонхилж ургасан, ургамлын дундаж өндөр 20-25 см, ургац дунджаар 3-5 ц/га, 1м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 3-5 зүйл ургамал бүртгэгдсэн. Бүлгэмдэлд зонхилогчоор шарилж нийт ургамлын 30-40 %-ийг дангаараа эзлэх бөгөөд үет ургамлаас нэг наст үетэн, хиаг, том хялгана, дэрвээн хазаар өвс зэрэг ургамлууд бүлгэмдэлд байнга оролцоно.
4. Дэрс – хиагт – бударганат бүлгэмдлийн тусгаг бүрхэц дунджаар 83%, гялгар дэрс болон бударгана зонхилж ургасан, ургамлын дундаж өндөр алаг өвс 15-20 см, дэрс 40-45 см, зуны ургац ургац дунджаар 8-10 ц/га, 1м<sup>2</sup> талбайн зүйлийн баялаг дунджаар 5-8 зүйл ургамал бүртгэгдсэн. Бүлгэмдэлд зонхилогчоор гялгар дэрс-*achnatherum splendens* улаанбударгана-*reaumuria soongorica* нийт ургамлын 50-60%-ийг дангаараа эзлэх бөгөөд хиаг - *elymus chinensis* болон саваан булган сүүл зарим газраар өндөр бүрхэцтэй бүлгэмдэлд оролцоно.

Судалгааны талбайд бүртгэгдсэн зүйлийн бүрэлдэхүүний хувьд 2023 онд **34 овгийн, 84 төрөлд хамаарах 123 зүйл** ургамал бүртгэгдсэн. Уг үр дүнг 2022 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 2 овог, 7 төрөл, 16 зүйл ургамал илүү бүртгэгдсэн байна.

- Судалгааны талбайд тохиолдож болох ховор ургамлын жагсаалтыг ном зүй, суурь материалаас шүүж үзэхэд нийт 8 зүйл хуулиар хамгаалагдсан ургамал тохиолдох боломжтойгоос МУ –ын улаан номд ховор ангиллаар бүртгэгдэж байсан 3 зүйл Дэрэвгэр жирэгрүү *Saposhnikovia divaricata*, Ацан цахилдаг *Iris dichotoma* Pall, Сибирь Ерөндгөнө *Vincetoxicum sibiricum*, 1995 оны ургамлын тухай хуулийн нэн ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн 2 зүйл Алтан Бэрмэг - *Limonium aureum*, Сибирь Ерөндгөнө - *Vincetoxicum sibiricum*, МУЗГ -ын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан ховор ургамал жагсаалтад бүртгэгдсэн 8 зүйл Дэрэвгэр жирэгрүү *Saposhnikovia divaricata*, Сибирь Ерөндгөнө *Vincetoxicum sibiricum*, Ацан Ажигана *Stellaria dichotoma* L., Эгэл нишингэ *Phragmites communis*, Шувуун хөл *Allium anisopodium*, Морин зээргэнэ *Ephedra sinica*, Ураал Чихэр өвс *Glycyrriza uralensis*, Байгаль гүүн хөх *Scutellaria baicalensis* Georgi зэрэг ургамлууд төслийн талбайд тохиолдож байна.
- Элбэг тархалттай зарим зүйл ургамлуудаас дурдвал (*agropyron cristatum*, *allium polyrrhizum*, *allium senescens*, *amaranthus retroflexus*, *artemisia adamsii*, *artemisia annua*, *artemisia frigida*, *artemisia pectinata*, *caragana microphylla*, *caragana stenophylla*, *cymbaria daurica*, *haplophyllium dahuricum*, *iris bungei*, *iris tenuifolia*, *polygonum divaricatum*, *potentilla acaulis*, *potentilla bifurca*, *potentilla tanacetifolia*, *salsola collina*, *serratula centauroides*, *taraxacum officinalis*, *thalictrum simplex*, *urtica cannabiana*, *reaumuria soongarica*, *chiazospermum erectum*) зэрэг ургамлын төрөл зүйлүүд төслийн талбайд их бага хэмжээтэй түгээмэл тохиолдож байна.
- Мониторинг судалгааны улирлын харьцуулалт: Бид 2023 оны мониторинг судалгааг хавар, зун, намар гэсэн 3 улирлаар хийж гүйцэтгэсэн бөгөөд улирлаар нь харьцуулан үзвэл хавар ургамлын

бүрхэц 10-60 % хооронд, дунджаар 32 % бүрхэцтэй байхад зун 45-90 % -ийн хооронд бүрхэцтэй буюу дунджаар 66 %-ийн бүрхэцтэй байхад намар 5-90 %-ийн хооронд дунджаар 59 % ийн бүрхэцтэй байна. Уг үр дүнгээс харахад төслийн талбайн ургамлын нөмрөг улирлын өөрчлөгдөл их байгааг илтгэж байна. Харин зүйлийн хувьд харьцуулан үзвэл 1 м<sup>2</sup> талбайд хавар 3-5 зүйл тохиолдож байхад зун 4-10 зүйл тохиолдох бол намар 1-8 зүйл тохиолдож байна.

- Мониторинг судалгааны сүүлийн 5 жилийн харьцуулалт: Бид 2023 оны мониторинг судалгаагаар сүүлийн 5 жилийн мониторинг судалгааны үр дүнг харьцуулах гэсэн боловч 2019 оны бичиглэл ямар нэгэн дугаарлалт байхгүй, цэгийн тоо зөрүүтэй, 2020 онд ковидын нөхцөл байдлын улмаас мониторинг судалгаа хийгдээгүй зэргээс харьцуулах боломжгүй байна. Харин 2021, 2022, 2023 оны ургамлын бүрхцийг харьцуулан авч үзэхэд 2021 онд ургамлын тусгаг бүрхэц дунджаар 51 % байхад 2022 онд ургамлын бүрхэц дунджаар 62 %, 2023 онд ургамлын тусгаг бүрхэц дунджаар 66 % -ийн бүрхэцтэй байна. Уг үр дүнгээс харахад 2021 оноос 2022 онд бүрхэц 10 % -иар өссөн бол 2022 оноос 2023 онд 4 % -иар бүрхэц тус тус өссөн үзүүлттэй байна. Сүүлийн 5 жилийн судалгааны зүйлийн тохиолдоц болон биомассын үр дүнг харьцуулан авч үзэх гэсэн боловч 2019, 2021 онуудад зүйлийн тохиолдоц болон биомассын хэмжилтийг огт хийгээгүй байна. Харин 2022 онд ургамлын биомасс хамгийн ихдээ 9 сард 4 ц/га бэлчээрийн ургацтай байсан бол 2023 онд хуурай ургац дунджаар 8 ц/га буюу 2022 оны биомассын үр дүнгээс дариу 2 дахин их байна. 2022 оны биомассын тоон үзүүлэлт нь маш бага байгаагаас үзэхэд бодит хэмжилтийн үр дүн биш баримжаа тоон үзүүлэлт байх магадлалтай байна.
- Судалгааны талбайн ургамлын нормчлогдсон ялгаврын индексийг Sentinel-2 хиймэл дагуулын 7 сарын мэдээнд тулгуурлан сүүлийн 2 жилийн зураглалыг боловсруулж үзэхэд 2022 оны 7 сарын дунд үед ургамалжлын нормчлогдсон ялгаврын индекс буюу NDVI утга хамгийн ихдээ 0.56 байхад 2023 онд NDVI утга хамгийн ихдээ 0.48 байгаагаас үзэхэд 2023 оны 7 сарын дунд үед 2022 оны 7 сарын дунд үеэс ургамлын гарц тааруу байсныг илтгэж байна. Төслийн талбайн NDVI -ийн зураглалаас харахад нөлөөлөлд бага өртсөн ургамлын бүрхэц сайтай газраараа NDVI утга 0.48–0.56 ийн хооронд хэлбэлзэж байхад талбайн төв хэсгээр буюу нөлөөлөлд өртсөн хэсэгт NDVI утга - 0.0 – (-0.04) хооронд буюу огт ургамлан нөмрөггүй халцгай гадаргатай байгааг илтгэж байна.
- 2023 оны ургамлан нөмрөгийн мониторингийн судалгааг, 6,8,10 дугаар саруудад 3 удаа хийсэн бол 2022 оны мониторинг судалгааг 06, 09 дүгээр сард хоёр удаа, 2021 оны мониторингийн судалгааг 12 дугаар сард буюу өвөл нэг удаа, 2019 оны судалгааг намар 1 удаа хийсэн учир өөр өөр цаг хугацаанд өөр давталттай хийж гүйцэтгэсэн учир үр дүнг харьцуулахад ихээхэн хүндрэлтэй байна. Иймээс ургамлын мониторингийн судалгааг нэг цаг хугацаанд, ижил давталттай тогтмол хийлгэсэнээр олон жилийн харьцуулалт үнэн бодит гарах учир цаашид ургамлын мониторинг судалгааг ижил цаг хугацаанд, ижил давталттай хийлгэж байх нь зүйтэй.

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

**АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хураангуй


№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
1	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах үүднээс байгаль орчны ажилтны бүтэц орон тоог нэмэгдүүлэх	2023 онд Байгаль орчны нэг ажилтан ХАБ-н нэг ажилтан нэмэгдсэн.
2	Аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах	Гэрээт талбайн нийт гэрээлэгч ангиудад хог хаягдлыг ангилан ялгах түүний ач тусын талаар сургалт зохион байгуулсан. Мөн хог хаягдлын менежментийг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн.
3	Гэрээлэгч ангиудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ	Нийт гэрээлэгч ангиудад ногоон байгууламжыг нэмэгдүүлэх талаар сургалт суртчилгаа хийж мод тарих ажилд нь хамтарч ажилласан.
4	Замын менежментийг сайжруулах	БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын удирдлагын зүгээс дотоод нөөц бололцоог дайчлан олборлолтын талбайн технологийн хамгийн их эвдрэлтэй ус тогтдог эвдэрсэн 5 км замд хайрга дэвсэн грейдэрээр тэгшлэн индүүдэж арчилгаа хийж ажилласан.
5	ЭМААБО-ны хэлтсийн ажилтнуудыг чадвахжуулах сургалтанд хамруулах	ЭМААБО хэлтсийн ажилчдыг БОАЖЯамнаас зохион байгуулсан “Хариуцлагатай уул уурхай, Нөхөн сэргээлт, Орчны хяналт шинжилгээ” сэдэвт 15 цагийн сургалтанд хамруулсан.
6	Үндсэн болон гэрээлэгч ангиудад байгаль орчны сургалт зохион байгуулах	Гэрээт талбайн нийт ажилчдад байгаль орчны сургалт зохион байгуулсан.

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

7	Химийн бодисын зарцуулалтын тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх.	Химийн бодисын зарцуулалтын тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлсэн.
8	Дорнод аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах ерөнхий төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллах	2023 онд БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын зүгээс Дорнод аймгийн Онцгой байдлын газраар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ашиглах төлөвлөгөөг” батлуулан мөрдлөг болгон ажилласан.
9	Шинээр хэрэгжих төслүүдэд БОНБНУ хийлгэх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэхээр тусгагдсаны дагуу мэргэжлийн эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж болох “ЕАСС” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлж байна.

“ПетроЧайна Дачин Тамсаг” ХХК-ийн БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны (ЭМААБО) хэлтэс нь 2023 оны тайлант жилийн хугацаанд нийт 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр гэрээт талбайд газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болоод байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөлөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, түүнд хяналт тавих чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх  
удирдлага зохион байгуулалтын баг**



11.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах үүднээс байгаль орчны ажилтны бүтэц орон тоог нэмэгдүүлэх.

2023 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах үүднээс Байгаль орчны нэг ажилтан ХАБ-н нэг ажилтан нэмэгдсэн.

11.2 Аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах.

БХГ-т Тосон Уул XIX талбайд дулааны оргил үед 1000 орчим хүн 20 гаруй анги, аж ахуй нэгжүүд улиралын чанартайгаар үйл ажиллагааг явуулдаг. Үйлдвэрлэлийн баазын удирдлагын зүгээс БХГ-т XIX талбай дээр Монгол улсын хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэх, гэрээгээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдийн хог хаягдлыг зөв зохистой шийдвэрлэж хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, бууруулах, цуглуулах арга хэмжээний зохион байгуулалтыг зохицуулахад зориулан “Хог хаягдлыг шийдвэрлэх журам”-ыг компанийн захирлын 2018.08.11 өдрийн 2018/01 тушаалаар баталсан бөгөөд уг журмын 3 дугаар хавсралтын дагуу талбай дээр үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудад 2023 оны тайлант жилийн хугацаанд хяналт тавьж эх үүсвэр дээр нь ангилан ялгуулж бүртгэлжүүлэн хатуу хог хаягдал хаях цэгт буулгах зөвшөөрлийн хуудас олгож ажилласан.

11.3 Гэрээлэгч ангиудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ.

Нийт гэрээлэгч ангиудад ногоон байгууламжыг нэмэгдүүлэх талаар сургалт суртчилгаа хийж мод тарих ажилд нь хамтарч ажилласан.



Зураг № 69. Гэрээлэгч ангиудын мод тарьсан байдал

#### 11.4 Замын менежментийг сайжруулах.

БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын удирдлагын зүгээс дотоод нөөц бололцоог дайчлан олборлолтын талбайн технологийн хамгийн их эвдрэлтэй ус тогтдог эвдэрсэн 5 км замд хайрга дэвсэн грейдэрээр тэгшлэн индүүдэж арчилгаа хийж ажилласан. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар “Авто агро” ХХК-тай гэрээ байгуулан Тосон Уул XIX - Бичигт боомт чиглэлийн сайжруулсан авто зам, Тосон Уул XIX - Өвдөг Баянхошуу боомт чиглэлийн хатуу хучилттай авто замуудад засвар арчлалтын ажлыг жилийн турш тогтмол хийж ажилласан.

#### 11.5 ЭМААБО-ны хэлтсийн ажилтнуудыг чадвахжуулах сургалтанд хамруулах.

2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйлдвэрлэлийн баазын зүгээс ЭМААБО хэлтсийн ажилчдыг БОАЖЯамнаас зохион байгуулсан “Хариуцлагатай уул уурхай, Нөхөн сэргээлт, Орчны хяналт шинжилгээ” сэдэвт 15 цагийн сургалтанд 2023.02.09-2023.02.10 өдрүүдэд хамруулсан.



Зураг № 70. Сертификат

11.6 Үндсэн болон гэрээлэгч ангиудад байгаль орчны сургалт зохион байгуулах.

БХГ-т талбайн үйлдвэрлэлийн баазын ажилчдад болоод тус талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудад газрын тосны олборлолтын үед гарч болзошгүй буюу гарч байсан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, доройтол бохирдолын талаар яриа таниулга хийж хэрхэн урьдчилан сэргийлэх талаар байгаль орчныг хамгаалах тухай хууль, холбогдох дүрэм журмыг танилцуулан сургалт хийж ажилласан.

11.7 Химийн бодисын зарцуулалтын тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх.

БХГ-т Тосон Уул XIX талбайн олборлолтын ТА1 ил байгууламжийн бохир ус цэвэршүүлэх технологи үйл ажиллагаанд 11 төрлийн химийн бодис ашиглагддаг бөгөөд түүний өдөр тутмын ашиглалт, хадгалалт, зарцуулалтанд нэгдсэн байгууламжийн бохир ус цэвэршүүлэх байгууламжийн оператор хяналт тавьж зарцуулалтыг бүртгэн ажилладаг.

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь 2023 онд химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны №0002252 дугаартай тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай БОАЖЯ-аас 2022.09.15-ны өдөр авсан.

11.8 Дорнод аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах ерөнхий төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллах.

2023 онд БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын зүгээс Дорнод аймгийн Онцгой байдлын газраар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ашиглах төлөвлөгөөг” батлуулан мөрдлөг болгон ажилласан.

11.9 Шинээр хэрэгжих төслүүдэд БОНБНҮ хийлгэх.

Петрочайа Дачин Тамсаг ХХК-ийн БХГ-т Тосон Уул XIX талбайн 2023 оны БОМТ-нд “2023 оны олборлолтыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын төсөлд” Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэхээр тусгагдсаны дагуу мэргэжлийн эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж болох “ЕАСС” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлж байна. “ЕАСС” ХХК үнэлгээний хээрийн судалгааны ажлыг гэрээт талбайд 2023 оны 06, 07 саруудад ирж хийж гүйцэтгээд байгаа бөгөөд одоо тайлан боловсруулалтын ажил хийгдэж дуусаад БОАЖЯ-тай батлуулахаар хүргүүлэн ажиллаж байна.

**АРВАН ХОЁР. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД БОМТ-НИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Петрочайа Дачин Тамсаг ХХК-ийн БХГ-т Тосон Уул XIX талбайн 2023 оны БОМТ 2023.06 сард батлагдсаны дагуу байгаль орчны ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг Дорнод аймгийн төвд нээлттэй тендэр зохион байгуулан шалгаруулан энэ жилийн байгаль орчныг хамгаалах ажлыг эхлүүлсэн.

Хүснэгт 19. Нөлөөллий бүсийн оршин суугчдад БОМТ танилцуулах төлөвлөгөөний хураангуй

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Хэрэгжилт
1	Дэлхийн усны өдөрт зориулан Буйр нуур Мэнэнгийн талын сав газартай хамтарсан ажил зохион байгуулах.	Дэлхий нийтээрээ жил бүрийн 3 дугаар сарын 22-нд “УСНЫ ӨДӨР”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Дэлхийн усны өдрийг угтан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаатай хамтран Матад сумын нутгийн иргэдэд усны үнэ цэнэ, усны нөөцийн хэрэглээ, ашиглалтын өнөөгийн байдал, усны нөөцөө хамгийн ухаалгаар хамгаалж, зүй зохистой ашиглах талаар мэдээлэл өгч, хамтран ажиллаа.
2	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл болоод 2024 оны БОМТ-	Дорнод аймгийн матад сумын соёлын төв танхимд нийт иргэдэд 2023 оны 6 сарын 11ний өдөр БОМТ-г танилцуулсан. Мөн нөлөөллийн бүсийн оршин суугчдад 2023 оны 6 сарын 12ны өдөр БОМТ-г танилцуулан мэдээ мэдээлэл өгч хамтарч ажилласан.



**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

	г орон нутгийн иргэдэд танилцуулах.	
3	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний явцыг орон нутгийн иргэдэд газар дээр нь танилцуулах.	Матад сумын хүүхэд залуучуудад 2023 оны 10 сарын 4 ний өдөр БОМТ-н гүйцэтгэл ажлын явцыг танилцуулах зорилгоор өдөрлөг зохион байгуулж байгаль орчныг хамгаалах талаар мэдээ мэдээлэл өгч хамтран ажиллаа.
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон комист танилцуулан хийгдсэн ажлуудыг хүлээлгэн өгөх.	Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг БХГ-т талбайд ажиллаж БОМТ-нд тусгагдсан ажлуудыг хүлээн авч үнэлэлт дүгнэлт гаргана.

12.1 Дэлхийн усны өдөрт зориулан Буйр нуур Мэнэнгийн талын сав газартай хамтарсан ажил зохион байгуулах.

Дэлхий нийтээрээ жил бүрийн 3 дугаар сарын 22-нд “УСНЫ ӨДӨР”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Дэлхийн усны өдрийг угтан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаатай хамтран Матад сумын нутгийн иргэдэд усны үнэ цэнэ, усны нөөцийн хэрэглээ, ашиглалтын өнөөгийн байдал, усны нөөцөө хамгийн ухаалгаар хамгаалж, зүй зохистой ашиглах талаар мэдээлэл өгч, хамтран ажиллаа.



Зураг № 71. Усны өдөрлөг

12.2 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл болоод 2024 оны БОМТ-г орон нутгийн иргэдэд танилцуулах.

Петрочайна Дачин Тамсаг ХХК нь төсөл хэрэгжүүлэгчийнхээ хувьд аймаг, сум орон нутагтай нийгэм, эдийн засаг, байгаль орчин зэрэг бүхий хүрээнд нягт ойр хамтран ажиллахыг эрмэлздэг. Дорнод аймгийн матад сумын соёлын төв танхимд нийт иргэдэд 2023 оны 6 сарын 11ний өдөр БОМТ-г танилцуулсан. Мөн нөлөөллийн бүсийн оршин суугчдад 2023 оны 6 сарын 12ны өдөр БОМТ-г танилцуулан мэдээ мэдээлэл өгч хамтарч ажилласан.



Зураг № 72. Матад сумын иргэдэд БОМТ танилцуулж буй нь

12.3 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний явцыг орон нутгийн иргэдэд газар дээр нь танилцуулах.

Матад сумын хүүхэд залуучуудад 2023 оны 10 сарын 4 ний өдөр БОМТ-н гүйцэтгэл ажлын явцыг газар дээр нь танилцуулах зорилгоор өдөрлөг зохион байгуулж байгаль орчныг хамгаалах талаар мэдээ мэдээлэл өгч хамтран ажиллаа





Зураг № 73. Матад сумын хүүхдүүд

БОМТ тусгагдсан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ургамал, хөрсний дээж авах ажилд Матад сумын Буян-Өндөр багийн засаг дарга Б. Нарангэрэл, тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч Э. Өсөхбаяр нар хяналт тавьж хамтарч ажилласан.



Зураг № 74. Матад сумын төлөөлөл мониторинг хийх ажилд хяналт тавьж буй нь

12.4 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон комист танилцуулан хийгдсэн ажлуудыг хүлээлгэн өгөх.

Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг БХГ-т талбайд ажиллаж БОМТ-нд тусгагдсан ажлуудыг хүлээн авч үнэлэлт дүгнэлт гаргана.

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

**АРВАН ГУРАВ. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
НЭГДСЭН ТӨСӨВ**

Хүснэгт 20. БОМТ Нэгдсэн төсөв

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	
2023 онд БХГ Тосон-Уул XIX талбай нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ 492.400 ам доллар зарцуулаад байна.	
Гүйцэтгэсэн ажил	Зардал ам.доллар
Нэг. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	
Нөхөн сэргээлт хийсэн өрмийн шаврын хаягдлын сангаас хөрсний дээж авч шинжилгээнд өгөх	15,000
Ашиглагдахгүй болсон зам хагалах, сийрүүлэх	60,000
Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажил	20,000
“Тэрбум” мод төсөл	40,000
Дүн	135,000
Хоёр. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	
Техникийн нөхөн сэргээлт хийх	122,400
Биологийн нөхөн сэргээлт хийх	50,000
Дүн	172,400
Гурав. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	
Дүйцүүлэн хамгааллын суурь судалгааг хийлгүүлэх	50,000
Дүн	50,000
Дөрөв. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Гүйцэтгэлээр
Тав. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Гүйцэтгэлээр
Зургаа. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	
Ослын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 6 ажил тусгагдсан.	Гүйцэтгэлээр
Долоо. Хог хаягдалын төлөвлөгөөний биелэлт	
Ахуйн хог хаягдал	50,000
Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал	
Дүн	50,000

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

Найм. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	
БХГэрээт талбайд 3 удаагийн давтамжтайгаар агаар, хөрс, ус, ургамал, амьтан зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдээс дээж авч судалгаа шинжилгээг хийлгэж тайлан гаргах	25,000
Дүн	25,000
Ес. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	
19-р талбайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	60,000
Арав. Олон нийтэд тайлагнах хуваарь	Гүйцэтгэлээр
Нийт зардал	492,400

№	2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ХУРААНГУЙ				
	Дэд төлөвлөгөө	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд	Төсөв (\$)	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл
	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл				
1		Зарим хуваарилах чиглэлд явсан шороон зам арчилгааг хийх	Гүйцэтгэлээр	Үйлдвэрлэлийн баазын дотоод нөөц бололцоог дайчлан эвдэрсэн 5 км замыг грейдэрээр хусаж тэгшлэн индүүдэж арчилгаа хийсэн.	100
	Усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл				
2		Үйлдвэрлэлийн баазын үйл ажиллагаатай холбоотой усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Гүйцэтгэлээр	Ус ашиглалтанд баталгаажуулсан тоолуур ашиглаж төлбөрийг хийж улмаар улирал тутамд усны дээж авч шинжлүүлсэн.	100
3		Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжид бохир ус зөвшөөрөлгүй буулгахаас урьдчилан сэргийлж байнгын бүртгэл хөтлөн ажиллах.	Гүйцэтгэлээр	Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжинд бохир буулгах тухай бүрт зөвшөөрлийн хуудсыг бөглүүлэн бүртгэл хөтлөн ажилласан.	100
4		Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн орж гарч байгаа усанд стандартын дагуу шинжилгээ хийлгэх.	Дотоод нөөцөөр	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн орж гарч байгаа усанд стандартын дагуу улирал тутамд дээж авч Дорнод аймгийн стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжлүүлсэн.	100
	Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл				

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

5	<p><b>Нэг. Гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт урьдчилан сэргийлэх</b></p>	Өрмийн сан байгуулахад шимт хөрсийг тусгайлан овоолж пайзжуулах	Гүйцэтгэлээр	2023 онд 2 цооног өрөмдөж өрмийн шаврын хаягдлын сан байгуулан үржил шимт хөрсийг тусад нь овоолон пайз тавьж ажилласан.	100
6		Олборлолтын операторууд болон тээврийн хэлтсийн жолооч нар, гэрээлэгч ангийн нийт жолооч нарт маршрутын бус замаар зорчихгүй байх, түүний ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах	Гүйцэтгэлээр	БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудын жолооч нарт аюулгүй ажиллагаа болоод байгаль орчны сургалтыг хийж ажилласан.	100
7		Нөхөн сэргээлт хийсэн өрмийн шаврын хаягдлын сангаас хөрсний дээж авч шинжилгээнд өгөх	15000	2023 оны БОМТ-нд тусгагдсаны дагуу 30 нөхөн саргээлт хийсэн цооногын талбайгаас хөрсний дээж авч БОТЛ болоод Геологийн төв лабораторид шинжлүүлэх ажлыг “Байгаль тандалт” ХХК-тай гэрээ байгуулж хийж гүйцэтгүүлж ажилласан.	100
8		Ашиглахгүй болсон технологийн замын хөрсийг хаглаж сийрүүлэх	60000	2023 оны БОМТ-нд 50 га газрыг хаглаж сийрүүлэхээр тусгагдсаны дагуу 50 га талбайд “Дорнод теленет сүлжээ” ХХК-тай гэрээ байгуулан хаглаж сийрүүлэх ажлыг хийж гүйцэтгүүлсэн.	100
Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл					
9	Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршигийн талаар сургалт зохион байгуулах	Гүйцэтгэлээр	Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхээр бэлэн байдлыг ханган гал түймэр унтраах тоноглолыг захиалан авч бэлэн байдлыг хангаж ажилласан. 2023 онд БХГ-т талбай болоод түүний орчны бүсэд гарсан 7 тал хээрийн түймрийг үйлдвэрлэлийн баазын зүгээс унтраан амьтан ургамлыг хамгаалан ажилласан байна. БХГ-т талбайд ажиллаж буй нийт ажилчдад хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж ажилласан.	100	

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

10		Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	Гүйцэтгэлээр	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд гэрээт талбайн түр суурингуудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн моджуулах ажлын хүрээнд “Байгалиа дээдлэе” ХХК-тай гэрээ байгуулан Дорнод аймгийн Матад суманд Жигдны суулгац 5000ш, Гүйлс модны суулгац 3000 ширхэгийг тус тус хүлээлгэн өгсөн байна. Мөн XIX талбайн хээрийн түр сууринд 18568ш мод тариад байна.	100
		Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөлөл			
11		Хууль бусаар ан агнах, ургамал түүх тэдгээрийг тээвэрлэх ашиглахыг хооиглох тухай Монгол улсын холбогдох хууль дүрмийн талаар сургалт зохион байгуулах	Гүйцэтгэлээр	Тосон-Уул XIX талбайн нийт ажилчдад Хууль бусаар ан агнах, ургамал түүх тэдгээрийг тээвэрлэх ашиглахыг хооиглох тухай сургалт зохион байгуулсан.	100
12		БХГ-т талбайн хээрийн түр суурин болоод ахуйн бохирын цэг, хатуу хог хаягдлын цэгт хортон шавьж мэрэгч амьтан үржих, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс шавжгүйтгэлийг хийх	20000	БХГ-т талбайн хээрийн түр суурин болоод ахуйн бохирын цэг, хатуу хог хаягдлын цэгт хортон шавьж мэрэгч амьтан үржих, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс шавжгүйтгэлийг мэргэжлийн эрх бүхий “Эгэл альфа” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд уг ажлыг үйлдвэрлэлийн баазад 2023 оны 06-р сарын 26–29 өдрүүдэд, 2023 оны 09-р сарын 22-24-ны өдрүүдэд 2 удаагийн давтамжтай хийж гүйцэтгэсэн.	100
13	<b>Хоёр.</b> Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	Техникийн нөхөн сэргээлт хийх	28200	2023 оны БОМТ-нд тусгагдсан 7 өрмийн зүмп, 4 үйлдвэрлэлийн шингэн хаягдалын сангийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн эрх бүхий “Баянтал Энержи” ХХК-аар гүйцэтгүүлэв.	100



**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

14		Биологийн нөхөн сэргээлт хийх	50000	2023 оны БОМТ-нд тусгагдсан 5 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 1000 ш улиас мод суулгахаар ажлыг мэргэжлийн эрх бүхий “Эко эрдэнэс бюлдинг”ХХК хийж гүйцэтгэсэн.	100
15	<b>Гурав.</b> Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Дүйцүүлэн хамгааллын суурь судалгааг хийлгүүлэх	50000	2023 оны дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд “ЕАСС”ХХК-тай гэрээ байгуулан 2017-2021 онд хийж гүйцэтгэсэн ажилд ерөнхий дүгнэлт өгөх, суурь судалгааг хийх, холбогдох төрийн байгууллагуудаас санал авах, ан амьтны амьдрах орчинд нөлөөлөгч хүчин зүйлс болох уур амьсгалын өөрчлөлт, цөлжих үйл явцад мониторинг хийх, 2023-2027 оны дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.	100
16	<b>Дөрөв.</b> Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	Уг төсөл нь үндсэндээ 1998 оноос хойш хэрэгжиж байгаа бөгөөд төсөл хэрэгжиж буй газар нутаг нь улсын тусгай хэрэгцээний газарт хамаарагддаг тул нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэх шаардлагатай байдаг. Зайлшгүй шаардлагаар нүүлгэн шилжүүлэлт хийгдэх нөхцөл байдал гарсан тохиолдолд цаг алдалгүй нүүлгэн шилжүүлэлт хийгдэх ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэнэ.	Гүйцэтгэлээр	БХГэрээт талбайн 2023 оны олборлолт, өрөмдлөг, бүтээн байгуулалтын ажлын явцад ямар нэгэн байдлаар нүүлгэн шилжүүлэлт хийгдэх шаардлага тулгаараагүй болно.	-
17	<b>Тав.</b> Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	2010-2011 онд Шинжлэх ухааны академи, Архелогийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээг байгуулан БХГ-т XIX талбайд хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэлсэн.	Гүйцэтгэлээр	БХГэрээт талбайн 2023 оны олборлолт, өрөмдлөг, бүтээн байгуулалтын ажлын явцад түүх соёлын ямар нэгэн өв илрээгүй болно	-

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

18	Зургаа. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	1.	Аюултай бодис асгарах	Гүйцэтгэлээр	БХГ-т Тосон Уул XIX талбайд ашиглагддаг химийн бодис 3 төвлөрсөн агуулахад хадгалдаг бөгөөд ашиглалт, хадгалалтын явцад өдөр тутам хяналт тавьж улмаар Дорнод аймгийн Онцгой байдлын газраар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ашиглах төлөвлөгөөг” батлуулан ажилласан.	100
		1.1	Химийн бодисыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах			
19		2.	Тос асгарах	Дотоод нөөц	БХГ-т талбайн олборлолтын технологи үйл ажиллагааны явцад тос асгарсан тохиолдол гараагүй бөгөөд харин олборлолтын үйл ажиллагааны явцад асгарсан тосыг тухай бүрт нь цэвэрлэж тостой шороо угаах үйл ажиллагаа явуулдаг “Эко Ургамал” ХХК-д хүлээлгэн өгч ажилласан болно.	100
		2.1	Тос асгарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч асгаралтыг зогсоон асгарсан тосыг шуурхай цэвэрлэх			
20		3	Гал түймэр	Дотоод нөөц	Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхээр бэлэн байдлыг ханган гал түймэр унтраах тоноглолыг захиалан авч бэлэн байдлыг хангаж ажилласан. 2023 онд БХГ-т талбай болоод түүний орчны бүсэд гарсан 7 тал хээрийн түймрийг үйлдвэрлэлийн баазын зүгээс унтрааж ажилласан.	100
		3.1.	Төслийн талбайд гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах			
21		4.	Хяналтаас гадуурх дэлбэрэлт	Гүйцэтгэлээр	БХГ-т талбайн олборлолтын үйл ажиллагаанд хэрэглэгддэг тэсрэх бодисыг “Бласт Сэлэнгэ”ХХК нийлүүлэн уг бодисын өдөр тутмын ашиглалт, хадгалалтанд хяналт тавьж ажилладаг.	100
		4.1.	Төслийн талбайн аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон тэсрэх бодистой холбоотой журмыг дагаж мөрдөнө.			
	5.	Хүний эрүүл мэнд муудах	Дотоод нөөц		100	

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

22		5.1.	БХГ-т талбайд хүний эрүүл мэнд муудахад үйлдвэрлэлийн баазын эмч тохирох арга хэмжээг авч шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлнэ.		БХГ-т талбайд өдөр тутамд хүний эрүүл мэндийн үзлэгийг үйлдвэрлэлийн баазын эмч үзлэг хийж тохирох эмчилгээг хийдэг бөгөөд гэнэтийн аваар ослын үед хүний эрүүл мэнд муудах яаралтай анхны тусламж үзүүлэн дараагийн шатны эмнэлэгт шилжүүлж ажилладаг.	
23		6.	Автомашины осол гарах	Дотоод нөөц	БХГ-т талбайд үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч ангиудын жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдох дүрэм журмыг танилцуулан сургалт хийж тогтмол хугацаанд тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтуудыг хийж ажилласан.	100
		6.1.	Замын хөдөлгөөний дүрэм тээврийн хэрэгсэл жолоодох шаардлагуудыг биелүүлэх			
24	Долоо. Хог хаягдалын төлөвлөгөөний биелэлт	Ахуйн хог хаягдал		50000	БХГ-т талбай нь хог хаягдалыг ангилан ялгах, давир бүтээгдэхүүнийг нийлүүлэх, булшлах зэрэг үйл ажиллагааг “Матад БЭШН” ХХК-тай гэрээ байгуулан ажиллалаа.	100
25		Үйлдвэрлэлийн хатуу хог хаягдал				
26		Ахуйн шингэн хаягдал		Дотоод нөөц		

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБAYН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

27		Тосоор бохирдсон хөрс	Гүйцэтгэлээр	Газрын тос олборлох үйл ажиллагааны үед технологийн доголдол болон хүний хүчин зүйлийн нөлөөгөөр газрын тос хөрсөнд хаягдан бохирдол үүсгэдэг. Ингэж үүсгэсэн бохирдолыг хусч цэвэрлэн тостой шороо хүлээн авах цэгт буулгадаг. Тосоор бохирдсон шороог хүлээн авах, цэвэршүүлэх ажлыг 2023 онд “Эко Ургамал” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлж байна. 2023 онд 2,700 м.куб бохирдсон шороог тус компанид хүлээлгэн өгч буулгаад байна.	100
28	<b>Найм.</b> Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт	2023 онд БХГэрээт талбайд 3 удаагийн давтамжтайгаар агаар, хөрс, ус, ургамал, амьтан зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдээс дээж авч судалгаа шинжилгээг хийлгэж тайлан гаргах	20000	Газрын тос олборлох үйл ажиллагааны явцад агаар, хөрсөн бүрхэвч, усан орчин, ургамлан нөмрөгт үзүүлж буй сөрөг нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтүүдийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээг төлөвлөх зорилгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Петроцайна дачин тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын зүгээс уг ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн эрх бүхий байгууллага болох “Цавчирын Хөндий” ХХК-тай гэрээ байгуулан хээрийн судалгааг 2023 оны 6, 8, 9 дүгээр саруудад хийж гүйцэтгүүлсэн.	100
29		2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах үүднээс байгаль орчны ажилтны бүтэц орон тоог нэмэгдүүлэх	Дотоод нөөц	2023 онд Байгаль орчны нэг ажилтан ХАБ-н нэг ажилтан нэмэгдсэн.	100
30		Аж ахуй нэгжүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах	Дотоод нөөц	Гэрээт талбайн нийт гэрээлэгч ангиудад хог хаягдлыг ангилан ялгах түүний ач тусын талаар сургалт зохион байгуулсан. Мөн хог хаягдлын менежментийг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн.	100

**БХГЭРЭЭТ XIX ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

31	Ес. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	Гэрээлэгч ангиудын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээ	Дотоод нөөц	Нийт гэрээлэгч ангиудад ногоон байгууламжыг нэмэгдүүлэх талаар сургалт суртчилгаа хийж мод тарих ажилд нь хамтарч ажилласан.	100
32		Замын менежментийг сайжруулах	Дотоод нөөц	БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын удирдлагын зүгээс дотоод нөөц бололцоог дайчлан олборлолтын талбайн технологийн хамгийн их эвдрэлтэй ус тогтдог эвдэрсэн 5 км замд хайрга дэвсэн грейдэрээр тэгшлэн индүүдэж арчилгаа хийж ажилласан.	100
33		ЭМААБО-ны хэлтсийн ажилтнуудыг чадвахжуулах сургалтанд хамруулах	Гүйцэтгэлээр	ЭМААБО хэлтсийн ажилчдыг БОАЖЯамнаас зохион байгуулсан “Хариуцлагатай уул уурхай, Нөхөн сэргээлт, Орчны хяналт шинжилгээ” сэдэвт 15 цагийн сургалтанд хамруулсан.	100
34		Үндсэн болон гэрээлэгч ангиудад байгаль орчны сургалт зохион байгуулах.	Гүйцэтгэлээр	Гэрээт талбайн нийт ажилчдад байгаль орчны сургалт зохион байгуулсан.	100
35		Химийн бодисын зарцуулалтын тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар холбогдох төрийн байгууллагат хүргүүлэх.	Гүйцэтгэлээр	Химийн бодисын зарцуулалтын тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлсэн.	100
36		Дорнод аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах ерөнхий төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллах	Гүйцэтгэлээр	2023 онд БХГ-т Тосон Уул XIX талбайн үйлдвэрлэлийн баазын зүгээс Дорнод аймгийн Онцгой байдлын газраар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ашиглах төлөвлөгөөг” батлуулан мөрдлөг болгон ажилласан.	

**БХГЭРЭЭТ ХИХ ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН – 2023**

37		19-р талбайн Байгаль орчинд нөлөөлөх байдалын үнэлгээ	60000	2023 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг “ЕАСС”ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлэн БОАЖЯ-тай батлуулахаар хүргүүлэн ажиллаж байна.	90
38	<b>Арав.</b> Олон нийтэд тайлагнах хуваарь	Дэлхийн усны өдөрт зориулан Буйр нуур Мэнэнгийн талын сав газартай хамтарсан ажил зохион байгуулах.	Гүйцэтгэлээр	Дэлхий нийтээрээ жил бүрийн 3 дугаар сарын 22-нд “УСНЫ ӨДӨР”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Дэлхийн усны өдрийг угтан “Петрочайна Дачин Тамсаг” ХХК нь Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаатай хамтран Матад сумын нутгийн иргэдэд усны үнэ цэнэ, усны нөөцийн хэрэглээ, ашиглалтын өнөөгийн байдал, усны нөөцөө хамгийн ухаалгаар хамгаалж, зүй зохистой ашиглах талаар мэдээлэл өгч, хамтран ажиллаа.	100
39		2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл болоод 2024 оны БОМТ-г орон нутгийн иргэдэд танилцуулах.	Гүйцэтгэлээр	Дорнод аймгийн матад сумын соёлын төвд нийт иргэдэд 2023 оны 6 сарын 11ний өдөр БОМТ-г танилцуулсан. Мөн нөлөөллийн бүсийн оршин суугчдад 2023 оны 6 сарын 12ны өдөр БОМТ-г танилцуулан мэдээ мэдээлэл өгч хамтарч ажилласан.	100
40		2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний явцыг орон нутгийн иргэдэд газар дээр нь танилцуулах.	Гүйцэтгэлээр	БОМТ-нд тусгагдсан Дүйцүүлэн хамгаалалын ажлын хүрэнд Матад сумын Засаг дарга болон иргэдийн төлөөллийг талбай дээр авчран хийгдэж буй ажлын явцыг танилцуулсан. Мөн Матад сумын ЕБС-ын төгсөх ангийн сурагчдыг 2023 оны 10 сарын 4 ний өдөр төслийн талбай дээр авчран БОМТ-т тусгагдсан ажлуудын явцыг танилцуулан байгаль орчныг хамгаалах талаар мэдээ мэдээлэл өгч хамтран ажилласан.	95
41		Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг орон комист танилцуулан хийгдсэн ажлуудыг хүлээлгэн өгөх.	Гүйцэтгэлээр	Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг БХГ-т талбайд ажиллаж БОМТ-нд тусгагдсан ажлуудыг хүлээн авч үнэлэлт дүгнэлт гаргана.	100
<b>Нийт</b>					<b>99</b>

### ДҮГНЭЛТ

Манай компани үйл ажиллагаагаа эхлэсэн цагаас Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлэн ажиллахын зэрэгцээ жил бүр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зориулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн байгаль орчинтой холбоотой ажлыг үр дүнтэй байдлаар зохион байгуулахыг зорилгоо болгон ажиллаж ирсэн. 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгжүүдийг тендерээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан хийж гүйцэтгүүлсэн. “Петрочайна дачин тамсаг” ХХК-ний БХГ-т Тосон Уул XIX талбайн 2023 оны БОМТ-нд нийт 41 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ба тухайн ажил бүрэн хийгдсэн тохиолдолд 100 оноо, харин тухайн ажил хамааралгүй тохиолдолд оноонд тооцохгүйгээр нийлбэр дүнг тооцон гарган хувилж дүгнэсэн. Уг 41 ажлаас (Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт) гэсэн 2 ажил хийгдэх шаардлага гараагүй тул хамааралгүй гэж авч үзэж үлдсэн 41 ажлын гүйцэтгэлийг 1-100 оноогоор дүгнэж үзэхэд гүйцэтгэл 99 хувьтай гарсан болно.